



ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ

2006

Сэтгүүлийн зөвлөл:

Д.Лүндээжанцан (эрхлэгч)
О.Амархүү (ерөнхий редактор)

Гишүүд: Ж.Болдбаатар
Г.Совд
Ч.Энхбаатар
Н.Лүндэндорж
Б.Мандахбилэг
Н.Батболд (нарийн бичгийн дарга)

РЕДАКЦИЙН ХАЯГ: Сүхбаатар дүүрэг 6 дугаар хороо,
Их сургуулийн гудамж, Шихихутуг ХЗДС-ийн
хичээлийн I байр.

Web site: www.shihihutug.edu.mn

E-mail: shikhi_setguul@yahoo.com







Утас: 314977

91181909


99150269

ЭВЭ ДУГААРТ



ОНОЛ АРГА ЗҮҮ, ТҮҮХ, УЛАМЖЛАЛ, СОЕЛ ИРГЭНШИЛ:

- ◎ ЭЗЭН БОГА ЧИНГИС ХААНЫ ТҮҮХЭН ТАВАН ТАВЪЯА
И.Дашням 3 | 
- ◎ МОНГОЛЫН ТӨР, ХУУЛЬ ЦААЗНЫ СЭЦЭН БИЛЭГТ ЗҮТГЭЛТЭН
Ж.Болдбаатар 13 | 
- ◎ ИЛ ХААН АРГУН, ӨЛЗИЙТ НАРААС 1289, 1305 ОНД 100 ФИЛИППТ ИЛГЭЭСЭН
ЗАХИДАЛУУД ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ
Д.Лүндээжанцан 27 | 
- ◎ МОНГОЛД ТАЗРЫГ ХУВЬД ӨМЧИЛЖ БАЙСАН ЭСЭХ ТАЛААРХИ ТҮҮХЭН МАРТААН,
ТҮҮНД ХИЙСЭН ТҮҮХ, ФИЛОСОФИ, ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ
Н.Лүндэндорж 37 | 
- ◎ ИРГЭНИЙ ХЭРЭГТ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ХУУЛИУДЫН ХӨГЖИЙН ТОЙМ
С.Энхбаяр 59 | 
- ◎ АЖ ҮЙЛДЭЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРТОНЦ ДЭХЬ СИНДИКАТИЙН ОРОН ЗАЙ,
НИЙТМИЙН ХОР АЮУЛ
Б.Намсрай 74 | 


ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮҮ

- ◎ ГЭМТ ХЭРЭГТ ҮЙЛДСЭН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ АСУУДАЛ
Ц.Цэлмэг 81 | 

ҮЗЭЛ БОДОЛ, ЧӨЛӨӨТ НУУДАС:

- ◎ ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ: МОДЕРН БА ПОСТМОДЕРН ХАНДАГА
(ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ЕРӨНХИЙ ОНОЛЫН АСУУДААЛ)
М.Батсуурь 93 | 
- ◎ МОНГОЛЫН НУУЦ ТӨВЧӨӨН ДАХЬ "ЗАСАГ" ХЭМЭЭХ
ҮГИЙН ТУХАЙД
Ч.Өнөрбаяр 105 | 

ХУУЛЬЧИЙН ХӨРӨГ

- ◎ "ЭЦЭГТ ЭХИЙНХЭЭ СЭТГЭЛД ХҮРСЭН ҮРТЭЛЖЭЛЭ НЬ БАЙХ ЮМСАН"
Ц.Ундармаа 114 | 

ХУУЛЬЧ ЗӨВЛӨЖ БАЙНА

- ◎ ХААГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТИШҮҮН ГЭЖ ХЭН БЭ?
◎ ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ
М.Алтан-Өлзий 120 | 

ШИХИХУТУГ СУРГУУЛИЙН МЭДЭЭЛЭЛ

- ◎ О.АМАРХҮҮ БАТШ ТАВЪЯАТ ЦОЛ ХҮРТЭВ
◎ ШИХИХУТУГИЙН ХӨШӨӨ СҮНДЭРЛЭЭЭ 127 | 

ШИНЭ НОМ

135 | 

ЭЗЭН БОГД ЧИНГИС ХААНЫ ТҮҮХЭН ТАВАН ГАВЪЯА

*Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
профессор, түүхч И.Дашцэцм*

Чингис бол дэлхийн талыг хамарсан Монголын Эзэнт гүрний хаан, дэлхийн хэмжээний аугаа их хүн. Тэрээр XIII зууны эхэн үеэс хүн төрөлхтний анхааралд өртөж, эрдэмтэд, судлаачид, түүхчид түүний түүхэн их хувь заяаг янз бүрийн чиглэл, арга хэлбэрээр тодорхойлон бичиж ирсэн, одоо ч бичсээр буй.

Дэлхий дахинаа Чингис хааны талаар эсрэг тэсрэг хоёр үзэл, хоёр сурталчилгаа явагдаж иржээ. Философийн ухааны доктор Даш-Ёндон томоохон оршил бичиж, орчуулсан “Суут богд Чингис хааны түүхэн гавъяа” ном 2003 онд Софи хотноо хэвлэгдсэн. Оршил хэсэгт “Дэлхий дахинаа Чингис хааны тухайд эсрэг тэсрэг хоёр үзэл, хоёр сурталчилгаа буй. Сөрөг тал нь ихэд газар авч давамгайлах байдалтай болсон. Энэ сөрөг тал нь Чингис хаан, түүнийг залгамжлагчдад эзлэгдэж, ялагдаж байсан угсаа овогнуудын дундаас гарсан үлгэр, домог, түүхэн өгүүлэл, ном, зохиолуудад голлон тулгуурладаг. Ялагдсан болохоор олонхи нь сайнаар хэлэхгүй нь лав. Харин ялагдагсад нь маш олон ажгуу” гэж бичжээ. Чингис хаан бол утга учиргүй дайн хийж, олон улс орныг хүчирхийлэн эзэлж, хүн амыг нь алж хөнөөн, хот суурин, барилга байгууламжийг нь үнсэн товрог болгон устгаж, соёлын асар их үнэт дурсгалыг эвдэн бусниулсан харгис хүн, түүний толгойлсон Монголын Эзэнт гүрэн дайнч, эзэрхэг улс байсан хэмээн нотолж бичих нь сөрөг үзэл, сурталчилгааны гол утга санаа юм. Үүнээс үүдэн Чингис хаан түүхэнд харгис роль гүйцэтгэсэн хүн хэмээх үзэл бий болж, ялангуяа социализмын үеийн Орос, Хятад, Монголд XX зууны эхнээс эцэс хүртлэх хугацаанд ийм үзэл нэлээд гүн ноёрхож байв. Чингис хааны Олгий нутаг болох Монгол оронд социалист онол, үзэл ноёрхож байсан цаг үед



/1930-аад оны эхнээс 1990-ээд оны эхэн/ Чингис хааны судалгаа, сурталчилгаа хаалттай байсан билээ. 1965 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын түүх” зохиолын I дүгээр ботид “Чингис хаан [21] оноос эхлэн бусдын газар орныг булаан дээрэмдэх дайныг өргөн хэмжээгээр явуулсан бөгөөд чухамхүү тэр үеэс эхлэн Чингисийн үйл ажиллагаа эрс харгис шинж чанартай болсон юм. Чингис тэргүүтэй Монголын байлдан дагуулагчдын дээрмийн дайн нь Ази, Европын ард түмэнд цаглашгүй их үхэл гамшиг, эвдрэл сүйдлийг учруулж, түүхийн үнэлж баршгүй хосгүй нандин зүйлийг сүйтгэн, тэдгээр орны хөгжлийг асар ихээр хойш татсан юм”¹ гэж бичсэн нь тэр үед ноёрхож байсан үзэл сурталчилгааны илэрхийлэл мөн. Социализмын онолч К.Маркс монголын байлдан дагуулагчид “явсан газар бүхнээ ээрэм цөл болгож, үржилт нутаг, хүн суусан тосгон сууринг үнсэн товрог болгож хувиргасан” гэж “Оросын дипломатын нууцууд” гэсэн бүтээлдээ бичсэн байдаг.

Оросын эрдэмтэн И.П.Петрушевский “XIII-XIV зууны Иран дахь газар эзэмшил ба газрын харилцаа” зохиолдоо “Алж хядах зохион байгуулалттай системийг дээрээс Чингисийн шууд зарлигаар явуулжээ. Энэхүү систем нь Монголын ба тэдэнтэй нийлсэн Түрэг нүүдэлчин аймгуудын язгууртан нарын сэтгэл санаанд нийлжээ. Учир нь гэвэл тэр систем зөвхөн эсэргүүцлийг дарж, зөвхөн толгой дараалан дээрэмдэхийг дөхөм болгож, тэр дээрэмдлэгийг язгууртан нарын ашиг тусын тулд илүү зохион байгуулалттай болгосон төдийгүй, аян дайнд дайчлагдсан жирийн нүүдэлчдийг агтлан барьж байхад ч хэрэглэжээ”² гэж бичжээ. Иймэрхүү дүгнэлт бичлэг дорнын ба өрнийн орнуудын олон ном, зохиолд дурдагдсан байдаг билээ.

Ялангуяа Чингисийн аян дайнд эзлэгдэн нэрвэгдэж байсан улс орнуудын түүх шастир, ном зохиолд илүү түлхүү бичигдэж ирсэн байна. Энд юуны түрүүнд Чингисийн явуулсан аян дайнд үнэлэлт өгөхдөө харгалзан үзвэл зохих нэгэн учир шалтгаан бий. Энэ бол Чингис ямар ч улс орон, хот, сууринтай байлдахдаа өөрөө эхэлж дайсагнах санаачлага гаргадаггүй, эхлээд эвийн аргаар зохицон эвтэй найртай амьдрах, өөртөө захирагдаж алба төлөх эрхшээлдээ сайн дураар орохыг шаарддаг төдийгүй, дайтах нь зөв эсэх, хэрэв дайтвал ямар стратеги, тактикаар байлдахыг Их хуралдай, Сэцэдийн

¹ БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ., 1966. 241-р талд

² Петрушевский И.П. Земледелие и аграрные отношения в Иране



зөвлөлөөр хэлэлцэн дүгнэлт гаргуулж түүнийг нь тунгаан болгоодог байсан нь “хууль” байжээ. Энэ нь уг аян, байлдааныг гэнэтийн бус, аль аль талдаа бодох, бодит ухаалаг шийдвэр гаргах бололцоо олгодог байсныг бодолцох нь зүйтэй юм. Чингис хаан, түүний жанжинууд энэ өндөр ёс зүйгээ хатуу мөрдөж байснаар олон улс орон дагаж орж, хүн ам, уугуул соёлоо хамгаалж байсан түүхтэй. Чингис хаан, түүнийг залгамжлагчид Тангуд улс, Алтан улс, Сүн улс, Хорезмын улсад аян дайн хийх үү, хийхгүй юм гэдгийг Монголын Нэгдсэн улсын Их Хуралдайгаар заавал хэлэлцүүлж байсан билээ. Японы эрдэмтэн Ш.Иванмура, Т.Кацуфума нар <<Их Монголын эзэнт улс>> бүтээлдээ, Чингис хааны Хорезмын гүрэнтэй дайтах болсон нь <<Хорезмын улс Чингисийн худалдаачдыг алж, элчийг нь дараалан буцаасан явдал гол шалтгаан болсон юм. Чингис хаан уг нь Хорезруу дайтах шаардлаггүй байсан юм>>³ гэж бичсэн байдаг. Үнэндээ Чингис хаан Хорезмын шах Мухамедад 3 удаа илчээ илгээж худалдааны харилцаа тогтоохыг оролдсон боловч энэ нь түүний санаснаар болоогүй билээ.⁴

Дорно Орнийн улс орнуудад Чингис хааны явуулсан аян дайнд одоогийн Хятад, Орос, Иран, Ирак, Турк, Болгар, Армян, Азербайджан, Туркстан, Узбекистан, Таджикстан, Укриан, Беларусь, Гүрж зэрэг Ази, Европын олон улс орны нутаг, дэвсгэр, тэдгээрт оршиж байсан том, жижиг улсууд эзлэгдэж, олон хот суурин, сүм хийдүүд эвдрэн сүйрч, мөн олон зуун мянган хүн амь насаа алдсан билээ. Энэ аян дайнд ялсан Монгол Улс ч үлэмж их хохирол амсжээ. Аливаа дайн бүр их, бага ямар нэг хэмжээгээр хүний амийг авч, эвдрэл, сүйтгэл, зовлон гуниг учруулдаг уршигтай. Чингис хааны удирдан Дорно, Орнийн улсуудад явуулсан дайн хэмжээ далайцын хувьд асар том дайн байсан болохоор учруулсан хохирол нь ч бас их байсан байж таарна.

Тийм том аян дайныг Монголын нэгдсэн улсын их хаан Есүхэйн Чингис удирдаж ялалтад хүргэсэн нь дэлхий дахины хэмжээний том үйл явдал мон. Тэрээр хэдийгээр аян дайн хийж, их гарз хохирол учруулсан нь харамсалтай ч дайныг чадварлаг удирдаж ялалтад хүргэсэн нь эл хувь хүний гоц чадвар,

³ Иванмура Шинобу, Кацуфуми Такэши. Их Монголы эзэнт улс. 12-р талд

⁴ Янай Ватару. Монголчуудын түүхэн судалгаа. Токно, 1970, 230-р тал.



агуу авьяас билэг, гайхамшигт суу билэгийг дэлхий дахинаа үзүүлсийг анхаарах нь зүйтэй.

Чингис хааны байгуулсан гавъяа, бүтээсэн сайн үйлс нь шүүмжлэгдэх, муучлагдах зүйлээсээ үлэмж давууг эрдэмтэд, судлаачид судлан тодорхойлсон нь нэлээд бий. Одгөө энэ нь Чингис судлалын бие даасан том чиглэл болж улам бүр хүчээ авсаар байна.

Академич Ш.Нацагдорж “Оөрийг нь төрүүлсэн цаг үеийн бүхий л шинжийг агуулсан Чингисийг түүхчид болон улс төрийн зүтгэлтнүүд, зарим хэсэг нь хараан зүхэж, зарим нь түүнийг шагшин магтаж биширдэг юм. Хэдийгээр ийм олон зүйл санал дүгнэлт байдаг боловч эцсийн эцэст Чингис бол дахин давтагдашгүй, ер бусын цорын ганц хувь заяатай, түүхэнд тэмдэглэгдсэн суут хүн мөн гэдэг талаар санал нэгддэг байна. Тийнхүү үзбээс Чингис бол төрийн гарамгай зүтгэлтэн, суут жанжин, Монгол угсаатны үндэсний баатар мөн”⁵ гэж бичсэн байдаг.

Энэтхэгийн төрийн агуу их зүтгэлтэн Джавхарлал Неру “Тухайн үед Монголчууд тооны олноор биш, харин сахилга, зохион байгуулалттай байсныхаа хүчинд тулалдааны талбарт их ялалт хийж байжээ. Бас Чингисийн цэргийн жанжины гайхамшигт урлагийн хүчээр тэд ийнхүү ялалт байгуулж чадсан байна” гэж өгүүлжээ. Чингис хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг олон орны эрдэмтэд, тухайлбал Ираны Рашид-ад-Дин, Египетийн Макриз, Армяны Д.Оссон, Английн Гарольд Дэмбэ, Х.Ховорс, Ж.Саундерс, Жек Редофорд Германы Краузе, Францын Рене Гуссе, Фернан Гренар, Оросын В.В.Бартольд, Б.Я. Владимирцов, Н.Ренрих, Л.Н.Гумилев, Буриадын Ш.Р.Цыденжапов, Халимагийн Эрэнджен хара Даван, Монголын Ч.Далай, Ш.Нацагдорж, Н.Ишжамц, М.Санждорж, Хятадын Чжоу Яотин, Сайшаал, Японы Ивамура Шинобу, Вада Сей зэрэг олон нэрт хүмүүс судлан үнэлгээ дүгнэлт өгсөн байдаг.

Чингисийн удам, үйл ажиллагаа, хүмүүнлэг чанар, үйл хэргийг түүхэн баримтаар эерэг байдлаар нотлон өгүүлсэн “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган” хэмээх зохиолуудын дүгнэлт, үнэлэлтийг ч бид сайтар тунгаан бодох ёстой билээ. Эдгээр бүтээл дэх баримт, мэдээлэл нь их хааны

⁵ Ш.Нацагдорж. Чингис хааны цаг. УБ., 1991. 312-р тал



үед амьдарч байсан бүх цаг хугацаа, ахуй амьдралын халуун тогоон дотор байсан гэгээнтэн мэргэд бичсэний учир хамгийн бодитой, үнэтэйд тооцох магадлал төгс бөлгөө.

Чингээд бид их хаан эзэн богд Чингисийн түүхэнд эзлэх байр, байгуулсан үнэн гавьяаг товч боловч нэгтгэн дүгнэн тодорхойлон гаргах гэгээнлэг зорилго тавьж, зөвхөн энэ л талаар өгүүлэхийг хичээв. Бүгдийг төгс сайн боловсруулах бичихэд авьяас билэг мөхөсдох хэднй ч үүнийг цааш цааш нь үргэлжлүүлэн гүйцээхийг хойч үедээ найдах нь баттай хэмээн үзэх үндэслэл буй билээ. Их Чингис хааны үнэн гавьяаг дараах хэдэн үндэслэлээр товч тодорхойлон өгүүлье.

Нэг. Чингис хаан бол Монгол үндэстний нэгдмэл улсыг үндэслэн байгуулсан их гавьяатай. Тэрээр Монгол угсааны аймгуудыг нийтэд нь нэгтгэн нэгэн цул нэгдмэл улсыг байгуулах үйлсийг удирдаж, үүнд амьдралынхаа 20 гаруй жилийг зориулан хатуужиж, Монголчуудын “яс” удирдагчаар товойн тодорч, өөрийгөө Монгол овогтондоо бүрнээ нээн харуулж, тэдний итгэлийг хүлээсэн агуу хүн байв.

Чингис хаан Монголын нэгдсэн улсыг өөрийн суу үзэл номнол, хол ч боллого, хатан зориг, эрдэм ухаан, хүч чадал, эрэмгий үйл ажиллагаагаараа цогцлон байгуулж чадсан нь Монголчуудын түүхнээ тохиосон агуу том гайхамшигт үйл явдал байсан ажгуу.

Чингис хааны энэ л гавьяагаар Монгол аймгууд нэгдэж “Монгол Улс” хэмээсэн төв азийн хүчирхэг улс болж, түүхнээ мөнхрөх хувь заяа эдэлсэн бөлгөө.

“Нэгдсэн улс байгуулагдсаны үрээр монголчууд Алтан улсын хараат байдлаас бүр мөсөн ангижирч, харийн довтлогчдоос нэг монгол аймгийг нөгөөгийн нь эсрэг ашиглан түрэмгийлэх явдлыг эцэс болгожээ. Монгол улс байгуулагдсанаар тус орны өөрийгөө хамгаалах хүчин өсөн нэмэгдэж, энэ үеэс монголчууд дэлхийн түүхийн тавцанд бие даан гарч ирсэн юм”⁶ /54-104/ гэж 2003 онд хэвлэгдсэн “Монгол улсын түүх” таван боть зохиолын дэд ботид бичигдсэнийг анхааран болгоовол зохионо.

⁶ Монгол улсын түүх. Дэд боть. УБ., 2003. 104-р тал



Хоёр. Чингис хаан Монгол үндэстнийг бүрэлдүүлж төлөвшүүлсэн ачтан болой. Монгол овогтон 81 аймгийг нэгтгэж, нэгэн угсаа, нэгэн хэл, амьдралын нийтлэг хэв маяг, соёл, зан заншил, ёс суртахуун, газар нутаг бүхий “Монгол” гэсэн нэртэй бүхэл бүтэн үндэстнийг бүрэлдүүлж бий болгосон нь их хааны аугаа том гавъяа мөн.

Чингисийг судлаач Францын нэрт эрдэмтэн Фернан Гренар 1935 онд туурвиж дуусгасан “Чингис хаан” хэмээх 10 бүлэг бүхий томоохон зохиолдоо “Чингис хаан бол Монгол ард түмний зэр зэвсэг биш, харин Монгол ард түмнийг бүтээж бий болгогч юм. Чингис хаан хүч чадлаа бэхжүүлэхийн тулд өвөр хоорондын тэмцэлдээ идэгдэн, хүчээ шавхан барж, жам ёсны нийтлэг мэдрэмжээ алдсан тархай бутархай аймгуудад найдан тулгуурлах аргагүй байсан юм. Тэдгээрийг нэгтгэн захирахын тулд гаргасан шиг тийм их хүч зүтгэлийг Чингис хаан өөр юунд ч, хэзээ ч гаргаагүй билээ. “Монгол” гэдэг ойлголт монгол хэлээр ярьдаг бүхнийг багтааж байгаагүй учраас тэр юм”⁷ гэж яруу тод бичсэн байдаг.

Монгол үндэстэн бүрэлдсэн нь асар нарийн үйл явц, маш хүчтэй бодлого, үйл ажиллагаа байсан тодорхой.

“Чингисийн байгуулсан Монголын тулгар төр моголчуудыг нэгдмэл нэгэн үндэстэн болгож, бүрэлдүүлсэн юм. Үндэстэн бол капитализмын бүтээгдэхүүн гэдэг онол яав ч Монголын нөхцөлд таарахгүй. Хэрэв монголчууд тэр үед үндэстэн болж бүрэлдэж чадаагүй бол тухайн үед мэдэгдэж байсан дэлхий дахины гуравны хоёрыг эзэлж даян дэлхийг хамарсан эзэнт гүрэн байгуулж чадахгүй. Манж-Хятадын 200 гаруй жилийн эзэгнэл, дарлалыг тэсэж давж чадахгүй.”⁸ гэж тодорхойлсонтой санал нэг байна. Монгол үндэстэн бол Чингис хааны аугаа том бүтээл, монголчуудад үлдээж өвлүүлсэн юугаар ч үл сольж болох хамгийн үнэт эрдэнэ мөн.

Гурав. Чингис хаан, Монголын нэгдсэн улсыг дэлхийн их гүрэн болгож, бас өөрөө ч дэлхий дахинаа алдаршсан түүхэн хувь хүн болой. “Монголын тулгар төрийг төдийгүй дэлхийн талыг хамарсан Монголын их эзэнт гүрнийг байгуулснаараа тэрээр дэлхий дахины ач холбогдолтой төр улсын агуу их

⁷ Суут болг Чингис хааны түүхэн галия. Софи, 2003, 12-13-р тал.

⁸ Суут болг Чингис хааны түүхэн галия. Софи, 2003, 12-р тал.



зүтгэлтэн болсон юм. Тэрээр их хуульч, сайн сэтгэл зүйч, өвөрмөц маягийн бодлогтон, түмэн олондоо ойр дотно байдаг монгол төрийн уугуул зүтгэлтэн, үлэмжийн их зохион байгуулагч байжээ. Цааш цаашдаа ч хүн төрөлхтөн түүнийг үүнээс доогуур үнэлэх аргагүй юм.”

Чингис хаан Ази, Европын олон улс орныг байлдан дагуулж их ялалтад хүрсэн нь “ээлэн ноёрхсон” гэх утгаар нь бус “яагаад ямагт ялалт байгуулаад байв” гэдэг талаас нь авч үзбээс аугаа их авьяас билэг, тэсвэр тэвчээр, ур чадвар, ухаан бодол, хүч чадал зарж байж, тэр олон орны өөрөөсөө илт олон цэрэгтэй, олон олон алдар түүхтэй хаад, сүр хүчит жанжинуудтай халз тулалдаж ялсан тийм их чадвар Чингист байжээ гэдгийг харуулж байгаа жинхэнэ бодит үнэн мөн юм.

Чухам XIII зууны 40-өөд оны Ираны /Перс/ түүхч Жувейний “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” алдарт зохиолд “Бүгдийг тольдогч тэнгэрээс Чингис хааныг олноос оройлсон оюун чадвартай, үзэл санааны хурц сэргэлэн, эрч хүчний хязгааргүй талаар дэлхий дахины олон хаан, ван нарын манлай болгожээ... Бусад улсыг дайлан дагуулах арга бодлого, дайсан цэргийг устгах ба харъяат нараа дэвшүүлэх арга зэрэг нь бас ч бүр түүний өөрийнх нь сэргж ухсан үрдүн мөн бөгөөд оюун чадварынх нь цараа болох юм. Үнэнийг хэлэхэд тэрхүү арга бодлогодоо чадамгай, дайснаа ажихдаа сахиус мэт гэдэг алдартай Александр хэрэв Чингис хааны үед амьд мэнд байсан бол арга сүвэгчилж, бодлого хэрэглэх талаар Чингис хааны сурагч нь болох бөгөөд хот балгасыг довтлох зүйл бүрийн уран аргын талаар Чингис хааныг үг дуугүйгээр дагаж хийвэл дээр гэдгийгээ тэр лав олж мэдэх байсан байх” гэж бичсэн нь Чингис хааны эзэнт гүрнийг байгуулсан “авьяас билэг, суу чадвар” үнэхээр аугаа болохын нэгэн нотолгоо биз ээ.

Чингис хааны ухаан бодол, авьяас чадвар л Умарт Хятад, Тангуд, Түвд, Иран, Дундат Ази, Орос, Европын олон орныг харъяалан захирсан Монголын эзэнт гүрэн тогтоход хүргэжээ гэж хэлэх хэрэгтэй болов уу.

Бодит баримтыг түших юм бол Чингис хаанд ялагдсан Тангуд, Алтан, Сүн улс, Хорезмын эзэнт гүрэн, Дундат Ази, Оросын вант улсууд, европын хаант улсуудын хаад, цэргийн жанжинууд бол тэр л үеийнхээ алдар цуутай,

* Мөн ном. 5-6-р талд



авъяас билэгтэй хувь хүмүүс шүү дээ. Тэхлээр тэдэнтэй өрсөлдөж, тэднийг ялна гэдэг тийм ч амар хялбар биш, агуу их гүн утга учиртай гэдэг нь ойлгомжтой. Тэгэхдээ Чингис тэднийг ялсан нь түүхэн үнэн болохоор түүний тэр л их суу билэгийг хүлээн зөвшөөрөх нь гарцаагүй болов уу.

Доров. Чингис хаан Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн үзэл, онолыг боловсруулан хэрэглэсэн суут ухаантай болно. Хамаг Монголыг сэргээн босгож, Монгол нэгдсэн улсыг байгуулах үзэл баримтлалыг Чингис хаан тэргүүлэн боловсруулсныг түүх гэрчилж байна. Энэ тухай дорвитой судлаагүй боловч тэрээр хамтран зүтгэгчдийнхээ хамтаар ийм үзэл баримтлалаа боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлсэн нь үнэнхүү түүний оюун ухааны их авъяас билгийн үр дүн мөн юм. Бодит үр дүн нь Хамаг Монгол, Монголын нэгдсэн улс байгуулагдан оршин тогтнож байсан түүхэн үнэн өөрөө мөн.

Чингис хаан оюун ухааны хурц чадвартай, юмыг олон өнцгөөс нь сэтгэж чаддаг, бас хэрэгтэй бол бие сэтгэлээ барьж чаддаг, эрдэмтэн мэргэдээс үндэс угсаа харгалзахгүйгээр байнга суралцахыг хичээнгүйлэн зүтгэдэг, Монгол улсын бие даасан байдлыг яс, махан утгаараа ямагт хамгаалан тэмцдэг, эх орноо, хүн ардаа барс мэт өмөөрдөг, үзэл бодолдоо ямагт үнэнч, шулуун шударга, эрс шийдэмгий зан чанар, бодол санаа нь дээрхи үзэл баримтлалыг боловсруулах хөрс суурь болсон ажгуу. Чингис хааны төр, эрх зүйн үзэл онолын цөм агуулга нь Монгол улс ямар ч улсаас хараат бус бие даасан улс байх, хэмжээгүй эрхт хаант засаг тогтох, Засгийн газар, Яамгүйгээр зөвхөн төрийн сайд, түшмэдээр дамжуулан төрийнхөө удирдлагыг /гүйцэтгэх засаглалыг/ хэрэгжүүлэх, шударга шүүх, хууль цаазтай байх, аравтлах тогтолцоонд үндэслэсэн төрийн байгууламжийг бий болгох, бүх ард нийтэд эрх тэгш байх дуртай шашнаа сонгон шүтэх эрх олгох, гадаад улс орнуудтай худалдаа арилжааг чөлөөтэй хийх, бас өөр хоорондоо өргөн дэлгэр харилцах, бие биенээ үнэнхүү хүндэтгэхэд оршиж байжээ. Эл үзэл онолын агуулгыг тодорхойлогч үзэл баримтлал нь бэлчээрийн мал сүргээ даган нүүдэллэж амьдардаг монгол маягт тохирч түүнд зохицсон байснаараа онцлог болой. Энэ бол Монгол соёлын эрхэмсэг нэгэн хэсэг мөн. Тэр их соёлыг Чингис хаан бүтээж, залгамжлагчид нь хөгжүүлсэн юм.



Тав. Чингисийн гавьяат үйлсэд түүний дэлхий дахинаа алдаршсан цэргийн жанжин, монголын нэгдсэн улсын цэргийн урлагийг үндэслэн бий болгосон явдал орох нь лавтай. Монголын нэгдсэн улс байгуулагдан улмаар дэлхийн цэргийн их гүрэн болсон хийгээд Ази, Европыг дамнасан их аян дайнд ялсны гол нууц нь Монгол цэргийн их урлаг, монгол цэргийн жанжин, монгол цэргүүдийн өөрийн хэмээсэн байлдах өндөр ур чадвар, тулалдах хатан зориг тэвчээр, амьдралын арвин баялаг арга ухаанд оршиж байсан хэмээн үзэх үндэслэл бүрэн буй.

Үүний нотолгоо болгохын үүднээс хэд хэдэн ишлэлийг тунгаан үзье. Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов “Чингис бол зөвхөн туршлагатай мэргэн жолоодогч, дайн тулалдааны зоригтой авъяаслаг удирдагч төдийгүй мөн гайхамшигтай стратегич, арми ба түүний салбар ангиудын дайны үйл ажиллагаа болон маневруудын удирдагч болохоо харуулсан юм.¹⁰ гэсэн дүгнэлт хийсэн бол Английн эрдэмтэн Ж.Ж.Саундерс “Тухайн үеийн анхны том жанжин байсны хувьд Чингис хааны авъяас чадал нь зөвхөн гайхамшигтай нээлтүүд төдийгүй тэр үед ч байсан практик амьдралыг өөрийн болгон өөрчилж сайжруулахад ер бусын авъяас чадлаа харуулснаар тодорсон ажээ”¹¹ хэмээн өгүүлсэн нь бий. Хятадын их түүхч Сайшаал “Чингис хаан бол Монгол үндэстний түүхэн дэх шалгарсан гарамгай цэрэг дайны зүтгэлтэн болно. Чингис хаантай адил их түншвээ ер байгаагүй”¹² гэж бичжээ.

Чингис хаан Монгол цэргийн нэр цуут армийг гардан бүрдүүлж, монгол цэргүүдийг цэргийн эрдэмд сургаж, ялагдашгүй их хүчирхэг армийг тэргүүлж ирсэн суут жанжин мөнөөс мөн. Нүүдлийн соёл иргэншилтэй улс орон, тэр тусмаа Төв Азийн нүүдэлчин Монгол үндэстний эрэлхэг зоригт армийг төрүүлж, тулалдаан бүхэнд ялж нэр цуугаа мандуулсан алдар төгс цэрэг эрсийг бэлтгэж ирсэн түүхэн гавьяаг дотоод, гадаадын нэрт эрдэмтэд өндөр үнэлсэн нь олонтой. Монголын Академич Ш.Нацагдорж “Чингисийн гавьяа бол нүүдэлчдийн цэргийн эрдэм боловсролыг төгс төгөлдөрийн туйл болгон дээд шатанд гаргаж баяжуулан, цэргийн ухааныг жинхэнэ ёсоор бүрэлдүүлэн бий

¹⁰ Владимирцов Б.Я. Чингис хаан. М., 1922.

¹¹ Саундерс Ж.Ж. Монголын байлдан дагуулал. УБ., 1992.

¹² Сайшаал. Чингис хааны товчоон. Тэргүүн дэвтэр. УБ., 2003. 276-277-р тал.



болгосонд оршино”¹³ хэмээн бичсэн байдаг билээ. Хятадын Мин улсын сүүлч Чин Улсын эхэн үеийн их эрдэмтэн Гү Зо Юу “Би Монголын цэрэг хэрэглэх аргыг шинжиж үзэв. Монголын цэрэг улирч хувирах, урагшлан довтолох нь гайхалтай гэнэт үзэгдэж гэнэдүүлэн дайрахдаа чадамгай. Цэргүүдийн сэтгэл ганц хүн мэт.... Иймээс Монголын дайны арга бодлого нь эрт өнгөрсөн лугаа харьцуулбал хамгийн дээдэд очно”¹⁴ гэж бичсэнийг Ш.Нацагдорж номондоо зориуд иш татсан явдал жирийн нэгэн илэрхийлэл бус сайтар судалсан мэргэн оюуны үр шим байж таарна. Итгэл, үнэмшил олохын үүднээс Орос орны их түүхч Монгол судлаач Г.В.Вернадскийн “Чингисийн үеийн монголчууд ба Орос улс” хэмээх зохиолоос нэгэн багц дүгнэлтийг иш татая л даа. Тэрээр “XIII зууны Монгол арми бол тэр үеийн дэлхий дахины хамгийн шилдэг арми байсан нь ямар ч эргэлзээгүй. Энэ морьт арми нь бас хэрэм боомт эвдэх инженерийн ангитай байжээ”¹⁵ гэсэн байдаг билээ. Монголын хүчирхэг армийн ерөнхий командлагч их эзэн Чингис хааны арга ухааныг төгс мэдрэн эзэмшиж, өвлөн залгамжлагч, ялан дийлэгч олон нэрт жанжин төрж бойжисны дотор Чингисийн өөрийн нь үеийн алдар цуут жанжингуудаас Зэв, Сүбээдэй, Зүчи, Тулуй зэрэг суу билэгт жанжинуудыг түүх андахгүй болгөө.

¹³ Нацагдорж Ш. Чингис хааны цагиг. УБ., 1991, 213-р тал.

¹⁴ Ш.Нацагдорж. Дээр дурдсан номын мөнхүү талд

¹⁵ Вернадский Г.В. Чингисийн үеийн монголчууд ба Орос улс. УБ., 1994.



МОНГОЛЫН ТӨР, ХУУЛЬ ЦААЗНЫ СЭЦЭН БИЛЭГТ ЗҮТГЭЛТЭН

Академик Ж.Болдбаатар

Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн түүхт ойн жил Монголын төр, хууль цаазны үлэмж гарамгай зүтгэлтэн Шихихутугийн тухай сайхь зүтгэлтнээр овоглосон сургуулийнхан дурсахгүй байх аргагүй.

1206 оны намар Онон мөрний эхэнд Монгол ноёдын их чуулга-Их Хуралдай хуран чуулж, Их Монгол улс байгуулагдсаныг тунхаглан зарлаж, Тэмүжинг Далай хаан буюу Чингис хаанд өргөмжилжээ. Шинэ тулгар улсаа тунхагламагц эзэн Чингис хаан улсын их заргачаар Шихихутугийг томилсон бүлгээ. Сайхь зүтгэлтний Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг дараах байдлаар хураангуйлан дүгнэж болох юм.

1. Төрсөн он, нэрийн тухайд



Шихихутуг түүхийн ямар үед амьдарч байсан нь тодорхой боловч, чухам хэдэн онд мэндэлсэн нь өдгөө хүртэл тодорхой бус явж ирэв. Ираны нэрт түүхч Рашид-Аддин “Судрын чуулган” хэмээх алдарт бүтээлдээ Шихихутуг Аригбөхийн самууны үеэр 82 хүрч нас барсан (1,61) гэж тэмдэглэсэн буй. Аригбөхийн

самуун гэж 1260-64 онд Хубилай, Аригбох хоёрын хоорондын хаан ширээний төлөө явагдсан тэмцлийг хэлж байгаа бололтой. Ингэхлээр Шихихутуг 1260-



1264 оны хооронд 82 настай байхдаа нас баржээ. Академич Ш.Бира үүнээс таацуулан бодож, Шихихутугийн төрсөн оныг 1180 он, нас барсан оныг 1262 он гэж ойролцоогоор гаргасанд бүрэн тал өгч болох юм. Үүнээс нарийвчлах боломж тун бага тул түүний төрсөн оныг 1180 он гэж үзэж, мэндэлсний нь 930 жилийн ойг 2010 онд тэмдэглэж болох бүлгээ. Шихихутугийн амьдралын Чингис хаантай холбогдсон үеийг ном зохиолд их төлөв 1190-ээд он гэж үзэж байна. Академич Ш.Нацагдоржийн “Чингис хааны цадиг”-т 1196 онд Татартай хийсэн тулалдааны үед, “Чингис хааны тухай товч тайлбар толь”-д 1190 онд Татар аймагтай байлдах үед Шихихутугийг Чингис хаан олж авсан гэж бичсэн байна. Ш.Нацагдорж: “...алтан ээмэгтэй, булган дотортой эрүүвч өмссөн нэг бяцхан хөвүүнийг Чингисийн цэрэг олж аваад Чингист авчирч өргөжээ. Тэр хөвүүний байдал төрх ерийн хүнээс их л өөр учир Чингис Оүлэн эхдээ асруулан тэжээлгэхээр өгсөн байна. Оүлэн эх тэр хөвүүнийг сайн хүний үр гэж үзэж таван хөвүүнийхээ дүү зургадугаар хөвүүн болгоё гэж шийджээ. Тэгээд Шихихутуг гэж нэр өгчөө” (2,60) хэмээн тэмдэглэжээ. Харин Рашид-Аддин “Татаар угсаатныг хоосруулж байх тэр үед Чингис хаан бас л хүүхэдгүй байсан, түүний авааль гэргий Бөртэ үжин хүүхэдтэй болохыг хүсдэг байжээ. Чингис хаан замын хажууд унасан хүүхдийг гэнэт хараад өргөн авч, Бөртэ үжинд өгч явуулан: “Чи хүүхэдтэй болох гэж байнга хүсч байдаг болохоор өөрийн хүүхдийн оронд энэ хүүхдийг хүмүүжүүлж хайрла” гэжээ. Гэргий нь түүнийг төрсөн хүү шигээ гэр бүлдээ бүрэн хүндэтгэн, нэр төртэй хүмүүжүүлсэн билээ. Түүнийг өсөхөөр нь Шихихутуг гэсэн мөн Хутуг ноён гэж нэрлэдэг. Тэр Чингис хааныг эцэг, Бөртэ үжинийг тэргүүн эх гэж нэрлэдэг байв. Бөртэ үжин нас барахад тэр түүний авсыг гараараа дэлдэн “Ээ, сайн ээж минь” гэж хэлэн, цурхиран уйлж байсан гэж ярилцдаг” хэмээн бичсэн байна. Шихихутуг нэрийн тухайд Шихи гэдэг нь чигчий хуруу мэт бяцхан, хутуг гэдэг нь хурц ухаан гэсэн үг гэж зарим эрдэмтэд тайлбарласан байдаг. Ийнхүү Шихихутуг хэмээх татарын нэгэн хөвгүүн алтан ураг, цагаан ястны хамгийн ойрын хүрээнд багтсан түүхтэй ажгуу.



2. Бага, залуу нас, нийгэм-улс төр, үзэл санааны төлөвшил

Шихихутуг Оэлүн эх, Бөртэ үжиний хайр халамжинд бага насаа өнгөрүүлж, талын язгууртны гэр бүлийн орчинд өсөн хүмүүжиж, хүмүүн төрх суужээ. Тэмүжиний эсгий туургатныг нэгтгэхийн төлөө шаргуу тэмцлийн жилүүдэд Шихихутугийн бага, залуу нас тохисон учир нийгмийн ийм орчин нь түүний улс төр-үзэл санааны төлөвшилд онцгой нөлөө үзүүлсэн байна. Оргөж авсан ах нар, ялангуяа Тэмүжиний талбиу ухаан, чин зориг, баатарлаг үйлс Шихихутугийг өөрийн эрхгүй үлгэрлэн дагуулж байв. Тэрээр хар багаасаа бат чийрэг, зориг чанга, харваж намнахдаа цэцэн мэргэн, овсгоо самбаатай болон өсч бойжиж байв.

Сурвалж бичиг, ном зохиолд Шихихутугийн сэргэлэн цовоо, авхаалж самбаатай баатарлаг хөвгүүн байсныг 12 настай үеэс нь эхлэн тэмдэглэсэн баримт тааралдаж байна. Тухайлбал, Рашид-Аддин “Судрын чуулган”-даа: “Нэлээд түрүүн Хутуг арван хоёр настай байхад нэг удаа Чингис хаан аян дайнд яваад гэрт нь эрэгтэй хүн үлдсэнгүй. Тайчууд аймгийн харъяаны дайсан болох нэг морьтой хүн хажуугаар өнгөрөхөд Чингисийн отгон хүү таван настай (Тулуй) хүү гэрийн гадуур гүйн тоглож байв. Тэр тайчууд хүн морин дээрээсээ бөхийн хүүг шүүрэн авч, толгойг нь сугандаа хавчуулан авч явах гэсэн, хүүгийн эх гүйн ирж хулгайчийн нэг гараас барьж, Хутуг нөгөө гарыг нь барьж авсан боловч, хулгайч хүүгийн толгойг чанга хавчсан болохоор түүнийг хулгайгаас салган авч огт дийлэхгүй байжээ. Хонь дагаж явсан Барака нохой үсрэн хулгайчид халдахад хүүг түүний гараас салгаж авсан. Үүний дараахан Чингис хаан ирээд хулгайчийн мөрөөр явж, олж аваад алжээ. Хулгайчтай тэмцэж эрэлхэг зориг гаргасанд Хутугийг маш их сайшаасан байна” (3,167) гэжээ.

Шихихутуг Чингис хааны орд өргөөнөө Оүлэн эх, Бөртэ үжиний гар дээр өсөж өндийхдөө өдөр ирэх тугам ухаан тод, бас цэгц шударга болохоо мэдрүүлж, моринд гарамгай, харваж намнахдаа цэц мэргэн, сэтгэл шулуун, зориг чанга болсоор байлаа. “Судрын чуулган”-ы бас нэгэн баримт дурдъя.

Овөл Чингис хааны ордон нүүж байхад тэр арван таван настай байсан. Тэсхийм хүйтэн, давшгүй их цастай байлаа. Ийсүт аймгийн Кучукур



(Хүчүгэр) ноён ордныг даргалж байлаа. Гэнэт замын хажуугаар хунгар цасан лундуур сүрэг янгир гүйн өнгөрөхөд Хутуг Кучукурт “Эдгээр янгир их цасанд зугтаж чадахгүй, ингэхлээр би тэдгээрийг хоон гүйцэж харвасугай” гэжээ. Кучукур “За яахав, болноо” гэжээ. Тэрбээр тэдгээр янгирыг хоон одсон байна. Шөнө ордон хоноглохоор буугаад байхад Чингис хаан түүнийг асуухад “Янгир хөөгөөд явчихсан” гэжээ. Чингис хаан асар их уурлан: “Ийм цас жаварт тэр хүү амь алдана” гээд Кучукурыг тэрэгний модоор цохьсон байна. Унтахаар хэвтэж байхад Хутуг иржээ. “Чи юу хийв?” гэж Чингис хаан түүнээс асуухад “Гучаад янгираас гурваас илүү нь зугатаж чадсангүй, бусды нь бүгдийг би алаад цасанд хаячихлаа” гэж хариулжээ. Чингис хаан энэ хүүгийн эрэлхэгийг ихэд гайхжээ. Чингээд тэдгээр янгирыг авчруулахаар Кучукурыг хэдэн нөхөдтэй явуулжээ. Чингис хаан ийм шалтгаанаар Хутугт элэгсэг хайртай байсан аж. Ийнхүү Шихихутуг 15 настайдаа хэдийнээ харваж намнахдаа маш мэргэн цэцэн эрэлхэг дайчин болсон байв. Овөр Монголын судлаач Алтаншаа “Монголчуудын өчигдөрийн мөр” номондоо утга ижил боловч, арай өөр хувилбарыг тэмдэглэсэн байна. Үүнийг сийрүүлбэл: Нэг их цастай өдөр Шихихутуг сүрэг бугыг үзэж, хоон намнасаар үдэш орой болтол буцаж ирсэнгүй тул Чингис хаан Хүчүгэрээс Шихихутугийг асуусанд Хүчүгэр: “Буга намнаад буцаж ирээгүй байна” гэв. Чингис хаан эс итгээд Хүчүгэрийг ташуурдах гэж байтал Шихихутуг буцаж ирээд “30 бугатай тааралдаж 27-г нь харваж алав” гэжээ. Маргааш нь үнэхээр тэдгээр буга цасанд хэвтэж байхыг үзээд Чингис хаан ихэд гайхжээ. Тэрээр бас ер бусын оюун тод, ухаан сэргэлэн байсан бөгөөд уйгаржин монгол бичгийг гарамгай сурчээ. Академич В.В.Бартольд: Чингис хаанд ойр дотно байсан хүмүүсээс татаар гаралтай, бага балчир байхдаа Чингисийн эхэд үрчлэгдсэн Шихихутуг бусдаас түрүүнд уйгар бичиг үсэг, боловсрол сайн эзэмшсэн байлаа (4,45) хэмээн тэмдэглэсэн байна.

Шихихутуг удалгүй эрийн цээнд хүрч, монгол овог, аймгуудыг нэгтгэх Тэмүжиний тэмцэлд оройлон оролцож, амь огоорон зүтгэх болсныг өмнө дурьдсан “Нууц товчоо”-ны зарим баримтаас харж болно.

1200 оны орчим Чингис хаан Тайчуудтай байлдахад Шихихутуг хэдийнээ эрийн цээнд хүрсэнээр барахгүй, хааны итгэлт сайдын нэг болж, дайсантай баатарлагаар тулалдан магтуулж байсан тухай “Монголын нууц



товчоо”-нд өгүүлсэн байдаг. Чингис хаан Чахарай ханыг арлаж, Жалман ханыг өлгийлж явтал эзний дороос халтар тэх харайн гүйхэд нь харван авлажээ. Эзнийхээ авласан ангын хишгийг авч ганзагалах гэтэл тэрбээр: “Үүнийг та нар үтэр өвчиж шар. Би тэр Шар дэвсэг дээр гарч бараа харъя” гээд одов. Тэнд эзний нойр хүрч, толбот бор морины дэл дээр ташуураа тулж унтаад, нэг зүүд зүүдлэв. Чингис хаан сэрээд зургаан сайддаа ирж зарлиг болруун:

<<Би нэг зүүд зүүдлэв.

Бор зүрх минь

Бол бол хийв

Богино хавирга минь

Шир шир хийв.

Болшгүй дайсан

Ирэх нь бололтой ...>> хэмээгээд “Энэ зүүд минь хэрэв үнэн бол зургаан сайд минь та нар яахав?” гэж асуухад тэдний дотроос Шихихутуг хэлэв:

<<Хол ойрыг харагч

Хоёр хурц нүдээрээ

Монгол аймгийг

Мохтол

Мэргид аймгийг

Мэгдэртэл

Тайчууд аймгийг

Далдиртал

Сарын газрыг

Саравчлан харж

Жилийн газрыг

Жилэвчлэн үзэж

Хар нүдний цэцгийгээр

Хаан чамдаа тусалъя

Эргэх нүдний харцаар

Эзэн чамдаа тусалъя>> гэжээ. Түүний дараа бусад сайд нар нь ч эзэндээ үнэнч зүтгэхээ тангараглажээ. Чингис хаан:



Шилдэг зургаан сайдын
Шийдвэртэй үгийг сонсож
Шарсан тэхийн махнаас
Шаламгайлан идэж дуусаад
Шаргал морины цулбуурыг
Шихихутугт өгч
<<Үзсэн зүүдний минь
Үнэн худлыг мэд>> гэж явуулав.
Шихихутуг шунхан шаргал морий нь унаад
Тал газар тавиулж
Тайга газар алхуулж
Хөндий газар хатируулж
Хөвч газар сажлуулж
Шар дэвсэгт хүрээд
Шалгаж сайтар харвал
Бараан тугийг хийсгэсэн
Балмад дайсны цэрэг
Бачмаг тулгарахад
Баатар Шихихутуг
Байсан газрын зүг
Бачимдан давхиж ирээд:
<<Шар дэвсэг дээр
Цочмог гарч очвол
Гурван зуун дайсантай бачмаг тулгарч уулзав
Тайчуудыг таньсангүй
Мэргидийг мэдсэнгүй
Монголыг

Мохтол харж чадсангүй. Хойшоо ганцхан хяламхийн үзэхэд, эзний зүүдэнд үзсэн дайсантай адил мэт байна>> гэжээ. Ойртон ирэхэд нь харвал Тайчууд мөн байсан тул тулалдан зуун хүнийг цавчин алж, хоёр зуун хүнийг дутаалгажээ. Энэ байллаанд зуун морь, тавин хуяг олзлон авчээ. Эзэн зургаан сайдаа магтан дуулсны дотор:

<<Мэргидийг мэгдүүлж



Монголыг мохоож

Тайчуудыг таньж

Дайсныг даралцсан

Татаарын Шихихутуг минь>> (3,96) хэмээн магтан соёрхжээ. Цагийн ороо бусгаа энэ үед Тэмүжин өргөмөл дүүгийнхээ чигч шулуун, ажигч гярхай, оюун гэгээрэнгүй, нягт, аливаа асуудалд даацтай ханддаг чанарыг улам гүнзгий танин мэдэж, цаашид их хэргийг итгэн даалгаж болох итгэл найдварыг өвөрлөжээ.

3. Монгол төр, хууль цаазны тулхтай зүтгэлтэн, их бичгийн хүн

Билгийн тооллын улаан барс жил-1206 онд Их Монгол улс байгуулагдсаны дараа Чингис хаан хамтран зүтгэгээддээ соёрхол хишиг хүртээхэд Шихихутугийн хэлсэн үг, түүний алтан ургийнхтай холбогдсон түүх цадигийг тодотгох тухайд нэгийг өгүүлнэ. “Монголын нууч товчоо”-ны 203-р зүйлд”: Бас Чингис хаан хүргэдийн хамт эдгээр ерэн таван мянганы ноёдыг томилоод тэр дотор зарлиг болоруун: “Омөг туст нөхөддөө өөр соёрхлыг өгье. Боорчи, Мухулай тэргүүтэн бусад ноёдыг ирүүлтүгэй” гэж тэр дотор байсан Шихихутугийг “Тэднийг урьж авчир” гэсэнд Шихихутуг өгүүллүүн:

<<Боорчи, Мухулай нар

Булт биднээс

Их тусалж

Илүү зүтгэсэн үү?

Тэмдэглэн соёрхоход

Тэднээс би

Дугуу тусалж

Ядуу зүтгэсэн үү?

Олгийтэй цагаасаа би

Ондөр босгыг чинь түшиж

Одий их сахалтай

Овгөн буурал болтлоо

Оөр санаа санасангүй



Оршөөлд чинь багтсаар ирэв
Алмай бага наснаасаа би
Алтан босгыг чинь түшиж
Амандаа өдий сахалтай
Ахмад настай болтлоо
Алжааж бэрхшээсэн зүйлгүй
Аль байдгаараа зүтгэв.
Хөлдөө хэвтүүлж
Хөнжилдоо хучиж
Хөвгүүн адилаар
Хүмүүжүүлэв намайг
Дэргэдээ хэвтүүлж
Дээлдээ хучиж
Дүү мэтээр
Түшиж өсгов.

Одоо надад ямар соёрхолыг хайрлах вэ>> (3,167) гэж асуусан байна. Энэхүү асуултын хариу болгон Чингис хаан Шихихутугт дараах соёрхлыг хайрлажээ.

“Монгол нууц товчоо”-нд “... Чингис хаан, Шихихутугт өгүүлрүүн: “Чи миний зургадугаар дүү биш үү? Оргөмөл дүү чамд өөрийн дүү нарын адилаар өмч хувийг олгоё. Бас чиний хүргэсэн ач тусыг бодож, есөн осолыг хэлтрүүлэх болгоё” гэж зарлиг болгов. “Мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохиуулж байхад чи, үзэх нүд, сонсох чих болж яв. Бидний эх ба дүү нар, хөвүүдэд эсгий туургатны дотроос эдлэх хувийг олгож, хавтсан үүдэтний дотроос харъяалах ардыг хувааж өг. Чиний тушаасан үгийг хэн ч өөрчилж үл болно” гэж зарлиг болов. Бас Шихихутугийг “Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай” гэж бүх улсын дээд заргач (шүүгч) болгов. Бас “Нийт улсын өмчийг хувааж, заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгтүн. Надтай зөвлөж, Шихихутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй” гэж зарлиг болгов. Шихихутуг өгүүлрүүн: “Миний мэтийн оргодол (өргөмөл) дүү, хааны дүүтэй адилаар хувь өмч авч яаж болох вэ? Хаан соёрхвол, байшин гэртэй,



балгас хотын иргэдээс авъя” гэж өчвөл, “Чи өөрөө энэ хэргийг зүтгэж шийтгэх тул өөрөө мэдэж гүйцэтгэ гэв” (3,167-168) хэмээжээ. Ингэж Чингис хаан Шихихутугийг Улсын их заргачаар томилжээ. Эл томилолтыг академич Б.Я.Владимирцов: “Чингис хаан хүмүүсээ гайхалтай таньж, өрлөг жанжнуудаа хэрхэн зөв сонгож байсан шигээ ерөнхий шүүгчээ мөн л тийм аргаар зөв таньж олж авч чадсан” (5,52) гэж үнэлсэн байна.

“Нууц товчоон”-ы энэ мэдээнээс үзвэл, улсын дээд заргач Шихихутуг нь:

- Хаанд зөвлөн, хааны нэрийн өмнөөс шүүн таслах ажиллагаа явуулах;
- Төрийн байгууллага, иргэдийн хуулиар зөвшөөрөгдсөн ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх;
- Хаан төрийн “үзэх нүд, сонсох чих” болж, улс үндэснийхээ аюулгүй байдлыг сахин хамгаалах;
- Бичмэл хууль цааз боловсруулж, хаанаар батлуулан мөрдөх зэрэг үүрэгтэй байжээ. Энэ бүхнээс үзэхэд, Шихихутуг “Их засаг” хуулийн гол зохиогч, хянан боловсруулагч байсан нь гарцаагүй юм.

Шихихутуг үйл ажиллагаагаа зөвхөн хууль ёс, журам дэглэм сахиулах төдийгөөр хязгаарлаж байгаагүй, төрийн бүхий л тулгам үйл хэрэгт ухаанаа уралдуулж, санаагаа сааж байсныг олон баримтаар өгүүлж болно. Тухайбал, 1234 оны I сарын 31-нээс 1235 оны I сарын 20-ны хооронд Умард Хятадад амбан сайд Хутагтын удирдлагын дор хүн амын тооллого явуулах тухай Огөдэй хааны зарлиг гарсан байна. (6, 77) Бас өөр нэг эх сурвалжид: “Монголын түшмэл Шихихутугийг 1235-1236 онд Яньзинд очиж, хүн амын тооллого явуулахад Омнот Сун улсын улсын төлөөлөгчид байлцсан” (6, 145) хэмээн өгүүлжээ.

Тухайбал, 1216 онд Чингис хаан Алтан улсыг байлдан дайлаад, нийслэл хот Зүндү балгасын алт, мөнгө, ад агуурс, юмыг тоолуулахаар Шихихутуг, Үнгүр буурч, Архай Хасар гурвыг илгээжээ. Алтан улсын хаан Зүндү хотоос зайлахдаа Хада нэртэй ноёнд уг хотыг хариуцуулан орхисон аж. Шихихутуг нарыг хүрэлцэн очиход Хада ноён угтаж, алттай, хээтэй эд агуурсыг барьж хот дотроос гарч уулзсан байна. Хадад Шихихутуг өгүүллүүн: “Урьд эн Жүндү хот ба Жүндүгийн эд юм Алтан хааных байв. Одоо Жүндү Чингис хааных болов. Чингис хааны эд агуурсыг чи яагаад далдуур хулгайлан авчирч өгч байна. Үүнийг би авахгүй” гэж Шихихутуг эс авав. Үнгүр буурч, Архай хасар



хоёр авав. Энэ гурав Жүндүгийн юмыг тоолж ирэв. Тэнд Чингис хаан Үнгүр, Архай, Шихихутуг гурваас “Хада юу өгөв?” гэж асуувал Шихихутуг өгүүлрүүн: “Алттай, хээтэй эд агуурсыг авчирч өгөв. Миний хэлсэн нь: “Урьд энэ Жүндү Алтан хааных байв. Одоо Чингис хааных болов. Хада чи, Чингис хааны эд юмыг далдуур хулгайлж яахин өгөв?” гэж би эс авав. Үнгүр, Архай хоёр, өгсний нь авлаа” гэв. Тэгэхэд Чингис хаан, Үнгүр, Архай хоёрыг маш буруушаан донгодов. Шихихутугийг “Чи их ёсыг сэтгэжээ” гэж маш сайшаан соёрхож, “Чи миний үзэх нүд, сонсох чих биш үү” гэж зарлиг болгожээ (3, 210-211). Үүгээр Монголын төр ёсонд хаан төрийн өмчийг хайрлан арвижуулах “их ёс”-ны үндэс тавигджээ. Ийнхүү Шихихутуг зөвхөн хууль хяналтын ажил эрхлээд зогсохгүй, их гүрний засаг захиргаа, хүн ам, аж ахуй, эдийн засгийн хэргийг удирдан зохион байгуулах үйлсэд хичээнгүйлэн зүтгэж байлаа.

Гадаад байдлаа төвшитгөх зорилгоор Чингис хааны өрнө зүг хийсэн аян дайнд Шихихутуг голлох үүрэгтэй оролцож, Дундат Азид ялгуулсан алдраа мандуулж, бас ялагдан дийлэгдэхийн сургамжийг ч авч байжээ. 1221 оны хавар Чингис болон Тулуйн цэрэг аян дайнаа үргэлжлүүлэхээр хөдлөх гэж байгаад Зебильстанд бэлтгэл хүч болгон суулгасан салаа цэргийг Хорезмын шах Желал-Аддин бут цохиж устгасан тухай мэдээ авчээ. Ингээд Чингис хаан Шихихутугт гурван түмэн цэрэг өгч, манлай болгон нэгд, Желал-Адиныг тагнах, хоёрт, их цэргийн аяныг хамгаалуулах үүрэгтэйгээр Зебильстан, Кабулын уулархаг нутагт томилжээ. (7, 239) Тэгээд Шихихутуг Парван тосгоны орчим Желал-Адины долоон түмэн цэрэгтэй тулгаран байлджээ. Хоёр этгээд өдөр турш ширүүн тулалдсан боловч хэн нь ч дийлсэнгүй. Тэр шөнө Шихихутуг олон агтын нуруунд эсгий хөдсөөр үйлдсэн мануухай унуулан эсрэг этгээддээ нэмэлт хүч ирсэн мэтээр ойлгуулах арга сэджээ. Султаны цэрэг ч түүнд итгэж айн балмагджээ. Гэвч Желал-Адин үхэх сэхэхээ үзэлцэхээр зориглон шийдэж, цэргүүддээ: “Дайсны цэрэг олон боловч, айх хэрэггүй. Хоёр гардан байлдаж, ороон бүсэлж устгагчун” гэсэн тушаал өгчээ. Шихихутуг эл ширүүн тулалдаанд цэргийнхээ хагас илүүг алдаж ялагдан, зам буруулжээ.

Чингис хаан Шихихутуг айн ялагдсан тухай мэдээг аваад онц ундууцаж



хилэгнэсэнгүй. Түүнийг буцаж ирсэний дараа их хаан: “Онгөрсөнд чи ер дайсанд дийлэгдэж үзээгүй тул омгорхог бардам болжээ. Энэ удаагийн ялагдлаас сургамж абвал зохино” гэсэн гэдэг. Тэгээд Чингис хаан өөрийн биеэр цэрэг авч, Желал-Аддиныг нэхэн хөөжээ. Замдаа Шихихутугийн ялагдсан газар ирж, хоёр этгээдийн цэрэг байрлуулан байлдсан газрыг байцааж үзээд: “газрын байцыг муу сонголоо” гэж Шихихутугийг буруушаан зэмлэсэн аж.

Шихихутуг Огөдэйн хаанчлалын үед ч Монголын төрд хүндтэй байр эзлэн, хааныхаа гол түшиг, дотны нөхөр болж байв. Огөдэй хаан түүнийг “Ахаа” хэмээн хүндэтгэн дуудаж, хожим хаан болсон Мөнхийн дээд талын суудалд суулгадаг байжээ. 1230 онд Огөдэй хаан Умарт Хятадыг дайлахаар мордохдоо Шихихутугийг авч явжээ. Тэрбээр баруун гарын цэргийг захирсан Тулуй ноёны зөвлөх жанжнаар энэ дайнд оролцсон байна. Тэд 200 мянган цэрэг бүхий хамгаалалтын шугамын гол цэг—Тунгуань боомтонд хүрч очжээ. Энд Алтан улсын жанжин Хада их цэрэгтэйгээ уулын энгэрт модон хүрээ байгуулан, Монгол цэрэгтэй эрэгчин эмэгчнээ үзэлцэхээр хүлээж байв. Эл байдлыг Тулуй олж мэдээд Шихихутугийг дуудаж: “Тунгуань боомт бол дөрвөн талаараа уул хайрханаар бүслэгдсэн бэрх бартаат газар болох бөгөөд Алтан улсын цэрэг ч уул энгэрт модон хүрээ татаад байлдахаар хүлээж байгаа тул бид заавал тэднийг өдөөн гаргаж ирээд байлдвал сая дийлж чадна. Иймээс чи гурван зуун морьт цэрэг авч өдөржин шоножин Тунгуань боомтыг өдөөн байлдагтүн!” гэж тушаажээ. Шихихутуг шилдэг гавшгай 300 морьт цэргээ авч хэдэн өдөр өдөөн байлдсан боловч, Алтан улсын цэрэг хүн хүч ихдээн бардамнаад ер ойшоох ч үгүй байжээ. Иймд Тулуй: “Алтан улсын цэрэг уг орноосоо хөдлөхгүй бол бид байлдаж үл болно. Бид хойш ухарвал тэд улам омогших болно. Иймээс бид Алтан улсын нийслэл хотыг байлдан эзэлвэл Тунгуань боомт аяндаа бууж өгөх болно” гэж хэлээд Шихихутугт цөөн тооны цэргийг үлдээн өгөөд, өөрөө их цэргийг авч, Бянь (Кайфин) хотыг эзэлхээр мордсон аж. Тийнхүү хэдэн өдөр өнгөртөл Монголын цэрэг нэг ч үзэгдэхгүй болсон тул Хада их цэргээ авч араас нь нэхэмжлэхээр хөдөлжээ. Энэ үед Шихихутугийн захирсан цөөн тооны шилдэг морьт цэрэг сүүлдэн дагаад, Хадын цэргийг байлдах гэвэл Шихихутугийн цэрэг дутааж,



Хадын цэргийг амдах гэвэл Шихихутугийн цэрэг байлдаж, өчүүхэн ч амруулахгүй үймүүлж байв. Хадын цэрэг энэ мэтээр хэдэн шөнө, хэдэн өдөр нойр хоолгүй аялаад, нэгэн сүрлэг уулын ойролцоо иртэл Огөдэй хааны цэрэг голын хойд талаас хүрэлцэн ирж, Тулуйн цэрэг лүгээ нийлээд хоёр талаас нь хавчин байлдаж, бүх цэргийг нь бут ниргэжээ.

1234 онд Огөдэй хаан Алтан улсыг бүрэн эзэлж аваад, Шихихутугийг дотор газрын захирагчаар томилсон байна. Тэрбээр 140 түм гаруй Хятад өрх амыг данслан, тохинуулаад эх нутагтаа буцаж иржээ.

Шихихутуг бас төрийн хэрэг, номын буяныг ихэрлүүлэн зүтгэж, бичгийн мэргэний нэн даруу ёс ямбыг жудаг сахин барьж байлаа. Зарим судлаачид түүнийг “Монголын нууц товчоон” хэмээх гайхамшигт бүтээлийг туурвисан гэж таамаглах нь буй. Үнэндээ ч Монгол овогтныг нэгтгэх тэмцэлд оролцож байсан цаг түүхийн амьд гэрч, эрдэм номонд гаршсан авьяас билэгтэй бичгийн мэргэний хувьд ч уг алдарт бүтээлийг туурвисан байж болзошгүй, үгүй юмаа гэхэд гар бие оролцсон нь дамжиггүй. Ямраар ч үзсэн өгүүлэн буй үед Шихихутуг цэргийн хэрэгт ид хав нэвт, эрдэм соёлд нягт хичээнгүй, цааз эрхэмжинд чанд хэрсүү төрийн эр, судрын хүмүүн болон төлөвшсөн нь бүх талаар нотлогдож байна.

4. Шихихутугийн номлол, дэг сургууль

Шихихутуг бол Их Монгол улсын Чингис, Огөдэй, Гүюг, Мөнх хааныг насан элтэл, Монголын Юан улс байгуулагдахын нүүрийг үзтэл хүчин зүтгэж, их ухаан, үлэмж тэвчээр тэгширч, өндөр насалсан зүтгэлтэн юм.

Тэрээр чин үнэнч, чигч шударга чанар, бичгийн мэргэний уламлан бодсон ухаарлын ачаар шүүх хууль цаазын өөрийн гэсэн дэг сургуулийг бий болгожээ. Рашид-Аддин: “Тэр үеэс одоо хүртэл Могулистанд ч, бусад нутагт ч түүний арга, барилын зарчмыг шүүхийн шийдвэрийг үндэс болгодог нь заргачдын /шүүгчдийн/ маргаанаас тодорхой байна. (1,61) хэмээн тэмдэглэжээ. Энэ дэг суруулиар Монголчууд төдийгүй, 720 хэлээр ярьдаг, 5 өнгийн улс түмнийг нэгтгэсэн, дэлхийн талыг эзэгнэсэн Монгол их гүрний



бүх шүүгчид ажиллаж байжээ. Шихихутуг Мөнх хааны үеийн нэрт шүүгч Мөнхсар ноён, Хубилай хааны үеийн шүүгч Байжу, түүнчлэн Хятад, Перс зэрэг олон үндэстний шүүгчдийг өөрийн гараар сурган бэлтгэсэн аж.

Халимагийн нэрт түүхч Э.Хар-даваа: “Чингис хааны сонголт маш зөв болсон. Шихихутуг шүүгчийнхээ үүргийг үлгэр жишээчээр биелүүлж, зарим талаар өөрийнхөө зуунаас бүр халин гарч байжээ. Тэрээр айхдаа өгсөн өчиг мэдүүлгэнд ямар ч ач холбогдол өгдөггүй байсан” (8,60) гэж бичжээ. Мөн академич Б.Владимириов: “Шихихутуг үүрэгт ажлаа үлгэр жишээчээр биелүүлж байсан ба түүний ажилсаг байдал бусад хүмүүст гайхамшигт сайхан үлгэр дуурайлал болж өгчээ” (5,52) хэмээн тэмдэглэсэн байна.

Хүлэг эцэж, хүн харьдаг нь жам ёсон. Тэрбээр насны эн, үйлийн ихэд дарагдаж, 82-ны сүүдэр зооглосон байна. Улсын их заргач Шихихутуг “Айж, цочин хэрэг хүлээх хэрэггүй”, “Айлтгүй үнэнээ хэл” гэж хэрэгтэн хүмүүст нэг биш удаа давтан хэлдэг байсан нь гэм эрдэм байвч, сэтгэл нь далай мэт байсных буй заа. Түүний түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, гавъяа зүтгэлийг эрдэмтэд судлаачид өндрөөр үнэлжээ. Академич Ш.Бира: “Шихихутуг үнэхээр Монголын хууль цаазны гарамгай зүтгэлтэн, монголын төрийн агуу их түшээ байсан” (9,76), академич Ч.Жүгдэр: “... монголын хууль зүйн сэтгэлгээний анхны том төлөөлөгчийн нэг” (10,127), доктор Д.Гонгор “Шихихутуг бол XIII зууны үеийн Монголын төрийн зүтгэлтний дотроос хамгийн өргөн боловсролтой бөгөөд... монголын тулгар төрийн анхны гол хууль “Их засаг” ийг зохиоход оролцсон бололтой” (11,154-155), профессор И.Дашням: “Эрдэм номтой, бичиг үсэг мэддэг, шулуун шударга, хичээнгүй нягт, нэр хүнд төгс, төрийн алдарт түшээ, нэрт зүтгэлтэн хүн”(12,376) гэх мэтээр тэмдэглэжээ. Энэ бүхнээс үзэхэд, Чингис хааныг эс тооцвол Шихихутугаас өөр өөрийнхөө дэг сургуулийг бий болгон дэлхий дахинаа хүлээн зөвшөөрүүлж, олон улс түмний төрийн түшмэл, шүүгчдийг ухаан, арга барилаараа араасаа дагуулж байсан төрийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэд Монголын түүхэнд урьд хожид ч, өдгөө ч гараагүй гэж бардаагаар хэлж болно. Ийнхүү Шихихутуг бол Монгол төрийн алтан буулга мэт хууль цаазыг магадлан боловсруулагч, чандлан сахиулагч, нандигнан хамгаалагч, төрийн



хэргийг номоор засахыг дээдлэн эрхэмлэгч төрийн үлэмж агуу, сэцэн билэгт зүтгэлтэн байжээ.

Шихихутуг хэмээх алдар Монголын төр, цааз эрхэмжийн түүхэд өнөд мөнхрөн үлдэх болно.

Эшлэл

1. Рашид-Аддин. Судрын чуулган. I боть, II дэвтэр (Орчуулсан Ц.Сүрэнхорлоо) УБ.1994
2. Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ.1991
3. Монголын нууц товчоо. УБ.1976.
4. В.В.Бартольд. Туркестан в эпоху монгольского нашествия. Сочинения. т-1, М.1963
5. Б.Я.Владимирцов. Чингис-хан. Улан-Удэ. 1995
6. Н.Ц.Мункуев. Китайский источник о первых монгольских ханах. Надгробная надпись на могиле Елюй-Чуцая. Перевод и исследование М.1965
7. Монгол цэргийн түүхэн товчоон. Тэргүүн дэвтэр. УБ.1996
8. Хара-Даван-Эренжен. Чингис-хан как полководец и его наследие. Элиста. 1991
9. BULLETIN. The LAMS News Information on Mongol studies. 1997.№2(20) 1998. №1(21)
10. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ.1987
11. Д.Гонгор. Халх товчоон. II боть. УБ.1978.
12. И.Дашням. Монголын улсын төр, эрх зүйн түүх. Тэргүүн боть. (МЭО 209-МЭ XIII зууны дунд үе). УБ.2005



ИЛ ХААН АРГУН, ӨЛЗИЙТ НАРААС 1289, 1305 ОНД ГОО ФИЛЛИПТ ИЛГЭЭСЭН ЗАХИДЛУУД ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

*Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
профессор Д.Лүндээжанцан*

Захидал 1.

Мөнх тэнгэрийн хүчин дор, хааны суу дор Аргун бидний үг.

Францын хаанд.

Ноднин (жил) чи айлчин Мар Бар Савма тэргүүтэй элч нараар өчиж мэдүүлэхдээ, (хэрэв) Илхааны цэргүүд Мисир (Египет)-ийн зүг дайлаар мордвоос бид бас эндээс хөдөлж довтлоно гэснийг чинь зөвшөөрч **Тэнгэрт залбирч** барс жил (1290 он) өвлийн адаг сард (бид) мордож хаврын тэргүүн сарын арван таванд Дамаскт бууна хэмээсэн (билээ). Эдүүгээ (чи) үнэн үгтээ хүрэн цэргүүдээ болзсон цагтаа илгээж **Тэнгэрийн хишгээр** тэр иргэдийг авбаас бид Иерусалемыг танд өгье. Цаг хугацаа хождож аваас нэмэлт цэргүүдээ явуулаад яахин зохих буй. Хожим гэмшивч ямар тус амуй. Бас аливаа мэдээ (г) нэмэн элч нараараа яаралтай явуулан тансаг эд, шонхор шувууд, франкуудын газрын элдэв өнгөтөн (үнэт) чулуу өгч илгээвээс хэрхэн соёрхохыг **Тэнгэрийн хүчин, хааны суу мэдтүгэй** (шийдтүгэй) хэмээн Мускерил юлдэчийг илгээв. Захидлаа (бид) үхэр жил зуны тэргүүн сарын зургаан хуучдад Хөндлөнд байхдаа бичив.¹

¹ А.Мостэрт, Ф.В.Кливе. Илхаш Аргун, Өлзийт нараас 1289,1305 онд гоо Филлипт илгээсэн захидлууд. УБ., 1998. 37,38 дахь тал.



Захидал 2.

Өлзийт султан бидний үг Францын султанд.

Эртнээс франкуудын султан та бүхэн бидний сайн элэнц, сайн өвөг, сайн эцэг, сайн ахтай найрамдаж хол боловч ойр мэт санаж аливаа үгсээ өчиж элчингүүдээ (болон) эсэн мэндийн бэлгээ солилцож ирснийг яахин умартах буй. Эдүгээ бид **Тэнгэрийн хүчинд** их хаан ширээнд суугаад түрүүчийн хаад (бидний) эрхэм өвгөд дээдэс (бидний) сайн эцэг, сайн ахын тушаал, зааврыг эс огоорон, (биднийг) хаан ширээнд залрах үед нэгэнт тогтчихсон байсан журмыг (хийгээд) (биднээс) өмнө засаглаж байсан (хаад) сайчуудтай (та нарын) зовшилцсөнийг хэрхэвч олтгойдуулахгүйгээр, (харин ч) андгай мэт үзэн урьдаас бүр ч үлэмж (та бүхэнтэй) найрамдаж элч нараа харилцан илгээхийг зорьж амуй. Ах дүү бид нар муу харцасын ташаа (хорлонт) үгнээс (шалтгаалж) бие биедээ (өмнө нь) дүргүй болсон билээ. Эдүгээ **Тэнгэрийн соёрхолыг хүртсэн** Чингис хааны ургууд Төмөрхаан, Тогтога, Цабар, Дуга тэргүүтэн бид дөчин таван жилээс нааш энэ хүртэл хэрэлдэцгээж эдүгээ **Тэнгэрийн ивээлээр** ах дүү бид бүгд зохилдож наран ургах Нанхиадуудын газраас Талу тэнгис хүртэл (манай) улс гүрнүүд холбогдож (=холбоо харилцаагаа сэргээж) (өртөө) замуудаа байгуулав. Бидний завсар хэн (хэн нэгэн) бус сэтгэвээс (буруу санаа өвөрлөвөөс) бүгдээрээ хамсарч тэдний дээр байя (тэдний эсрэг босно) хэмээн үг хэлэлцэн тогтов. Эдүгээ манай сайн өвгөд дээдэс (манай) сайн эцэг (манай) сайн ахтай (та бүхний) найрамдаж харилцсаныг яахин бид огоорох билээ хэмээж Мамал (а)-г, Томан эд (энэ) хоёрыг илгээв. Таны Олон Франкуудын вангууд хамт хоорондоо зохилдож амуй хэмээн (бидэнд) айлтгасан билээ. Үнэн хүү зохилдохоос сайн юу байх билээ?. Эдүгээ бидэнтэй болон та нартай үл эвсэгчдийн эсрэг **Тэнгэрийн хүчинд** бүгдээрээ хамсарч тэмцэхийг **Тэнгэр мэдтүгэй**. Манай захидал үүнийг 704 онд могой жил (1305 он) зуны тэргүүн сарын найман хуучдал Аливанд байхад бичив.²

Юуны өмнө өнөөдөр бид бүгдийн хувьд харьцангуй тодорхой болчихсон

² А.Мостэрт, Ф.В.Клине. Илхаан Аргун, Өлзийт нараас 1289,1305 онд гоо Филиппт илгээсэн захидлууд. УБ., 1998. 86,87 дахь тал.



эл захидлуудын түүхэн болон хэл зүйн олон асуудлаас түдгэлзэж “.....” сэдвийг хөндөн өгүүлэхийг хүсэж, басхүү ийн өгүүлэх болсон учир шалтгаанаа нэн тэргүүнд тайлбарламаар байна.

Миний бие саяхан Францын уулзаж, ярилцаж байхад.....өөрийнхөө өгүүлэл бичих гэж буй тэр сэдэвтэй холбоотой халуун дулаан яриа өрнүүлсэн билээ. Харин өгүүллээ бичих тэрхэн үед эрх зүй, төрийн онол, түүхийн судлаач, хуульч хувьдаа асуудлыг өөрөөсөө эхэлж, эрх зүйн орчин буюу төр ёс, эрх зүйн сэтгэлгээний асуудал руу хандуулж авч үзмээр санагдсан билээ.

Монголч эрдэмтэн А.Мостэрт, Ф.Б.Кливе нарын бүтээл болох “Илхаан Аргун, Олзийт нараас 1289, 1305 онд гоо Филиппт илгээсэн захидлууд” хэмээх бүтээлд: *“...Мөнх Тэнгэрийн хүчин”, “Эзэн хааны буян заяа”-г сануулдаг дасал болсон эхний томъёолол ... Газаны захидал болон Өлзийтийн захидалд, мөн Өлзийт, түүний хүү Абу Са, идын тамганы үсэгт “мөнх тэнгэр” дурсагддаг¹ хэмээгээд Ислам шашинтай болсон хунтайз нарын захидал хийгээд бусад баримт бичигт дурдагдаж буй “тэнгэр” гэдэг үгийг лалынхны дээдлэн шүтдэг бурхан гэж ойлгох нь зүйтэй юм шиг байна²* гэсэн тайлбар хийгээд дүгнэлтийг өгсөн байдаг. Чухамхүү энэ тайлбар дүгнэлтээс л эхлэн өгүүллээ бичих санаа төрсөн билээ.

1. Дорно дахины ард түмний сэтгэлгээний хэв шинжийг өрнөтэй харьцуулахад төвшний ялгаанаас гадна иргэншлийн онцлогоос үүдсэн үнэлэмжийн шинжтэй өвөрмөц онцлогууд олон бий.

Дорно дахины иргэншил, соёл олон хүчин зүйлээр өрнөөс ялгарах хэдий ч онцолж үзмээр нэг зүйл “тэнгэрийн үзэл”, “азийн үйлдвэрлэлийн аргаар” нөхцөлдсөн төрийн өндөр үүрэг, түүнээс улбаалсан үүрэг дээдлэх сэтгэлгээ давамгайлах чиг хандалага байдагт оршино.

Үүрэг дээдлэх сэтгэлгээний оюун санааны үндэс нь Эртний Хүннү нараас эх үндэстэй эзэн хааныг шүтэж, түүнийг тэнгэр язгууртай гэж үзэж байсан төв азийн нүүдэлчдийн төр ёсны сэтгэлгээтэй шууд холбогдоно.³

Тэгэхлээр тэнгэрийн үзэл эртний Хүннү нараас монголчуудыг хүртэлх

¹ Мөн ном. 87 дахь тал.

² Мөн ном. 87 дахь тал.

³ Н.Лүндэндорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ.,2002.183 дахь тал.



бүх түүхэн үед нүүдэлчдийн хаадыгаа өргөмжлөх, дээдлэх, төр ёсыг сэтгэх үндсэн баримтлал болсоор ирсэн бололтой. Тийм учраас тэнгэрийн үзэл бол хүннүгээс эхлэн Монголчуудын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний тулгуур зарчим, эх сурвалж, төр шүтэх үзлийн оюун санааны үндэс болж ирсэн байна.

Харин өдгөө эл үзлийг “төгс төгөлдөр ухамсарын төсөөлөл”⁶ “төрийн хүлээн зөвшөөрөгдөх чанарыг илэрхийлсэн үзэл суртал”⁷, “бүхнийг амилуулан шимэлж өгдөг түгээмэл чанар”⁸, “оюун санааны дээд төвшний үзэгдэл”⁹, “юмсын хөгжлийн түгээмэл шинжийг тохиож байдаг дээд хууль”¹⁰, “оюун санааны ертөнц”¹¹ гэж үзэх нь нэлээд түгээмэл боллоо.

Монголчуудын тэнгэрийн үзэл эрх зүйн соёл, сэтгэлгээнд төгс төгөлдөр үнэний тухай, шударга ёс, тэнгэрлэг ёс суртахуун, түүнд нийцсэн ёс заншил, хэв ёсыг бий болгох оюун санааны эх үндсийг бий болгосон гэж үзэж болно. Энэ үндэс суурин дээр монголчуудын хууль цаазын үзэл, сэтгэлгээ бүрэлдэн тогтов. Түүнээс давсан хүчтэй ямар нэг номлол, суртал байсан гэх үндэслэл олоход нэн бэрх бөгөөд бололцоогүй шахам юм.

Тэнгэрийн үзэл монголчуудын хууль цаазыг гагцхүү биелүүлэх, бишрэн дагах үүргийн сэтгэлгээг юуны түрүүнд бий болгосон байна.

Үүнээс үндэслэн монголчууд хууль цаазыг үүргээр дамжуулан төсөөлж, объектив эрхийн агуулгыг тогтсон зан заншлын эсрэгийг цээрлэх, эзэн-төрийг дээдэлэх, ёс жудагтай амьдралыг тусгасан зан заншил, ёс журам, хууль зүйлээр ойлгож, субъектив эрхийг эдлэх ёстой жам ёсны эрх гэсэн утгаар бус тэнгэрийн ёс, зарлиг гэсэн ухаан, итгэл бишрэлээр хүлээн зөвшөөрч байсанд оршино. Энэ үзэл, сэтгэлгээ нь дорнын ард түмний өрнө дахинаас ялгарах онцлог болно.

Нөгөө талаас нь авч үзвэл, Монголчуудын мөнх тэнгэрийн үзэл-эртний

⁶ Х.Тэмүүжин. Монголчуудын хууль цаазын сэтгэлгээний тулгуур зарчим ба эх сурвалж. (Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал) УБ., 2002. 105 дахь тал

⁷ Ш.Бира. Монголчуудын тэнгэрийн үзэл (ОУМЭ-ийн VII их хурлын илтгэл)

⁸ Г.Лувсанцэрэн. Чингис хааны төрийн үзэх үзэл. Монголын философиин түүх. II боть. УБ., 2000. 127 дахь тал

⁹ С.Дулам. Мөнх тэнгэрийн шүтлэгхийгээд монголчуудын оюун санааны өвөр төрх. (Гүн ухааны баримтлал) Улан-Удс., 1996.с67.

¹⁰ Х.Сэлэнгэ. Мөнх тэнгэр, төрийг шүтэх үзэл. (Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал) УБ., 2002. 25 дахь тал

¹¹ Ч.Жүндэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-үж төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 2002.2 дахь хэвдэл.34 дэх тал.



дорно дахины домог зүйд тулгуурлан Бүртэ-чингын удмынхан тэнгэр язгууртай, мөнх тэнгэрийн ивээлээр төрж, төр улсаа мандуулах ид шидтэй, тэнгэрийн элч учраас юунд ч дийлдэшгүй хүчтэй, тэнгэртэй зөвхөн тэр л харилцаж, одоо болон ирээдүйн хэргийг шийднэ гэсэн үзэл нь (үнэхээр тэгж итгэж байсан уу, эсвэл төр улсаа аймаг, овгоо нэгэн эгэл биш сод хүмүүнийг даган нэгдэж, хүчирхэгжин тогтох үүднээс ийм суртлыг зориуд буй болгосон нь тодорхойгүй хэдий ч) эхэндээ их эзний суу билгийг үнэлэх, тахин шүтэх үндэслэл болж байснаа улмаар хөгжлийн явцад ертөнцийн жам ёсыг эрхэмлэн дээдэлж, хүч оюунаа хөвчлөн төвлөрүүлж, өөртөө эрч хүч, итгэл бишрэлийг олж авах дээд объект тэнгэртэй “харьцаж” хүмүүсийн ёсноос дээш халисан төрийн их үйл хэргийг мэргэн, шударга, зүй ёсоор явуулах, хүчирхэгжүүлэхэд оюун ухааны эрч хүчийг хураан зангидаж, дайчлан илэрхийлэх, үнэт зүйлсийн дээд чанарыг агуулсан төр ёсыг хэрэгжүүлэх арга, ухаан болж хөгжсөн байна.¹²

Их эзэн Чингис өөрийгөө тэнгэр гаралтай, тэнгэрийн хүчээр их үйл бүтээж байгаа гэдэгтээ гүн итгэж, тэнгэрт мөргөн залбирч байхад: тухайлбал, Монголын нууц товчоонд өгүүлдснээр Чингис хаан тэнгэр эцэгтээ өчил өргөхдөө:¹³

Эрэмгий сайнаараа

Эзэн эс боллоо би

Эцэг тэнгэрээс заяатай боллоо би.

Гайхамшигт сайнаараа

Хаан эс боллоо би

Хан тэнгэр эцгээс заяатай боллоо би хэмээчихүй. Тэгвэл төрийн иргэн улсын хувьд тэнгэр ямар аугаа хүч мэт ойлгогдох нь ойлгомжтой юм. Тийм учраас тэнгэрийн зарлигийг дагах нь аугаа их ёс, нэр төрийн хэрэг мэт байв. Үүний нотолгоо бол нэгэн хятад жуулчны бичсэн тэмдэглэл бөгөөд тэрхүү тэмдэглэлд: “... тэд энгийн яриандаа “мөнх тэнгэрийн хүчинд их хааны суу зальд ивээгдэж” гэж ярьдаг. Тэд өөрийн хүссэн явдлаа үйлдэхдээ тэнгэрийн

¹² Н.Лүндэндорж. Дээр дурдсан ном.

¹³ Монголын Нууц Товчоо.



соёрголоор үйлдэв хэмээх ба нэгэнт үйлдсэн явдлаа тэнгэр түүнийг мэднэ гэнэ. Ямарваа явдлыг ч тэнгэрт эс найдах бээр үгүй. Монголын эзэн хаанаас энгийн ардад хүртэл бүгд ийм ажээ” хэмээн бичигдсэн байна. Энэхүү санаа ч 1289, 1305 онд Ил хаан Аргун, Олзийт нараас гоо Филиппт илгээсэн захидлын агуулгад ч тодорхой туссан байна. Тухайлбал, 1305 онд “Ил хаан Олзийтөөс гоо Филиппт илгээсэн захидал”-ын дээрхи агуулгад: “... бид **Тэнгэрийн хүчинд** их хаан ширээнд суугаад... **Тэнгэрийн соёрхолыг хүртсэн** Чингис хааны ургууд бид ...**Тэнгэрийн ивээлээр** ах дүү бүгд зохилдож... (та бүхэнтэй) найрамдаж элч нараа харилцан илгээхийг зорьж амуй”¹⁴ гэжээ.

Энэ бүхнээс эрэгцүүлвэл төр, түүний эзэн өөрийн туйлын хүслэн болох тэнгэрлэг чанартай дүйцэж түүнийгээ хадгалах гэсэн чармайлт нь төрөө төр шиг байлгаж, жинхэнэ хаан шиг хаан байхад хөтлөн дуудаж, дайчлан зоригжуулж байсанд монголчуудын төрөө дээдлэн хүндэтгэх ёсны үндэс оршин буй мэт. Өөрөөр хэлбэл, монголчууд Эзэн Чингис болон түүний ор залгамжлагчид нь мөнх Тэнгэрийн санааг уламжилж, зарлигийг нь биелүүлэгч хэмээн шүтэж биширч байжээ. Иймд тэнгэр эцэг удирдах гэдэг нь дээд оюун санаагаар удирдах гэсэн утга санаа болой. Тэгэхлээр монголчуудын тэнгэрийн таалал, тэнгэрийн зарлиг гэдэг нь дээд оюун санааны хууль зарчмын илэрхийлэл болох нь гэж үзэж болно.

Ийнхүү Монголчуудын тэнгэрийн үзэл эрх зүйн соёл, сэтгэлгээнд төгөлдөржсөн үнэний тухай, шударга ёс, тэнгэрлэг ёс суртахуун, түүнд нийцсэн ёс заншил, хэв ёсыг бий болгох оюун санааны эх үндсийг бий болгосон гэж үзэж болно.

2. Монголчуудын төр ёс, хууль цаазын сэтгэлгээний язгуур эх сурвалж нь: бусад улс үндэстний нэгэн адил шударга ёсны төсөөлөл, түүний шаардлагаар нөхцөлдсөн нь ажиглагддаг. Монголчуудын хувьд эртнээс шударга гэдэг ойлголт үнэн (үнэнч) гэдэг ухагдахуунтай ямагт ханьсан ойлгогдож ирсэн ба эл хоёр ойлголтыг сэлгүүлэн хэрэглэх нь нэн элбэг төдийгүй шударгыг үнэнээр дамжуулан тайлбарлах нь түүхэн эх сурвалжуудад түгээмэл тааралддаг. Тухайлбал, Илхаан Аргунаас 1289 онд францын хаан

¹⁴ А.Мостэрт, Ф.В.Клисс. Илхаан Аргун, Олзийт нараас 1289,1305 онд гоо Филиппт илгээсэн захидаауд. УБ., 1998. 86, 87 дахь тал.



ИЛ ХААН АРГУН, ӨЛЗИЙТ НАРААС 1289, 1305 ОНД ГОО ФИЛИППТ ИЛГЭЭСЭН ЗАХИДЛУУД ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

гоо Филиппт илгээсэн захидалд: “...Эдүгээ (чи) үнэн үгтээ хүрэн цэргүүдээ болзсон цагтаа илгээж Тэнгэрийн хишгээр тэр иргэдийг авбаас бид Иерусалемыг танд өгье. Цаг хугацаа хождож аваас нэмэлт цэргүүдээ явуулаад яхин зохих буй. Хожим гэмшивч ямар тус амуй...” мөн 1305 онд Илхаан Олзийтөөс илгээсэн захидалд: “...Таны Олон Франкуудын вангууд хамт хоорондоо зохилдож амуй хэмээн (бидэнд) айлтгасан билээ. Үнэн хүү зохилдохоос сайн юу байх билээ?...” хэмээн бичсэн байдаг.

Үнэхээр “үнэн зүйл өөрөө л шударга байдаг” гэх энэ сэтгэлгээ байгалийн нөхцөлд дулдуйдан амьдрах амьдралын хэв маяг, ерөөс тэмцэл тулааны хүчинд өөрийн төр ёсыг авч явах тэр ороо бусгаа орчинд нэн чухал шаардлага байсан бололтой. Тийм ч учраас Франкийн хаанд Илхаан Аргунаас илгээсэн захидал бол угтаа Франкийн хааны өөрийнх нь амлалтанд буюу Илхаан Аргуныг Египетийн Мамелюкуудтай дайтах тохиолдолд туслах цэрэг хөдөлгөн илгээх болно гэсэн түүний амлалт үгэнд хариу бичсэн захиа болно. Тиймээс Илхаан Аргунаас Франкийн хаан үнэн үг (амлалт үг)-тээ хүрэн 1) цэргүүдээ болзсон цагтаа илгээх; 2) тэнгэрийн хишгээр тэр иргэдийг авбаас; 3) бид Иерусламыг танд өгье гэсэн нь шударга бодитой байх тухай асуудал нь үнэн дээр л оршдог гэх монголчуудын сэтгэлгээний зүй тогтлыг илтгэсэн явдал болов уу. Ерөөс анд бололцох, болзох ёс журам бол XII зууны үеэс монголчуудын дунд нэлээд түгээмэл дэлгэрсэн, хүлээсэн үүрэг, болзсон цагаа биелүүлж занших үүргийн сэтгэлгээний тод хэлбэр байжээ. Үүний нэг нотолгоо бол “Монголын нууц товчоо”-ны 108 дугаар зүйлд:

“Бороотой боловч
Болзолд (ирье)
Хуртай боловч
Хуралд бүү хожидья
Монголчууд зээ андгаартан
Зээ гээд хожидсоныг,

Зэргээс гаргая”¹⁵ гэж өгүүлсэн байдаг. Энэ нь нэгэнт хүлээн авсан үүргээ (үгээ) ямар ч үед гуйвалтгүй биелүүлэх ёстой гэсэн үг. Тийм учраас Илхаан Аргунаас Филиппт хэлсэн үгэнд “...Цаг хугацаа хождож аваас нэмэлт

¹⁵ Х.Пэрлээ. Гурван өгүүллэл. УБ., 1962. 27 дахь тал



цэргүүдээ явуулаад яахин зохих буй. Хожим гэмшивч ямар тус амуй” хэмээн өгүүлсэн байдаг.

3. Эв эеийн үзэл санаа монголын төр ёс, соён гэгээрлийн бүх сургаал номлолд шингэсэн байдаг. Тухайлбал,

Ер хоёр хүн эвтэй бол
Төмөр хүрээ мэт бэх
Хорин хүн эв үгүй болбоос
Эвдэрхий хүрээ мэт хэврэг
Онөр хүн эв үгүй бол
Ончин хүний элэг болох
Олон хүн эв үгүй бол

Оорцог хүний идэн¹⁶ болно гэж Оюун түлхүүрт заасан бол “Нууц товчоо”-н дахь эв нэгдлийн тухай Алангуа эхийн домог зэргийг дурьдаж болно. Энэ-иргэн улс дотор эс эвийг олуулах хэв ёс, хууль цаазын цэгцтэй бодлого байж үзэл, сургаал оршиж, хэрэгжиж улмаар үе дамжин хөгжсөн түүхэн сэтгэлгээ болсон бизээ. Тиймээс ч эл үзэл санаа, сэтгэлгээ бусад оронтой найрамдах, эс эвийг хичээхэд нөлөө үзүүлсэн нь 1305 оны Илхаан Олзийтийн захианаас тодорхой харагдана. Тухайлбал, “...*Эртнээс франкуудын султан та бүхэн бидний сайн элэни, сайн өвөг, сайн эцэг, сайн ахтай найрамдаж хол боловч ойр мэт санаж аливаа үгсээ өчиж элчингүүдээ (болон) эсэн мэндийн бэлгээ солилцож ирснийг яахин умартах буй. ...өмнө засаглаж байсан (хаад) сайчуудтай (та нарын) зөвшилцсөнийг хэрхэвч өмтгойдуулахгүйгээр, (харин ч), андгай мэт үзэн урьдаас бүр ч үлэмж (та бүхэнтэй) найрамдаж элч нараа харилцан илгээхийг зорьж амуй. ...Эдүгээ манай сайн өвгөд дээдэс (манай) сайн эцэг (манай) сайн ахтай (та бүхний) найрамдаж харилцсаныг яахин бид огоорох билээ хэмээж Мамал (а)-г, Томан эд (энэ) хоёрыг илгээв” хэмээн захиандаа бичсэн байдаг. Үүнээс гадна, эв эеийг эс огоорох нь ямар их хор хохиролд хүргэж болох хийгээд эв эеийг хичээх нь үлэмж их тус, ач холбогдолтойг чухал болгон өгүүлсэн байдаг. Тодруулбал, тус захианд: “...*Ах дүү бид нар муу харцасын ташаа (хорлолт) үгнээс (шалтгаалж) бие биедээ (өлцөн нь) дургүй болсон билээ. Эдүгээ Тэнгэрийн**

¹⁶ Ц.Дамдинсүрэн. Монголын уран зохиолын дээж зуун биэлэг оршинов. УБ., 1959.53 дахь тал



соёрхолыг хүртсэн Чингис хааны ургууд Томорхаан, Тогтога, Цабар, Дуга тэргүүтэн бид дочин таван жилээс нааш энэ хүртэл хэрэлдэцгээж эдүгээ Тэнгэрийн ивээлээр ах дүү бид бүгд зохилдож наран ургах Нанхиадуудын газраас Талу тэнгис хүртэл (манай) улс гүрнүүд холбогдож (=холбоо харилцаагаа сэргээж) (өртөө) замуудаа байгуулав. ...Бидний завсар хэн (хэн нэгэн) бус сэтгэвээс (буруу санаа өвөрлөвөөс) бүгдээрээ хамсарч тэдний дээр байя (тэдний эсрэг босно) хэмээн үг хэлэцэн тогтов” хэмээжээ.

Тэгэхлээр эл захианы гол зангилаа, эцсийн цэг болох асуудал бол эе эвийн үзэл дээр суурилж байгаа нь тодорхой мэт. Тийм ч учраас, энэхүү захианы төгсгөлд: “...Таны Олон Франкуудын вангууд хамт хоорондоо зохилдож амуй хэмээн (бидэнд) айлтгасан билээ. Үнэн хүү зохилдохоос сайн юу байх билээ?” хэмээгээд “...Эдүгээ бадэнтэй болон та нартай үл эвсэгчдийн эсрэг Тэнгэрийн хүчинд бүгдээрээ хамсарч тэмцэхийг Тэнгэр мэдтүгэй” хэмээн төгсгөсөн байдаг.

Мэдээж энэ захиа бичигдсэн тэр түүхэн үе бол Монгол гүрэн задарч олон хэсэг биеэ даасан улсууд болж, хүч чадал нь суларч ирэхийн хамт дипломат бодлогод ч зохих өөрчлөлт гарч эхэлсэн ийм л үе байлаа. Энэ үеэс монголын хаадын дипломат бодлогод ч зохих өөрчлөлт гарч эхэлсэн байна. Оөрөөр хэлбэл, энэ үеийн монголын хаадын дипломат сэтгэлгээ нь нэгэнт эзэлж авсан орон газар, байр сууриа хамгаалах, гадаад зөрчлөө зөөлрүүлэх, дотоод хямралаа зогсоох, элбэн тохинуулахад чиглэгдэх болжээ. Тийм ч учраас дээрхи Ил хаан Олзийтөөс гоо Филиппт бичсэн захидалд улс түмний хооронд найртай сайхан харилцаа тогтоохын чухлыг зааж, энх тайвныг эрхэмлэсэн “үнэнхүү зохилдохоос сайн юу байх билээ” хэмээх санааг илэрхийлэн гаргажээ. Энэ бол тэр үедээ шинэ бөгөөд чухаг санаа байлаа.¹⁷ Энэ санаа нь бусад улсад Монгол улсыг дагасугай хэмээн тулган шаардаж байсан Чингисийн үеийн бодлогын халаа болон гарч иржээ. Тодруулбал, олон улстай харилцахдаа эрх тэгш харилцах ёс ба хүчээр түрээ үл барих, гэрээ хэлэлцээртээ үнэнч байх гэсэн зарчмууд болон төвийг сахин суугаа улс иргэнийг найрамдалтайгаар үзэх ёс энэ түүхэн үед хүчтэй үйлчилж

¹⁷ Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 2002.2 дахь хэвлэл. 176 дахь тал.



байсны жишээ болно. Тиймдээ ч өдгөө олон улсын харилцааны түүхэнд анх удаа нэг улс нөгөө улсдаа дайн зарлалгүй халдан довтлохыг хориглосон хүн бол Чингис хаан хэмээн судлаачид батлан нотлодог. Тэдбээр "...аливаа аян дайн хийхдээ заавал элч илгээж, нөгөө талаас найрамдах, эсхүл дайтах тухай хариуг авсны дараа эцсийн шийдвэр гаргадаг байжээ"¹⁸ хэмээн судалгааны бүтээлдээ нотлон өгүүлсэн байдаг.¹⁹ Мөн судлаачид олон улсын эрх зүйн харилцааны хөгжилд болон олон улсын харилцааны зохицуулалтын механизмд монголчуудын оруулсан түүхэн гавъяаг дурьдан баримт, эх сурвалжийн нотолгостойгоор өгүүлсэн байдаг. Энэ тухай дээрхи судлаачдын санаа, үзэл баримтлал, түүхэн нотолгоонуудыг болон өөрийн судалсан судалгааныхаа хамтаар энэ удаа энэхүү өгүүлэлдээ өгүүлэн бичихийг төвдсөнгүй.

Ийнхүү энд төгсгөл болгон өөрийн өгүүллээ эхлэхдээ эхэлсэн үгийг дахин давхцуулан хэлэхэд, өгүүллээ бичих тэрхэн үед эрх зүй, төрийн онол, түүхийн судлаач, хуульч хувьдаа асуудлыг өөрөөсөө эхэлж, эрх зүйн орчин буюу төр ёс, эрх зүйн сэтгэлгээний асуудал руу хандуулж авч үзмээр санагдсан билээ.

¹⁸ Ж.Бор. Билгүүн дипломат Чингис. УБ., 1994. 51 дэх тал.

¹⁹ G.Vernadski. The Scope and Contents of Chingis Khan's Yasa. Brussel 1339.p.13, M.Rossabi. Khubilai Khan. California University.1988. ба дээр нэр дурлагдсан бусад номуудаас дэлгэрүүлэн харж болно.



МОНГОЛД ГАЗРЫГ ХУВЬД ӨМЧИЛЖ БАЙСАН ЭСЭХ ТАЛААРХИ
ТҮҮХЭН МАРГААН, ТҮҮНД ХИЙСЭН ТҮҮХ,
ФИЛОСОФИ, ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ

*Философийн доктор (Ph.D), хууль зүйн шинжлэх ухааны
доктор (Sc.D), профессор Н.Лүндэндорж*

Миний бие “Монголын газрын эрх зүйн харилцааны түүхэн хөгжил” гэсэн өгүүдэлийг “Шихихутуг” сэтгүүлд нийтлүүлсэн. Тэр өгүүдэлд монголын газрын эрх зүйн харилцааны түүхэн онцлогийг “азийн үйлдвэрлэлийн арга”-ын үзэл баримтлалын үүднээс авч үзэж, “газар- улсын үндэс” гэж үзэж ирсэн монголчуудын төрийн философийн зарим асуудлыг хөндсөн билээ. Үүнийг давталгүйгээр монголчууд “газар” гэсэн ойлголтыг “нутаг билчээр”-тэй бараг адилтган ойлгож, цөөн тооны хүмүүс нутаг билчээрийг эзэмшиж, жирийн малчид эдлэн хэрэглэж, улс өмчилж байсан түүхэн харилцаа, түүнийг судлаачид хэрхэн тайлбарлаж ирсэн талаар одоо өгүүлэх болно.

Монголчуудын газарт хандах хандлага, эрх зүйн болон эдийн засгийн харилцаа суурьшмал орны иргэдээс эрс өөр байсныг тэмдэглэх хэрэгтэй. Суурин иргэншилтэй, аграр соёлтой улс гүрэнд “газар” гэсэн ойлголт эдийн засаг, эрх зүйн нарийн утгатай. Үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл, өмчийн зүйл, иргэний гүйлгээний хэрэгсэл, амь амьдралын салшгүй хэсэг гэж ойлгоно. Жишээ нь, эртний америкт нүүдэллэн очсон суурин улсын цагаачид газрыг дураар эзэмшиж, Эрнандо де Сотогийн (Hernando de Soto) хэлснээр “газрыг дураар эзэмших явдал үндэстнээсээ өөрөөс нь эрт үүсэж”¹, “томогавк” болон “овоохойн” эсвэл “суулгацын” хууль бус эрхийг үүсгэж, улмаар тэр нь цаашид газрыг албан ёсоор эзэмших, улмаар өмчлөх эрхийн үндсийг хүчээр, эрх зүйн дэг журмын гадуур бий болгож байсан² бол монголын нүүдэлчдэд үүнтэй төстэй ямар нэгэн үйлдэл, сэтгэлгээ илэрч

¹ Эрнандо де Сото (Hernando de Soto). Капиталин нууц / Англи хэлнээс орчуулсан Д.Энхзаяа / УБ., 2004, 105 дахь тал

² Мөн ном. 108-109 дэх тал



байсан баримт үгүй юм. Энэ бол нүүдлийн мал аж ахуйг нөхцөлдүүлсэн газар, түүн дээр бүрэлдсэн нүүдлийн соёлын онцлог байв.

Монголд газрыг хувьд өмчлүүлж байсан эсэхийн талаар бараг нэг жарны турш маргаж, социалист байгуулалын он жилүүдэд бүхэлдээ өмчилж байсан гэсэн үзэл жин дарж ирлээ. Ийм дүгнэлтийг тухайн үеийн албан ёсны “онол”, жуулчдын замын тэмдэглэл, нэр хүндтэй зарим судлаачдын үзэл бодолд тулгуурлан хийж иржээ. Энэ дүгнэлт монголын нийгэмд газрыг хувьд өмчлөх хэрэгцээ, шаардлагыг төрүүлсэн нийгэм, эдийн засгийн нөхцөл, иргэншлийн хэв шинж байсан эсэхэд тулгуурлаагүй, зөвхөн монголд формацийн онол тохирч байгаа гэдгийг батлахыг зорьж байснаас үүдсэн дүгнэлт юм.

Монголчуудын газрын эрх зүйн харилцаа, түүний агуулгыг нүүдлийн соёлын онцлогтой, харин газрыг хувьд өмчилж байсан эсэхийг газартай харилцаж байсан арга, ухаан, соёлын төвшинг шалгуур болгон авч үзэх ёстой.

Нүүдлийн соёлтой, мал аж ахуй эрхлэдэг үндэстний хувьд газрыг өмчилж, иргэний гүйлгээнд оруулж, ашиг шимийг аграр соёлын аргаар хүртэх тухай ойлголт нэн бүрхэг байсан юм. Газрыг улсын үндэс, нутаг дэвсгэр, нутаг билчээр гэж ойлгож, “газар эх, тэнгэр эцэг” хэмээн хүндэтгэж, эх болсон газрыг эзэн хаанаас өөр хэн ч дур мэдэн таслан хуваах, бусдад хувь өмч болгон өгөх, эзэмшүүлэх ёсгүй гэсэн сэтгэлгээ төр ёсны сургаалын нэгэн үндэс болж байсан юм. Үүний улмаас жирийн малчин билчээрийн мал аж ахуйн хүрээнээс хальж, газрыг хувьд өмчилж, иргэний гүйлгээний хэрэгсэл болгон ашиглах арга, ухаанд нүүдэлчин монголчууд хүрээгүй байсан юм.

Оросын эрдэмтэн В.А.Рязановский монголчууд газрыг хувьдаа өмчилнө гэдгийг мэддэггүй байсан¹ гэсэн нь оргүй зүйл биш юм. Академич Н.Ишжамц агсаны монголчууд “Газрыг өмчлөх, эзэмших, эдлэн хэрэглэх ийм гурван тодорхой зэрэг дэвийн ялгаа, нарийн нандин дэг журам эгнэгт мөрдөгдөж, амьдралд хэрэгжиж”² байсан гэсэн нь жирийн малчдын тухайд бус харин монгол төрийн бодлогод холбогдох зүйл гэж хэлмээр байна.

Тийм учраас монголын өнгөрсөн үеийн бүх түүхэнд газар нутгийн

¹ Рязановский В.А. Великая Яса Чингис хана. Харбин. 1933, с. 66

² Н.Ишжамцанс Улсын биг хурлын дарга, гишүүдэл биеэн захидаас /Монгол улсын сөнхийлөгчийн тамгын газрын архив/. Гадаад орнуудын Үндсэн хуулийн талаар судалсан зүйлтэй холбогдох материал. III боть, 1991, 246-247 дахь тал



цорын ганц дээд өмчлөгч нь төр-улсын эзэн хаан байж, түмт, мянгатын ноёд, аймгийн хан, хошууны засаг ноёд тус тусын газар нутгийг бусдад эзэмшүүлэх, захиран зарцуулах зэргээр өмчлөх эрхийн агуулгыг хэрэгжүүлдэггүй байсан. Жирийн малчид газар нутгийг зөвхөн эдлэн хэрэглэдэг байв. Тэд нутаг билчээрийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй. Зөвхөн улсын хаан л хувь хүний хувьд бус, төрийн тэргүүний хувьд нутаг билчээрийг өмчилнө. Харин эзэн хаанаас монголын төрд онцгой гавьяа байгуулсан хүмүүс, алтан ургийнханд нутаг билчээрийг эзэмшүүлж байсан нь баттай мэдээ юм. Уг асуудлыг монгол судлаачид багагүй судалж, зөв чиг хандлагыг нэгэнт тогтоосон байна.

Тэгэхлээр, газар нутгийг эзэмших, эдлэн хэрэглэх, захиран зарцуулах эрх зөвхөн улсын хаанд хадгалагдаж, эзэн хаанаас эрх олгосон хүмүүс эзэмшиж, жирийн малчид эдлэн хэрэглэж байсан гэж үзэх нь зүйд нийцнэ.

Чингис хаан монголын төрд онцгой гавьяа байгуулсан хүмүүст болон алтан ургийнханд нутаг билчээрийг “нутаг дархлах”⁵, “түшээ”⁶, “инж”, “соёрхол” гэсэн харьцангуй эзэмшлийн хэлбэрээр олгож байсан нь өөрийгөө өмчлөгч гэдгийг гаргууд мэдэрч, газар- улсын үндэс учраас хэнд ч хувь өмч болгон өгөх ёсгүй гэсэн хатуу зарчим байсны илрэл мөн. Эзэмшлийн эдгээр хэлбэр нь дундад зууны үед европод байсан газар эзэмшлийн бенефицийтэй (beneficium) ихээхэн төстэй. Тухайлбал, эзэн хаанаас үзэмжээр олгодог, шан харамжийн шинжтэй, гавьяа зүтгэл, өөртөө үнэнч алба хаших болзол болгож газрыг насан туршийн эзэмшилд нь олгож байсан зэргийг дурьдаж болно. Харин Европын бенефиций нь овлох эрхгүй байсан бол монголын газар эзэмшлийн дээр дурьдсан хэлбэрүүд “Монголын нууц товчоо”-д зааснаар “ургийн урагт хүртэл” эзэмших эрхтэй байжээ. Энэ ялгаа өргөн уудам нутаг дэвсгэртэй, нүүдлийн соёлтой үндэстний зүй ёсны онцлог байсан бизээ.

Харин улсын хаан бусдад өөрийн өмчлөлийн газраас урт хугацаагаар нутаг билчээрийг эзэмших эрх олгож байсан нь монголын эзэнт гүрний үед болон цааш цаашдаа ямар утгатай, түүний эдийн засаг, улс төр, хууль зүйн агуулгыг эргэцүүлэн тунгаах нь чухал. Үүнийг монголд төдийлэн судлаагүй билээ.

⁵ Монголын нууц товчоо. 219-р зүйл

⁶ Ratchnevsky P. Zum Ausdruck “Tushsia” in der Mongolenzeit. A.F. Band17, 1966. Шинобу Инамура. Монголу шякай ксидзайши но кенкю. Киото. 1968, 410-411.



Энэ асуудалд холбогдуулан дараах бүрдэл хэсгийг тодруулан хэлж болмоор байна.

1. Нутаг билчээрийг зөвхөн эзэн хаан төрд онцгой гавьяа байгуулсан болон алтан ургийн хүмүүст эзэмших эрх олгодог байсан нь нутаг билчээрийг эрхэм чухалд үзэж, улсын үндэс болсон газар нутгаас үргэлжид эзэмших эрх олгохыг хамгийн дээд хишиг, хүндэтгэл гэж үзэж байсны нотолгоо юм. Энэ бол монголчууд газар нутгаа хэрхэн үнэлж дээдэлдэг, эрхэм чухал зүйл гэж үзэж байсны тод гэрч мөн.

2. Эзэмшил газар нутгийг хугацаагүйгээр, МНТ-ны 219-д өгүүлснээр “ургийн урагт хүртэл хорчилж (ан ав хийж), өтөглөж (өвөлжөө бууцаа засаж, хүн, малаа тогтвортой байршуулах)” байх тухай заажээ. Энэ нь маш удаан хугацаагаар гэсэн утгыг илтгэж байгаа тул газар нутгийг хувь өмчид өгөөгүй гэдгийг давхар илэрхийлэхийн зэрэгцээ эзэмшлийн энэ хэлбэр өвлөх эрхтэйг давхар харуулж буй юм.

3. Газар эзэмшлийг зөвхөн байгалийн төрөл зүйлээр бус түүн дээр амьдарч суугаа хүн зонтой хамтад нь цогц байдлаар ойлгож байсан нь газрыг иргэний гүйлгээний шууд хэрэгсэл гэж үзээгүй мал, малчдаар дамжуулан үр шимийг хүртэх утгаар газрыг нутаг билчээр, мал, малчинтай хамт үнэлдэг нүүдэлчдийн сэтгэлгээний онцлогийг агуулсан байна.

4. Эзэмшилд өгсөн газар нутаг одоогийнх шиг 1-2 га бус том орон зайг хамарч байсан. Энэ нь газар эзэмшлийн зорилго, зориулалтыг илэрхийлж буй хэрэг. Малчин хүнд нутаг билчээр өргөн уудам байх нь баян чинээлэг, малын хөл олон байх суурь учраас эзэмших зориулалтаас үүдэн өргөн уудам нутгийг эзэмшүүлж байсан байхаа.

5. Эзэмшил нутаг нь харьцангуй бие даасан, засаг захиргааны нэгж байдлаар оршдог байсан. Түүхийн баримт сөхвөл газар нутаг эзэмшлийн “нутаг дархлах”, “түшээ”, “инж”, “соёрхол” хэлбэр зөвхөн нутаг билчээрийг хараа хяналтандаа байлгаж, эдлэн хэрэглэж, үр шимийг үргэлжид ашиглахаас гадна тэрхүү нутаг дэвсгэрт амьдарч буй ард олныг захирч байх засаг захиргааны онцгой эрхийг давхар эдэлж⁷, алба татвар бариулж байсан гэж үзэж болно. Түүхийн эл үед монгол орноор аялан явсан хятад түшмэл

⁷ Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978. 56 дахь тал



Пэн-Да-я, Сюй-Тин нарын тэмдэглэлд “Миний (Сюй Тиний) явж өнгөрсөн энэхүү говь цөл газарт татарын хаан бусад хууль ёсны бус хатан, хан хөвүүд, гүнж, төрөл садан тэднээс доошхи хүмүүсээс эхлээд цөм эзэмшил газартай. Тэдний бүх хүн (уг эзэмшил газарт суудаг) үхэр, шар, морь, хөсөг тэрэг, зэр зэвсэг, ажлын хүн, хонины мах, гүүний айраг, зэргээр (ээдэд) алба нийлүүлдэг”⁸ гэжээ. Мөн акедемич Ш.Нацагдорж агсан нутаг билчээрийн харьцангуй эзэмшлийн нэг хэлбэр-“түшээ”, “түүний толгойлогч өөрийнхөө аймгийн газар нутаг, хүн амыг захиран өмчлөгч”⁹ байсан гэжээ. Японы эрдэмтэн С.Ивамура эзэн хаанаас үргэлжид эзэмшүүлэхээр заасан нутаг мянганы тогтолцоонд багтдаггүй, бие даасан байдлаар оршиж байсан гэж үзсэнийг монголын түүхчид хүлээн зөвшөөрч байгаа болно.

б. Эзэмших эрхийн агуулгыг зөв тусгаж байсан учраас эзэмшил нутгаас бусдад шилжүүлэх худалдах зэрэг захиран зарцуулах эрхийг эдэлдэггүй байсан.

Эртнээс улбаатай нутаг билчээрийн энэ эзэмшлийг зарим судлаачид¹⁰ газар өмчлөлийн хэлбэр гэж судалгааны андууралд хүрч байсан. Үүний уг үндэс газар нутгийг цөөн тооны хүмүүс эзэмшиж байсан уу, өмчилж байсан уу гэсэн асуудал нь нарийн ээдрээтэйд бус гагцхүү марксист арга барил, үзэл суртал, формацийн онолын үүднээс монголд феодализм оршиж байсан гэдгийг батлахын тулд газрыг хувьд өмчилж байсан гэж хэлэхэд зүй ёсоор хүрснийг дээр тэмдэглэсэн билээ. Тухайлбал, акедемич Ш.Нацагдорж агсны өөрийн төрөлх үзэл нь формацийн “албан ёсны” онолтой зөрчилдөж байсан нь түүний бүтээлээс харагдана. Тэрээр бичихдээ “Нүүдэлчин бүх ард түмний дотроос монголчуудад газар эзэмших феодад ёс нилээд хөгжсөн гэж үздэг нь үнэний талтай юм. “Монголын нууц товчоо”, “Юан улсын судар”, Рашид-ад-диний “Судрын чуулган” зэрэг бусад бичиг сударт феодалын газар эзэмшлийн тухай цөөнгүй гардаг бөгөөд дорно дахинд тухайлбал, Монголд газар нь улсын өмч байсан нь феодалын газрын өмчийн нэгэн хэлбэр боловч газрыг улс өмчлөхийн зэрэгцээ феодалууд хувьдаа өмчлөх ёс бас байжээ. Газар өмчлөгч нь феодалын улс уу, эсхүл феодалын язгуур угсаа юу, үгүй бол газар нь хувь феодалуудын өмч үү гэдэг нь уул асуудлыг тодорхойлоход

⁸ Мөн ном. 55 дахь тал

⁹ Мөн ном. 56 дахь тал

¹⁰ Ш.Нацагдорж, Д.Гонгор, Н.Жагпарал, С.Жилан-Аажав, И.Дашням зэрэг эрдэмтэн



төдий л чухал биш юм. Эдгээрийн **алли ч бай (тодруулсан-Н.Л)** газар нь феодалын өмч байсныг батлах юм”¹¹ гэснээс харагдана. Ш.Нацагдорж агсан газрыг өмчилж байсан субъектыг хэн байсныг төдийлөн ач холбогдолгүй гэж үзсэн нь хаан буюу улсаас өөр субъект нотлогдохгүй байсантай холбоотой болов уу. Хэрэг дээрээ зөвхөн хаан буюу улс эсвэл хувь хүн өмчилж байсан эсэх нь хамгийн чухал билээ. Нөгөө талаас газар феодалуудын хувь өмч байсан гэдгийг нотлохын тулд К.Марксын хэлснээр газрын өмчийн эдийн засгийн биелэл болсон феодалын рент оршиж байсан гэдгийг нотлох шаардлагатай нь мэдээж. Феодалын рентын сонгодог агуулга аграр соёлтой оронд л яригдах нь ойлгомжтой боловч Ш.Нацагдорж болон бусад судлаачид нүүдлийн мал аж ахуйн оронд нутаг билчээр эдлэн хэрэглэсний үнэ төлөөс гэсэн нэртэй татвар өгч байгаагүйг хүлээн зөвшөөрч, мал аж ахуйн ашиг шимээс алба гувчуур өгч байсныг феодалын өмч-газрын рент¹² гэж үзэхэд хүрсэн байна. Зохиогчийн хувьд энэхүү “алба, гувчуур” бол феодалын газрын рент биш болов уу гэж үзэж байна. “Алба, гувчуур” буюу өнөөгийнхөөр татвар Д.Гонгор агсаны судалснаар Хиданы Ляо улсын сударт болон “Монголын нууц товчоон”-д “алба” хэмээх нэр үгүй ч “гувчуур буюу гувчихуй” гэсэн үг юмнаас юм татаж авах¹³ гэсэн утгаар хэрэглэжээ. 17-р зуунаас улсын чанартайг “алба”, ноёдын татлагыг “гувчуур” гэж салган нэрлэж, эдгээр нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эдийн засгийн эх сурвалж болж байсан байна. Албан баримтад “хан, ван, засгууд цөм өөрийн албатаас албан тэсгэхэд (татвар авахад) итгэж аж төрмүй. Албат болоод тус тусдаа харъят хан, ван засгуудад алба эс өгөх болвоос олон ван, засаг даруйд амь зуух зүйл үгүй болоход хүрмүй”¹⁴ гэсэн нь өөрийн хувь өмч газрыг эзэмшүүлж, эдлэн хэрэглэсний төлөө алба, гувчуур авах ёстой гэсэн байр сууриас бус, харин ард олны татварт итгэж амьдарч буй тухай өгүүлсэн нь тодорхой байна. Иргэд нь дайны олз, ан ав хийж олсон ашгаа эзэн хаандаа барьдаг нь эртний ёс юм. Энэ тухай МНТ-ны 219-д дайны болон ан гөрөөний

¹¹ Нацагдорж Ш. Монголын феодалзмын үндсэн замнал. УБ.,1978. 54-55 дахь тал

¹² Мөн номын 65 дахь тал, Гонгор Д. Хялх товчоо.

УБ., 1978, I боть, 302 дахь тал

¹³ Word-and Suffix- Index to the Secret History of the Mongols based on the Romanized transcription of *L. Ligeti*. Compiled by H. Kyriřayashi and Chojinjab, the center for Northeast Asian Studies Tohoku University. 2001. Sendai, S. 368

¹⁴ Зуун зүйлийн бичиг. УНС. Гар бичмэл



олзоо нутаг дархалан өгсөн Сорхон шарыг өөрөө авч байх эрх олгосон нь үүнийг гэрчилнэ. Энэ мэтийг феодалын рент гэж батлахад нэн төвөгтэй төдийгүй арай андуу ташаа болох бизээ.

Тэгэхлээр, малчдаас эзэд нь авч байсан алба, гувчуур бол хувь өмч газрын рент бус, харин иргэн бүрийн төлдөг татвар байсан бололтой.

Монголын нэртэй түүхч агсан Д.Гонгор мөн л монголд феодализмын нийгмийн байгуулал оршиж байсан гэсэн формацийн онолын үүднээс газрын хувь өмч байсан гэдгийг нотлохыг оролдсон. Тэрээр мянганы ноёд болон бусад эрх олгосон хүмүүс газар нутгийг өмчилж байсан гэдгийг эртнээс билчээрийг зохистой ашиглуулах үүднээс нутаг усыг хувааж өгөх¹⁵, заан олгох¹⁶, зарим нутагт жирийн малчдыг нутаглахыг хориглох¹⁷, алтан ургийнхан заасан нутгаа эзэмших¹⁸, нутаг шагнах¹⁹ зэрэг улиран эзэмших эрх болон хожуу үеийн хууль цаазад тусгай зориулалтаар төрөөс хамгаалсан, хот хүрээ байгуулахаар товлосон (“их нутаг”, “өргөө буух газар”, “хүрээ засах газар”, “ихэсийн онголсон газар”, “их авын газар”) газрыг феодалын газар өмчлөлийн хэлбэр гэж үзсэн нь мөн л феодализмын нийгэм, эдийн засгийн байгуулалыг оршиж байсан гэдгийг баталж, улмаар формацийн онолыг зөв гэдгийг харуулахад чиглэсэн гэж үзэж болно.

Харин эдгээр эзэмшлийн хэлбэрийг эзэн хаанаас төрд онцгой гавьяа байгуулсан хүмүүсийг нутаг билчээрийг үе улиран эзэмших эрх олгож, төрийн түшээ нарыг төрд үнэнч зүтгэх эдийн засгийн сонирхлыг төрүүлэх, бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх ямбыг өргөтгөх үүднээс харьяа нутаг билчээрт эзэмшлийн хүрээний эрх олгож байсан гэж үзэх нь одоо мэдэгдэж байгаа судалгааны эх сурвалжуудын хүрээнд үнэмшил бүхий юм.

Ер нь монголын судлаачид газар нутаг өмчлөл Их Монгол улсын үеэс эхэлсэн гэж нэг хэсэг нь үзсэн бол зарим нь (академич агсан Ш.Нацагдорж, Н.Ишжамц, Д.Гонгор, профессор С.Жалан-Аажав Ц.Гомбосүрэн) манжид дагаар орохын өмнөх улс төрийн бутралын цаг үетэй холбон авч үзжээ. Тухайлбал, академич агсан Ш.Нацагдорж “Манж нарт эзлэгдэхийн өмнө

¹⁵ Монголын нууц товчоо 279 дэх зүйл

¹⁶ Путешествие в восточные страны Плато-Карпини и Рубрука. М., 1957. с.45

¹⁷ Монголын нууц товчоо 179 дэх зүйл

¹⁸ Мөн тэнд 65 дэх зүйл

¹⁹ Мөн тэнд 207, 219 дэх зүйл



Монголд газар феодалын бүрэн өмч байв”²⁰ гэсэн бол Н.Ишжамц гуай “Ноёд газар өмчлөх болсон нь Монгол гүрэн мөхөсний дараа төвийн засаг суларсан феодалын бутралын үед хамаарна”²¹, Н.Гонгор гуай “Чингис хаан амьд ахуй цагт хан хөвгүүд, алтан ургийнхан, бас зарим шадар нохөрлогчид, төрд зүтгэсэн гавьяатан сайд жанжин нарт хувь өмч буюу газар нутаг, албат иргэн таслан олгож эзэмшүүлсэн нь яваандаа тэдхий үе улирсан эзэмшил болон хувирч феодалын бутрал үүсэхийн эх суурь тавигджээ”²², Ц.Гомбосүрэн “монголын уламжлалт нийгмийн үед хувийн газрын өмч үүсэх байдал манай улсын түүхэн дэх бутралын үе гэж нэрлэгддэг тэр үед харин байжээ. Энэ бол монгол улсын нийтийн үйл хэрэгийг удирдаахад эзэн хааны хүч чадал, засаглах чадал суларч, том язгууртан ноёдын улс төр, эдийн засаг, цэргийн бие даасан байдал бэхжиж байсан тийм үе юм. Тийм том ноёд харьяа нутаг дэвсгэрээ өмчлөгч нар болж хувирч байжээ”²³ гэж тус тус бичсэн байна. Эдгээр эрдэмтэдийн дүгнэлт санал хэр зэрэг үндэслэлтэй вэ гэсэн асуулт гарч байна. Үүнд холбогдуулан дараах тайлбар, тодруулгыг хийж болох юм.

Нэгдүгээрт, улс төрийн бутралын үед газар өмчлөл баттай байсан гэдгийг Чингис хаан зарим хүмүүст өвлөх эрхтэйгээр газар нутгийг хугацаагүйгээр эзэмшүүлсэн, насан өөд болохын өмнө эрх мэдлийн тэмцлээс сэрэмжилж хан хөвгүүддээ газар нутгийг хуваан эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасны түүхэн үргэлжилтэй холбон авч үзсэн бололтой. Энэ ч зүйн хэрэг. Хөгжлийн онолын үүднээс болон дэлхийн улс түмний түүхээс харахад газар эзэмшил нь түүхэн хөгжлийн явцад өмчлөл болон хувирч байсан тул монголд ч өмчлөлийн шинж рүү улам бүр ойртсон байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Жишээ нь, Европод газар эзэмшлийн бенефицийн хэлбэрээс өмчлөлд шилжсэн зүй тогтлыг баримтлал болгосон байж болох юм.

Түүхийн ээдрээ зөрчилтэй энэ үед эзэнт гүрний үеийн нэгдмэл газар нутаг зургаан түмэн монголын ба дөрвөн түмэн ойрдын бас хан нарын газар нутагт хуваагдсан байсан нь түүхийн үнэн. Улмаар улс төрийн нэгдмэл чанар, нэгдсэн хууль эрх зүйн тогтолцоо нэгэнтээ алдагдаж, улс төрийн жижиг нэгдлүүдийн өмчлөлд газар нутаг дураар шилжсэнийг тухайн нэгдлүүдийн

²⁰ Нацагдорж Ш. Ар монголд гарсан ардын хөдөлгөөн. УБ., 1966, 9 дэх тал

²¹ Ишжамц Н. Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 1974, 97 дахь тал

²² Гонгор Д. Халх товчоон. УБ., 1978, 1 боть, 147 дахь тал

²³ Гомбосүрэн Ц. Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү. УБ., 22 дахь тал



газар нутгийг улс төрийн нэгдлийнх гэх үү, тухайн удирдагчдын хувь өмч байсан гэх үү зэрэг олон нарийн асуудал урган гарч байгаа юм. Эдгээр улс төрийн нэгдлийг хэрхэн авч үзэхээс газар нутгийн өмчлөлийн асуудал хамаарна гэж бодож байна.

Тэдгээрийг хууль ёсны улс төрийн нэгдэл- улс гэж эс үзвээс эзэнт гүрний нутгийг дураар хуваан өмчилсөн удирдагчид байсан гэж үзэхэд хүрнэ. Харин жижиг жижиг улс байсан гэж үзвээс тэнд газар нутаг улсынх байсан гэж үзэж болно. Дээрх судлаачид эдгээр бутарсан хэсгүүдийг улс төрийн нэгдэл- улс байсан гэж үзээгүй тул газрын хувийн өмч байсан гэж үзсэн бололтой.

Улс төрийн бутралын энэ үе бол Их Монгол улс байгуулагдахын өмнөх үетэй бараг бүх талаар адил нөхцөл байдал бүхий байсан гэж үзэж болохоор байна. Үүнтэй ижилсүүлэн авч үзвэл тэр үед газар удирдагчдын улсын өмч байсан нь эргэлзээгүй юм. Энэ тухай академич Ч.Далай 12-р зууны сүүлч, 13-р зууны эхэн үед "...мал сүрэг хувийн өмчид байсан хэдий боловч бэлчээр нутаг ус аймаг, овгийн өмч хэвээр байлаа"²⁴ гэсэн нь Хамаг Монголын үе үеийн хаадыг зөвхөн газрын эзэн байсан гэж үзээгүйг гэрчилнэ. Эдгээр нэгдлийг "овог, аймаг", "удирдагчийн улс", "төр улс" гэдгийн альнаар нэрлэсэн ч эцсийн эцэст бидний ярилцаж буй асуудлын хүрээнд газар нутаг хэн нэг иргэний, малчны, удирдагчийн хувь өмч байгаагүй, харин тухайн нэгдлийн өмч байсан нь эргэлзээгүй байхаа.

Энэ үүднээс улс төрийн бутралын үеийг авч үзвэл нэгдмэл улсын шинж нэгэнтээ алдагдаж, өөр өөр улс төрийн эрх мэдэл бүхий нэгдэл үүсэж, хууль эрх зүйн өөр өөрийн дэг ёстой удирдагчдын улс бодитой байсан тул тэдгээрийг зөвхөн газрын эзэд байсан гэж үзэж болмооргүй байна. Нөгөө талаас жижиг улсуудын дотор удирдагчдын нэгдлээс өөр субъект газрыг хувьд өмчилж байсан тухай мэдээ сурвалж одий хүртэл илрээгүй байна.

Хоёрдугаарт, Елюй Чуцайн хэлсэн баримтыг үндэс болгосон болов уу. Гэвч Елюй Чуцайн хэлсэн үг ихээхэн эргэлзээтэй. Чингис хаан хөвгүүддээ газар нутгийг хувь өмч болгон хуваан өгсөн гэж үзэх нь түүний төр ёсны ерөнхий зарчимтай эрс зөрчилдөж байгаа тул эргэлзээ энд байгаа юм. Нэгдсэн төрийн төлөө бүх амьдралаа зориулсан, тэр зорилгодоо гайхамшигтайгаар хүрсэн Чингис хаан төрөлх гэмээр өөрийн үзлээсээ ухарч,

²⁴ Далай Ч. Их Монгол улс (1206-1260), УБ., 1994, Дэл лэйгэр, 35 дахь тал



нэгдмэл төр улсаа задлан бутаргах эх үүсвэрийг тавьсан гэж үзэхэд үнэхээр бэрх билээ. Харин эзэнт гүрний өргөн уудам нутгийг нэгдсэн төрийн дор хөвгүүдээ үеийн үүрд хуваан эзмшиж явах нь төр ёсны нэгдмэл чанарыг хадгалах нэг арга гэж үзсэн байж болох юм. Газар нутгийн нэгдмэл чанар бол улс гүрэн хүчтэй байхын үндэс гэсэн дорнын төр ёсны сургаалаар хүмүүжсэн, тэр үзэлд насан туршдаа тууштай байсан Чингис хаан хөвгүүддээ газар нутгийг хуваан өмчлүүлэх тухай шийдвэр гаргасан гэж үзэх нь итгэлтэй биш санагдаж байна.

Тэгэхлээр, улс төрийн бутралын үеэс газар нутгийг хувьд өмчлүүлэх болсон гэсэн үзэл мөн л батлагдахгүй мэт санагдана.

Одоо монголд газар хувь өмч байгаагүй зөвхөн улсын өмч байсан гэж үзэж байсан судлаачдын судалгааны дүгнэлтийн үндэслэлд та бүхний анхаарлыг хандуулъя. Ийм үзлийг баримталж байсан судлаачид (академич Н.Ишжамц, Ч.Далай, доктор Г.Сүхбаатар, Т.Сэнгэдорж, О.Амархүү нар) (1) газар нутгийг хувь өмч болгож байсан түүхийн болон хууль цаазын мэдээ байхгүй гэдгийг иш үндэс болгож, Чингис хаан ч монголын газар нутгийг өөрийнхөө хувийн өмч боллоо гэж зарласан баримт түүхнээ байхгүйг²⁵, (2) нүүдлийн мал аж ахуйн арга ажиллагааны онцлогтой холбон авч үзэж, зогсоо зайгүй нүүдэллэн аж төрөх ёс нь газар нутгийг хувьд өмчлүүлэхийг зөвшөөрөөгүйтэй,²⁶ (3) монголын хаад ноёд газрыг хувь өмч болгон өгвөөс улсын үндэс эвдэрч, төвөөс зугтах хүчин бий болж, улсын нэгдмэл чанар задарна гэж үзсэн улс төрийн болгоомжлолоос, (4) монголын газар, түүний хөрс ургамалын даац газар нутгийг хувь өмч болгохыг нөхцөлдүүлээгүй зэрэг үндэслэлд тулгуурласан байна.

Одоо эдгээр судалгааны үндэслэлд тулгуурлан монголчууд газрыг хувь өмч болгоогүйн учрын талаар зарим бодрол эргэцүүллийг хийе.

Монголчуудын газрыг хувьдаа өмчилж ирээгүйг капиталын нууцыг нээн ойлгох хөгжлийн төвшин, чадваргүйтэй холбоотойгоос гадна малаар дамжуулж газрыг ашигладаг нүүдлийн мал аж ахуйн амьдралын хэв шинжийг нөхцөлдүүлсэн байгаль цаг агаар, түүнээс үүдэлтэй газрын хөрс, ургамлын онцлогтой холбон үзэх нь зүйтэй болов уу. Үүнээс хамаарч газарт хандах,

²⁵ Ишжамц Н. Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 1974. 77 дахь тал

²⁶ Далай Ч. Их Монгол улс (1206-1260). Дэл дэвтэр, УБ., 1994. 34-35 дахь тал



харилцах арга ухаан, төрийн бодлого, ёс төр бүрэлдэж, түүний тусгал болсон хууль цаазын баримтлал тогтсон бизээ.

Нүүдлийн мал аж ахуйн арга ажиллагаа газар нутгийг хувь өмч болгохыг зөвшөөрдөггүй гэдгийн үндэслэл юунд орших вэ гэсэн асуултыг тавьж болно. Монголчууд нүүдэлчин амьдралд дуртайдаа нүүдэлчин болсон гэж хэн ч баталж чадахгүй. Харин нүүдэл амьдралыг газар дэлхий нь шаардсан гэвэл илүү үнэн болно. Нүүдэлчид соёл, иргэншилээр дорой буурай хэдий ч суурин амьдрал, иргэншил давуу гэдгийг мэдэж байсан нь лавтай. Тийм ч учраас оросын эрдэмтэн А.М.Хазанов Чингис хааны байлдан дагууллыг эдийн засгийн агуулгатай²⁷ гэж үзсэн байдаг. Үнэндээ монголын нүүдэлчид суурин улс руу үе үе довтолж хэрэгцээтэй эд зүйлээ олж байсан нь тодорхой билээ.

Тэгэхлээр, нүүдэл амьдрал, газар нутаг хоёр салшгүй холбоотой, бие биеэ нөхцөлдүүлсэн байдаг учир монголын газар нутаг нүүдлийн амьдралыг монголчуудад бэлэглэжээ. Жилийн дөрвөн улиралд байгаль цаг агаараас хамааран ийш тийш нүүж, мал сүргээ адуулан маллаж, осгөж үржүүлэх нь нүүдэлчдийн байгалиас заяасан хөдөлмөрийн хуваарь юм. Үүнээс гажиж, нутаг билчээрийг хувь өмч болгон хашаа хороо барьж, суурин улс шиг фермерийн аж ахуй байгуулан аж төрөхийг газар ч, бэлчээрийн мал аж ахуй ч зөвшөөрдөггүй ажээ. Байгалийн энэ хуулийг хэн ч өөрчилж чаддагүй, болдоггүйд хэргийн учир оршино. Үүнийг анзаарч тэмдэглэсэн судлаачдын дүгнэлт бас цөөнгүй юм. Тухайлбал, академич Ш.Нацагдорж агсан монголчууд газар зүйн орчноос хамаарч нүүдлийн мал аж ахуйг эрхлэх болсныг тэмдэглээд “монгол орон бол Ази тивийн өндөрлөг бүсэнд багтаж, нутаг дэвсгэрийн ихэнх нь ээрэм тал, цөл, говь эзэлж, цаг уурын амьсгал эрс хатуу, хөрс шороо шим муутай, ус чийг ховорхон тул газар тариалангийн ажилд зохимжоор бага, харин мал адгуулан аж төрөхөд ихэд тохирсон нутаг ажээ.Түүхийн баримтаас үзэхэд монгол нутагт мал аж ахуй, тариаланг хослуулан хөгжүүлэх оролдлого нэг бус удаа гарсаар ирсэн боловч тариалангийн ажил цаашид биеэ даасан салбар болох ч байтугай мал аж ахуйтай хосолсон хэлбэрээр ч хөгжиж чадаагүй”²⁸ гэж монголын газар нутгийн онцлогийг тодорхойлсон байдаг.

²⁷ Хазанов А.М Социальная история скифов. М., 1975. с. 255-256

²⁸ Нацагдорж Ш. Монголын феодалзмын үндсэн замнал. УБ.,1978. 95 дахь тал



Монгол улсын Үндсэн хуульд өнөөдөр ч билчээрийг төрийн өмч мөн гэж заасан нь монголын малчид бэлчээрийг өнө эртнээс нийтээр эдэлж хэрэглэж ирсэн түүхэн зүй тогтлын тусгал гэж үзүүштэй.

Ийм онцлогтой, эмзэг хөрс шороотой газар нутгийг ашиглах зориулалт нь мал билчээж, малаар дамжуулан үр шимийг хүртэх зүй тогтолтой тул нутаг билчээрийг өдий хүртэл хувь өмчид шилжүүлээгүй байна. Төрөлх газар шороотойгоо зохицон амьдарч ирсэн нүүдэлчин монголчуудын энэ арга, ухаан өдгөө дэлхий дахинаа хүчтэй яригдаж байгаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай ч тохирч байгааг дурьдахад илүүдэхгүй.

Монголын хаад ноёд газар нутгийг хувь өмч болгоход улсын үндэс суларна гэсэн улс төрийн болгоомжлол үнэхээр байсан уу гэсэн асуудал судлаачдын сонирхол татсан асуудал юм. Чингис хаан таалал төгсөхийн өмнө төв монголын газар нутгийг өөрийн хөвгүүн Тулуйд, эзэлсэн бусад нутаг орныг бусад хөвгүүддээ хуваан огсөн тухай түүхийн баримт бий. Үүнээс өмнө монголчуудын түүхэнд ийм явдал гарч байгаагүйг төрийн их зөвлөх Елюй Чуцайгийн үг нотолдог. Тэрээр Чингис хааныг хөвгүүддээ газар нутгийг хуваан эзэмшүүлэх шийдвэр гаргасанд ихэд харамсан газар нутгийг үе улируулан эзэмшүүлж болохоос биш, хувь өмч болгож яаж болох вэ? Ингэхлээр л яваандаа төвөөс тэмүүлэх хүчин давамгайлж, улс гүрэн задархын үндэс тавигддаг юм хэмээн хоолой нь зангирч, нулимс дуслуулан хэлж байсан гэдэг²⁹. Чингис хааны төрийн их зөвлөх Елюй Чуцай нэгэнт ийм бодолтой байсан болохоор монголын төр ёсны номлолд тийм үзэл баримтлал байгаагүй буюу мэдэхгүй байсан гэж хэлэхийн аргагүй юм.

Монголын түүхийн болон төр, хууль цаазын одоо бидэнд нэгэнтээ ил болсон, уламжлан хадгалагдсан эх сурвалжуудад газрыг хугацаагүй дархлан эзэмшүүлж байснаас хувь өмч болгож байсан ямар нэгэн мэдээ сэлт одоо хир байхгүй байгаа юм.

Энэ асуудлыг доктор О.Амархүү нэлээд нарийн судалж, монголын эртний хууль цаазын дурсгалт баримт бичгүүдэд газар түүний баялгийг зөв зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, ан гөрөө хийх талаар бусад орнуудад хувийн өмчийн газрын эзний эрхээр шийдэгддэг асуудлыг монголд нийтээр

²⁹ Ишжамц Н. "Улсын бага хурлын дарга, гишүүдэд бичсэн захидал /Ерөнхийлогчийн тамгын газрын архив. ХН-52, III богь, 246-247-р тал



дагаж мөрдөх түгээмэл зохицуулалтын хүрээнд заан тодорхойлсон нь өмчийн эзэн зөвхөн төр байсныг давхар нотолж байна³⁰ гэсэн нь зөв дүгнэлт юм.

1640 оны Монгол Ойрадын “Их цааз”-аар ихэс дээдсэд зориулан ан ховрого хийх газар нутгийг мөн Юаны нэгэн адил хуулиар тусгайлан тогтоож, түүнийг бусдын эзэмшлээс хамгаалж байхаар заасан бол 1709 оны “Гурван хушууны Их цааз” буюу “Халх журам”-д тухайн үеийн нийгмийн дээд давхрааны төлөөлөгчид болох лам хувраг нарыг нутаглах газар нутгийг ноёдын өргөө гэр барихаас бусад газар тааллаараа сонгож нутаглахыг хуульчлан хамгаалж өгч байсан³¹ атлаа хувь өмч болгосон нэгээхэн заалт баримт байхгүй байна.

Энэ асуудлыг түүхийн талаас нэлээд нухацтай судалсан, монголын нэртэй түүхч агсан Г.Сүхбаатар “Их Монгол улсын үеийн Засаг хууль, 1640 оны Монгол- Ойрдын Их цааз, 1709 оны Халх журам зэрэг монголын хууль цаазын бичигт газрын хувийн өмчтэй холбогдож болмоор зүйл огт байхгүй”³² гэснээс давхар харагдана.

Манж-Чин гүрний үед Монголын газрын өмчлөлийн дээд субъект нь Манжийн хаан болон солигдож, албан баримтад Монголын газар нутгийг “Эзний (Манжийн хааны) албан газар” гэж нэрлэснээс өөр ямар нэг өмчлөгчийн эрхийг хөндсөн баримт бас байхгүй байна.

Богд хаант монгол улсын үеийн гол хууль-”Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-т газар, түүний баялаг улсын өмч гэснийг тал бүрээр нотолсон зүйл заалт олонтаа байна. Тухайлбал, тус хуулийн “Түшмэлийн засаг” хэмээх 10-р, “Битүү хулгах” хэмээх 51-р дэвтэрт нийт нутаг дэвсгэрийн байгалийн баялгийг хариуцан хамгаалж байх үүргийг харьяа засаг нарт ногдуулж, тэдгээрийн хариуцлагыг заажээ. Энд хувийн болон улсын гэж ялгаж заагласан зүйл үгүй бөгөөд хэрэв газрын хувь өмч байсан бол түүнийхээ баялгийг ашиглах, хянах, хамгаалах эрх, үүрэг нь засаг ноёнд бус, харин газрын эзэнд байх нь эрх биш ойлгомжтой билээ.

Энэ үед газрыг хувь хүн өмчилдэггүй байсан гэдгийн өөр нэг том нотолгоо бол Богдын засгийн газар 1916 онд “Монгол улсын хөрөнгийг

³⁰ Амархүү О. Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз. УБ., 2000. 63 дахь тал

³¹ Мөн ном. 39, 44-45, 55-69 дахь тал

³² Сүхбаатар Г. Газар ба БНМАУ-ын тусгаар тогтнол. Ардын эрх. 1991.11.07. №195(267)



захирах газар”-ыг байгуулж, түүний үйл ажиллагааны дүрэмд “Тус улсын байгалийн бүх баялаг, ой, мод, ус, элдэв уурхай, ашиглаж буй ба ашиглаж болох сул газар цөм Монгол улсын хөрөнгө мөн” хэмээн заажээ.

Олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны дөрвөн сарын 21 буюу Европын 1921 оны таван сарын 21-ний өдөр Монгол ард улсын хэмжээт цаазат ардын засгийн эрхлэх товчооны гишүүд хуралдаж, зөвлөлдөн тогтоосон 19-р хурлын тогтоолоор “Монгол ардын үндсэн хөрөнгө болох газрыг энгийн хүмүүст хувь хязгааргүй хэрэглүүлэх явдлыг устгавал зохино”³³ гэсэн нь эртнээс улбаатай эзэмшлийн хэлбэрийг зогсоосон хэрэг юм.

Анхдугаар “Үндсэн хууль”-аар “БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялгууд бол *эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн* (тодруулсан-Н.Л) зан суртаал нь чухам одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно”³⁴ гэж зааж, газрын өмчийн реформ хийх тухай ямар ч баримт бичигт заагүй зэрэг нь газар нутгийг хувь өмч болгож байгаагүй гэдгийг бас нотолж буй юм.

Ийнхүү монголын өнөөг хүртэлх бүхий л үеийн турш газрыг улс эсвэл хувь хүн өмчилж байсан гэсэн үзлийн үндэслэл, нотолгооны талаар зарим бодрол эргэцүүлэл хийхийг оролдож, монголчуудын түүхнээ газрыг хувьд өмчлүүлж байгаагүй гэсэн судлаачдын талд миний бие зогсож, түүний учир шалтгааны талаар санал бодлоо илэрхийллээ.

Одоо 1992 оны Үндсэн хуулиар газрыг хувь хүнд өмчлүүлэх анхны түүхэн шийдвэр гаргасан нь улс өмчилж байх гол шалтгаан болсон монголын газар шорооны төрөлх чанар өөрчлөгдөв үү, монголчууд капиталын нууцыг нээх чадвартай болов уу, иргэншлийн явцад гарсан шинэ үзэгдлийн тусгал уу гэсэн асуултын уулзварт хүрч ирлээ. Ямар ч гэлээ монголын байгаль цаг уур, газар шороо өөрчлөгдөж, өмчлөлийн шинэ эздийг шаардаагүй нь лавтай.

Тэгвэл газрыг хувьд өмчлүүлэх үзэл санаа хаанаас гарав, түүний агуулгын эх сурвалж юу байв?

³³ БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхэтгэл УБ., 1972. 18-р тал

³⁴ БНМАУ-ын 1924 оны Анхдугаар Үндсэн хууль. Нэгдүгээр бүлэг. Гуравдугаар зүйлийн Нэг /БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхэтгэл УБ., 1972.119-р тал



МОНГОЛД ГАЗРЫГ ХУВЬД ӨМЧИЛЖ БАЙСАН ЭСЭХ ТАЛААРХИ ТҮҮХЭН МАРГААН, ТҮҮНД ХИЙСЭН ТҮҮХ, ФИЛОСОФИ, ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ

Энэ үзэл санаа, санаачилгын гол субъект нь тэр үеийн төр засгийн болон улс төрийн намуудын удирдлага байв. Одоо үүнийг монголд бараг мартсан бололтой. Гай, гавьяа хоёрыг тэд үүрэх, хүртэх учиртай. Үүнээс өмнө газрыг хувьд өмчлүүлэх цаг үе ирснийг сануулсан, түүний түүхэн ач холбогдлыг гаргасан, ухуулсан судалгааны болон олон нийтийн санаа бодол хэрэг дээрээ огт илрээгүй юм. Тийм учраас газрыг хувьд өмчлүүлэх тухай Үндсэн хуулийн төсөл дэх заалтыг хаа сайгүй сэрджийн хүлээн авч, дээр доргүй балмагдалд орж, энэ шийдвэрийг гаргах ёстой АИХ-ын депутатууд түүхийн болон монголын ард түмний өмнө ямар хариуцлагатай шийдвэр гаргах гэж буйгаа үнэнхүү мэдэрч, хоёр он дамжуулан тавь шахам хоног хуралдан хэлэлцэж, халуун маргаан мэтгэлзээнийг өрнүүлсэн юм. Зарим депутат үүнийг халхын түүхэн дэх хамгийн удаан чуулган гэж хэлж байсан. Гэвч тэр үеийн Ардын Их Хурлын 476 депутатын ихэнх нь энэ шийдвэрийн эсрэг байсан гэж хэлж болно.

Үүнд АИХ-ын депутатуудын ихэнх нь их болгоомжтой хандаж, өөрийн орны түүхэн онцлогийг үл харгалзан гаднын байгууллагын шахалтаар хийж байна гэсэн хардлага сэрдлэг нэлээд гарч байсан нь тэдний чуулган дээр хэлсэн үгээс тодорхой байдаг. Тухайлбал, депутатууд Улсын Их, Бага Хурлын удирдлага, Ерөнхийлөгч нар депутатуудыг хөтөлж, зүтгүүлсээр байгаад газрыг хувьд өмчлүүлэх хууль батлуулж байна. Бид үүнийг зөвшөөрөхгүй³⁵. Ямар ч зардал, үнээр өөрсдийн шийдвэрээ хамгаалж, батлуулах нь энэ 48 хоногоос тодорхой байна. Түүхийн өмнө хариуцлага ялгамжтай хүлээх үүднээс нэрээр санал хураалгая. Бидний дуу хоолойг огт сонсохгүй өөрсдийн бодлогыг тулгаж байна³⁶ гэж олон депутат шүүмжилж байжээ.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай Үндсэн хуулийн энэ заалтын үндэслэлийг тухайн үеийн төр, засгийн удирдлага, улс төрийн намууд, эрдэмтэд, улс төрчид монголын амьдралд гарсан иргэншлийн өөрчлөлтөд тулгууралахаас илүү дэлхий дахины хөгжлийн хандлага руу илүү харж, тайлбарлаж байсан нь өөрийн орны онцлогоос ургуулан хийсэн судалгаа, тооцоо, дүгнэлт хэрэг дээрээ байгаагүйтэй холбоотой болов уу. Тийм ч учраас ширүүн эсэргүүцэлтэй тулгарсан байх. Эл байдал уг асуудлыг

³⁵ БНМАУ-ийн АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл (Соронзон хэвлэлийн хуудбар) 45-р боть. ХН. 45, 25, 26 дахь тал

³⁶ Мон тэнл. 6, 26 дахь тал



хэлэлцэхэд оролцсон олон нийтийн санал бодол, Ардын Их Хурлын чуулган дээр депутатуудын хэлсэн үг, уг төслийн заалтыг хамгаалагчдын тайлбар, хариултаас тодорхой харагддаг.

Газрыг Монгол улсын иргэнд өмчлүүлэх тухай үндсэн хуулийн 6-р зүйлийн үндэслэлийг хамгаалагчид: (1) дэлхийн улс түмний түүхэн туршилга, зах зээлийн эдийг засаг бүхий тогтолцооны олон улсын жишиг, (2) гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, татах замаар эдийн засгийн хөгжлөө түргэтгэх, (3) газрыг эзэнтэй, иргэнийг хөдөлшгүй хөрөнгөтэй болгох замаар тусгаар тогтнолоо баталгаажуулах зэргийг гол баримтлал болгож байжээ.

Харин газрыг иргэнд өмчлүүлэхийг зөвшөөрөөгүй, цаг нь болоогүй гэж үзэж байсан депутатууд олонхи болж байсан бөгөөд тэд (1) монголчууд бүх түүхийн турш газрыг улс өмчилж ирсэн нь санаандгүй хэрэг биш бөгөөд байгаль цаг агаараас үүдсэн газар, түүний хөрсний үржил шим, нүүдлийн соёлыг бий болгож, тэр нь газрыг малаар дамжуулж нийтээр эдэлж хэрэглэж байх байгал, түүхийн үндэстэй, (2) газрыг хувьд өмчлүүлэх нь монголын нийт ард түмэнд хүртээлгүй, хотын хэдэн хүнийг бодсон ялгавартай бодлого, (3) тарчиг ядуу амьдралтай монголчууд өмчилсөн газраа гадаадынханд өөрийн эрхгүй худалдаж, үндэсний тусгаар тогтнол хэврэгшинэ, (4) нүүдлийн соёлыг устгах аюул дагуулна зэрэг үндэслэлийг дэвшүүлж байсан юм.

Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх үеэр газрыг хувьд өмчлүүлэх эсэх талаар иргэдээс ирсэн олон мянган санал дотор зөвхөн 23-хан хүн өмчлүүлэхийг, 4426 хүн эзэмшүүлэхийг дэмжсэн бөгөөд тухайн үеийн судалгааны томоохон төв байсан “Төр, нийгэм судлалын академ”-аас Сэлэнгэ, Овөрхангай, Увс аймаг, Улаанбаатар, Дархан хотод явуулсан судалгаагаар судалгаанд оролцсон 100 хүн тутмын 15 нь өмчлүүлэхийг, 56 нь газрыг зөвхөн улсын өмчид байлгахыг дэмжсэн дүн гарч байсан байна³⁷. Гэвч тухайн үеийн төр засгийн удирдлага, БНМАУ-ын Бага Хурлын цөөн гишүүд газрыг хувьд өмчлүүлэх асуудлыг амжилттай зүтгүүлж чадсан юм.

АИХ-ын чуулганы дэлгэрэнгүй тэмдэглэлийг судалж үзэхэд төр засгийн удирдлага үнэхээр энэ асуудлыг шийдүүлэх гэж ихээхэн хүч чармайлт гаргасан нь илт байдаг. Маш олон дахин санал хураалгаж, депутатуудыг ятгаж, учирлаж байсан нь харагддаг. Үүний улмаас депутатууд сайн хөл

³⁷ Нямзага С. Монгол төрийн ухааны нэгэн чухал асуудал. Ардын эрх. 1991.10.29. №188(260)



бөмбөгчин сиймхийг олж гооь хийдэг шиг, биднийг аргалж зорилгодоо хүрч байна гэж “алдарт хөл бөмбөгчний” тухай шог яриа гаргаж байжээ. Тухайн үеийн БНМАУ-ын Ерөнхийлогч П.Очирбат АИХ-ын чуулганд үг хэлж, “бид чинь хэрэг дээрээ газрыг өмчилж байгаа шүү дээ, одоо зөвхөн түүнийг нь хуулиар баталгаажуулах л гэж байна” гэж депутатуудыг ятгаж, Эрдэнэт үйлдвэрийг жишээ болгож, газраа үнэлж, оруулчихаад тэр 400 сая рублийн өртөгтэй объектын 51 хувийг бид эзэмшиж, түүний 30 хувь нь газар байгаа гэх зэргээр учирлаж байснаас тодорхой билээ. Харин газрыг хувьд өмчлүүлэхийг зүтгүүлж байсан депутат³⁸ нар монголын түүхэнд газрыг хувьд өмчлүүлж байсан гэж АИХ-ын чуулган дээр болон хэвлэлд нийтлүүлсэн өгүүлэлдээ дурьдаж байсан нь тухайн үеийн судалгааны хүрсэн төвшин, мэдээлэлтэй нь холбоотой байсан бизээ.

Тэгэхлээр, газрыг хувьд өмчлүүлэх гэж төр засгийн удирдлага ингэж их чармайсан нь ардчиллын үнэт зүйлсийг хэрэгжүүлэх шаардлагын үүднээс ард түмнээ хөдөлшгүй хөрөнгөтэй болгож, өмчлөх эрхийн баталгааг хангах гэсэн утгаар зүй ёсоор дэвшсэн асуудал байж болох юм. Ер нь тийм ч байх.

Нөгөө талаас Олон улсын валютын санч тодорхой шаардлага, зөвлөмж өгч байсан нь лавтай. Тэр нь уг шийдвэрийн дангаар үндэслэл байсан эсэх нь өнөөдөр тийм ч чухал биш юм. Зөв байвал хэн, хаанаас анхны “хонх”-ыг цохисон байх нь гол биш. Үр дүн чухал.

Олон улсын валютын сангаас газрыг хувьд шилжүүлэх чиглэл өгсөн эсэх талаар зарим депутат АИХ-ын чуулган дээр удаа дараа асууж, шалгааж байсны эцэст тэр үеийн Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн АИХ-ын чуулган дээр депутатын асуултад хариулахдаа: “Тэнд зөвхөн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг Монголын засгийн газар шийдсэн байх ёстой гэсэн асуудал хөтөлбөр дотор бий”³⁹ гэснээс үзэхэд ОУВС-ийн нөлөө хүчтэй байсан нь эргэлзээгүй.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай түүхэн шийдвэрт хүрэхэд гадна, дотны янз бүрийн нөлөө санал зөвлөмж байсан эсэх нь хэрэг дээрээ

³⁸ БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдаанд Б.Чимидийн хэлсэн үг /БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл (Соронзон хальсны хуулбар) 47-р боть, ХН. 45, 1991:12:30, ХН 44, 48 дахь тал, М.Энхсайхан. Газрыг хувьд өмчлүүлж болно /Ардын эрх, 1991.08.23. №141(213)

³⁹ БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл (Соронзон хальсны хуулбар) 45-р боть, ХН. 45, 1991:12:31, 108 дахь тал



нуушлаад болгоомжлоод, шүүмжлээд байх зүйл огт биш бөгөөд хамгийн гол нь монголд газрыг хувьд өмчлүүлэх цаг хугацаа, нөхцөл бүрэлдсэн эсэх л гол асуудал байв. Харин энэ асуудлыг монголын нийгмийн хөрсөн дээр судалж үзсэн дорвитой судалгаа дүгнэлт тэр үед ч байгаагүй, одоо ч бараг байхгүй бөгөөд зориг зүрхээрээ, өмч хүний эрхийн үндэс гэсэн ерөнхий тунхагийн хүрээнд л бид явж иржээ.

Үүнээс үүдэн газрыг хувьд өмчлүүлэх тухай Үндсэн хуулийн энэ заалт ямар ч аргаар төрж бүтсэн нь гол биш бөгөөд монголын хөрсөнд ургаж төлжих, улмаар капитал болох амьдралын үндэс, иргэншлийн нөхцөл бүрэлдсэн эсэх л хамгийн чухал асуудал юм.

Миний бодоход тийм хөрс монголд бүрэлдсэн байсан нь гол олз юм. Монгол улс, монголчууд капиталын нууцыг нээх төвшинд хүрээгүй хэдий ч, газрыг малаар дамжуулж ашиглаж байсан амьдралын хэв шинж өөрчлөгдөж, “газартай нөхөрлөх”-ийг шаардсан иргэншлийн шинэ хэв шинжийг тогтоох хэрэгцээ бий болжээ. Уг асуудлыг АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р чуулган дээр нэг хоёрхон депутат хөндөж байсан байна. Тухайлбал, АИХ-ын орлогч дарга Лоохууз хүн амын 80 хувь суурин амьдралд шилжлээ. Төв сууринд зохицсон амьдралыг бий болгоход газар гол хэрэгсэл болно, газрыг хувьд өгөхгүй, гадаадынхан авчихна гэж үндэсний явцуу үзэл баримтлах нь монголчуудад ашиггүй⁴⁰ гэж хэлж байжээ.

20-р зуунд монголын нийт хүн амын дийлэнхи олонхи суурин, хагас суурин амьдралд хөгжлийн эрхээр шилжсэн нь үнэн юм. Одоогийн байдлаар нийт хүн амын бараг 40-өөд хувь нь зөвхөн Улаанбаатар хотод суурьшин амьдарч байна. Үүн дээр бусад аймгийн төв, сууринд суурьшин амьдарч буй хүн амыг нэмбэл нийт хүн амын дийлэнхи олонхи хот сууринд суурьшсан статистик гарна. 2003 оны байдлаар нийт хүн амын тоонд нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчдын тоо 15 хувийг эзэлж байна. Мөн монголын нийт ажиллагчдын (926.0) мянга, 40 хувь буюу 378.0 мянган малчид нүүдлийн мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байна. Энэ тоо сүүлийн жилүүдэд буурах хандлага ажиглагдаж байгаа. Зөвхөн 2003 онд 2000 оныхоос 43.0 мянгаар буурсан⁴¹ байх жишээтэй.

⁴⁰ БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл (Соронзон хальсна хуулбар) 43-р боть, ХН. 43. 1991:12:28. 89 дахь тал

⁴¹ Элгээр тоо баримтыг Т.Намжия. Монгол улсын эдийн засаг. УБ., 2004, 2,3-р ботгийн тоо баримтад тулгуурлан гарган.



Нөгөө талаас мал аж ахуйн гол бүтээгдэхүүн болсон махны хэрэглээ 2020 онд 2002 оныхоос 1.8 дахин өсөх тооцоо гарч байна. Осөн нэмэгдэж байгаа энэ хэрэгцээг хангахын тулд малын тоо толгойг 30 орчим саяд хүргэхээс гадна мал аж ахуйг эрчимжүүлэх, билчээрийн, хагас суурин, суурин маллагааны арга технологи бүхий аж ахуйн хэлбэрийг хослон хөгжүүлэх шаардлага тулгарч байна гэж судлаачид үзэж байна⁴².

Тэгэхлээр, хүн амын дийлэнхи олонхи хот сууринд суурьшиж, суурин амьдралын хэв шинжид тохирсон арга ухаанаар амьдрах нь гарцаагүй болсноос гадна мал аж ахуйг эрчимжүүлэхийг шаардсан, дагалдсан үйл явц нь монголын газрын эрх зүйн харилцааг цаашдаа нэлээд өөрчилж болзошгүй байгаа тул Монгол улсын Үндсэн хуульд газрыг хувьд өмчлүүлэх заалт нь их түүхийн эхийг ямарч байсан зөв эхлүүлсэн боллоотой.

Гэвч энд хууль зүйн техникийн хувьд засаж сайжруулах зүйл цөөнгүй бий. Жишээ нь, Монгол улсын Үндсэн хуулийн 6-р зүйлийн 3-д “Иргэд хувийн өмчийнхээ газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх барих байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно” гэсэн заалт нэг мөр ойлгоход ихээхэн бэрхшээлтэй байгаа юм. Энэ заалтыг дараах утгаар ойлгож болно.

Нэгдүгээрт, “бусдад” гэдэг үгнийг гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэж уншвал “Иргэд хувийн өмчийнхээ газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэхийг хориглоно. Харин төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрвөл гадаадын иргэн харьяалалгүй хүнд эзэмшүүлж, ашиглуулж болно” гэж нэг ойлгож болно. “Бусдад” гэдэгт Монгол улсын иргэдийг хамааруулж ойлгохгүй зөвхөн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг багтааж ойлгох онолын өөр нэг үндэслэл бол өмчлөх эрх хүний салшгүй жам ёсны, үндсэн эрх учраас түүнийг ямар нэг зөвшөөрлөөр хязгаарлаж болохгүй бөгөөд Монгол улсын Үндсэн хуулиар өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрч, газрыг хувьд өмчилж болно гэж заасан учраас өмчлөх эрхийн агуулгад халдсан заалт эрх зүйт Үндсэн хуульд байх ёсгүй гэсэн үзлийн үүдгээс авч үзэх явдал юм.

⁴² Намжил Т. Монгол улсын эдийн засаг. УБ., 2004, 3-р боть, 1254-1264 дэх тал



Ингэж үзвэл “бусдад” гэдэгт гадаадын иргэн, харьяалалгүй хүн багтаж, эдгээр хүн Монгол улсад төрийн эрх бүхий байгуулга зөвшөөрвөл газар эзэмшиж болох нь. Ийм тохиолдолд гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд, харьяалалгүй хүн Монгол улсад газар эзэмших эрх “Газрын тухай хууль”, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-иар хориглосон заалтууд Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэхэд хүрнэ.

Хоёрдугаарт, “бусдад” гэдэг үгийг Монгол улсын иргэд гэж уншвал “Иргэд хувийн өмчийнхээ газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлж үл болно. Түүнчлэн иргэд хувийн өмчийн газраа бусдад (өөрийн улсын иргэд) эзэмшүүлэх, ашиглуулахдаа төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна” гэсэн утгаар ойлгоно. Үүнийг баримталж, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 28-р зүйлийн 1.2-д “өмчийн газраа энэ хуулийн 29.1-д⁴¹ заасан зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэн, ашиглуулахыг” хориглоно гэсэн зохицуулалтыг хуульд оруулсан бололтой. Гэтэл “бусдад” гэдэг үгийг Монгол улсын иргэн, хуулийн этгээдэд хамааралтай гэж үзвэл Үндсэн хуулийн эрх зүйт чанарт тун зохисгүй байдлыг буй болгож байгаа юм. Тухайлбал, өмчийн эзэн, Монгол улсын иргэн өмчилж буй газраа өөр хоорондоо захиран зарцуулахдаа өмчлөх эрхээ хэрэгжүүлэх эрхтэй атлаа бусдад эзэмшүүлэх, ашиглуулахдаа төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах нь утга чанаргүй бөгөөд өмчлөх эрхийг нь хязгаарласан хэрэг болж таарна.

Гадаадын хүн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд эзэмшүүлэхээс сэрэмжилж зөвшөөрөл авах тухай заалт оруулсан гэж үзвэл төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрвөл гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн газар эзэмшиж болох хууль зүйн логик гарна. Монгол улсын Үндсэн хуулийн 6-р зүйлийн 5-д зааснаар “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно” гэж заасан учраас нэг нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэх, нөгөө нь ашиглах эрх эдлэхийн тулд газраа ашиглуулах, ашиглах

⁴¹ “ Иргэн өмчийн газраа зориулалтаар нь, тодрохой хугацаагаар сум, дүүргийн засаг даргын зөвшөөрлөөр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно”.



эсэх талаар зөвшөөрөл авах нь утгагүй болж буй билээ.

Тэгэхлээр, Үндсэн хуулийн 6-р зүйлийн 3-ийг тойрсон энэ маргаантай асуудлыг тайлбараар засах хууль зүйн бололцоо миний хувьд харагдахгүй байна. Эрх зүй судлалд “эзэмших,” “ашиглах” эрх нь бие даасан ойлголт гэдэг нь нэн тодорхой бөгөөд Монгол улсын Газрын тухай хуулийн 3-р зүйлд⁴⁴ тэдгээрийг агуулгыг тус тусад тодорхойлсон билээ. Оөрөөр хэлбэл, хоршиж хэрэглэж нэг утгыг илэрхийлэх онолын хийгээд хууль зүйн техникийн бололцоо байхгүй гэсэн үг.

Иймээс Монгол улсын Үндсэн хуулийн 6-р зүйлийн 3-ийг “Иргэд хувийн өмчийнхээ газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн харьяалалгүй хүний өмчлөл, *эзэмшилд* шилжүүлэхийг хориглоно” гэж өөрчилбөл “Газрын тухай хууль”-ийн 28.1.1-тэй болон Үндсэн хуулийн 6-р зүйлийн 5-ын заалтай зөрчилгүй болж, газар улс орны тусгаар тогтнолтой холбоотой өмчлөлийн онцгой объект гэсэн утгаар гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн өмчлөх, эзэмших эрхийг хориглож, Монгол улсын иргэн газар өмчлөх эрхээ сонгодог утгаар хэрэгжүүлэх бололцоо нээгдэнэ. Үүнийг дагаж “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 28.1.2, 29.1 дэх Монгол улсын иргэний өмчлөх эрхийг хязгаарласан заалтуудыг хүчингүй болгох шаардлага гарна. Оөрөөр хэлбэл, гадаадын иргэн хуулийн этгээдэд Монгол улсын иргэн өмчилсөн газраа эзэмшүүлж болзошгүйг зохицуулах үүднээс иргэдийнхээ өмчлөх эрхийн агуулгыг хязгаарлахад хүрсэн байна.

Монгол улсын Үндсэн хуулийн 6-р зүйлийн 3-ын энэ эгзэгтэй заалтууд анх Үндсэн хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхэд болон БНМАУ-ын Бага Хурлаас Ардын Их Хурлын Чуулганд өргөн барьсан төсөлд байхгүй байснаас үзэхэд “газрыг зөвхөн Монгол улсын иргэнд өмчлүүлж болно” гэсэн заалтыг авч үлдэхийн тулд хийсэн “буулт” гэж үзэж болно.

Эцэст тэмдэглэхэд, монголчууд 20-р зууны сүүдч хүртэл газрыг төр өмчилж, цөөн тооны хүмүүс эзэмшиж, жирийн малчид эдлэн хэрэглэж ирсэн нь монгол нутгийн газар шорооны үржил шим, “зориулалт” нь билчээрийн

⁴⁴ “3.1.3. Газар эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуультар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг”, 3.1.4 “газар ашиглах” гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигт чанарыг гаргаж хэрэглэхийг “ хэлнэ гэж заажээ.



мал аж ахуйн үйлдвэрлэлд илүү тохирч, түүнд тулгуурласан нүүдлийн соёл, билчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн төвшний зүй ёсны тусгал байлаа. Харин 20-р зууны дунд үеэс бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн зэрэгцээ бусад төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд шинээр хөгжиж, суурин, хагас суурин иргэншлийн хэв шинж бүрэлдэж, газартай харилцаж ирсэн монголчуудын эдийн засаг, эрх зүйн арга, хэлбэр өөрчлөгдсөн нь өмчлөх эрх, улмаар газрыг хувьд өмчлүүлэх эрхийг нээх суурь нөхцөл болсон байна. Энэ эрх нь хүний үндсэн эрх учраас халдашгүй дархан эрх бөгөөд төр зөвхөн хамгаалж байх ёстой гэсэн хүн төрөлхтөний түгээмэл үнэт зүйлсийн үүднээс авч үзвэл бид үндэсний явцуурал, болгоомжлолын улмаас андуу ташаа хандсан зүйл манай хууль тогтоомжуудад байгаа хэдий ч хөгжил, ухаарлын явцад тэдгээрийг даван туулах нь эргэлзээгүй. Оросууд “Москваг нэг өдөр бариагүй” гэдэг шиг их хэргийг бүтээхэд алдаа оноо ч хамт явж, цаг хугацааг ч туулдаг билээ.



ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУДЫН ХӨГЖЛИЙН ТОЙМ

*Цагдаагийн Академийн Үндсэн хуулийн
эрх зүйн тэнхимийн бигш С.Энхбаяр*

Монголын ард түмэн 1921 онд ардын хувьсгалаа хийж, ард олны засгийг тогтоосон үеэс өөрсдийн эрх ашгийг илэрхийлсэн төрийн байгууллагаа байгуулж, хууль цаазаа буй болгох шаардлага аяндаа тавигдах болов. Энэ талаарх олон арга хэмжээ, ололтыг үл өгүүлэн зөвхөн Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг төрөөс хэрхэн журамлан зохицуулж ирсэнийг баримт түшиглэн авч үзье. 1926 онд шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуулийг батлан гаргасан бөгөөд түүнээс хойш хууль тогтоох газраас 1952, 1967 онуудад Иргэний байцаан шийтгэх, 1994, 2002 онуудад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулиуд тус тус батлагдан гарсан.

Эдгээр хуулиудыг батлан гаргах, шинэчлэхэд хүргэсэн нийтлэг хүчин зүйлсийг тодруулбал:

- Монгол Улсад Үндсэн хууль батлагдан гарах бүрд түүний үзэл баримтлалд нийцүүлэн салбар хуулиудыг шинэчлэх шаардлага бий болсон. Оөрөөр хэлбэл Монгол улсын Үндсэн хуулиудад тунхагласан улсын хөгжлийн зорилго, болон нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдаж иргэний процессийн хууль өөрчлөгдөж байсан.

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль нь процессийн хууль тул материаллаг хуультайгаа саллигүй уялдаатай байж, түүний хэрэгжилтийг хангахад чиглэж байдаг. Иймд иргэний хууль шинээр батлагдан гарах нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль шинээр батлагдан гарах нэг хүчин зүйл болсон.

- Монгол Улс социалист системтэй байх үедээ Оросын холбооны улсын хуулиудыг бараг хуулах шахам авч хэрэглэж байсан тул Оросын холбооны улсын Иргэний процессийн хууль батлагдан гарах, хүчингүй болох



нь Монгол улсын хууль өөрчлөгдөх нэг хүчин зүйл болж байв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хөгжлийг оновчтой тодорхойлохын тулд уг хуулиудыг зохих шалгуураар үечлэн судлах нь зүйтэй болов уу. Ингэхдээ:

1. Улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг үндэслэх

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх зарчмыг харгалзах гэх мэт шалгуураар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг тодорхой үечлэлд хувааж болно.

Хууль зүйн ухааны доктор, профессор, гавьяат хуульч Б. Чимидийн үечилснийг¹ загвар болгон авч үзвэл:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх социалист маягийн хуулиуд: энэ үечлэлд 1926 оны Аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль, 1952, 1967 оны Иргэний байцаан шийтгэх тухай хуулиуд хамаарна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ардчилсан маягийн хуулиуд: Энэхүү үечлэлд 1994, 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиуд хамаарна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг шалгуур болгон үечилбэл:

1. Байцаан шүүх / следственный / зарчмаар Иргэний хэргийг хянан шийдвэрлэх үеийн хуулиуд: Үүнд 1926 оны аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль, 1952, 1967 оны Иргэний байцаан шийтгэх тухай хуулиуд хамаарна.

2. Мэтгэлцэх зарчмаар явагдах иргэний хэргийг хянан шийдвэрлэх үеийн хуулиуд: Энд 1994, 2002 онуудын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг хамааруулан судлах нь зүйтэй.

Эдгээр үечлэл бол тус улсад үйлчилж байсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг ердийн байдлаар ангилан хувааж буй хэрэг биш бөгөөд улс орны хөгжил, иргэний хэргийг тасалж байсан шүүхийн үйл ажиллагааны мөн чанартай холбоотой байна.

Монгол улсад үйлчилж байсан эдгээр хуулиудын онцлогийг товч боловч авч үзье.

1. Монгол Ард Улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль 1926 он: Монгол улсад 1921 онд ардын хувьсгал ялж

¹ Б. Чимид, “Үндсэн хуулийн үзэл баримтлал”, 1-р дэвтэр, УБ, 2004 он, 207 дахь тал



өөрийн улсын дотоод асуудлыг бие даан шийдвэрлэх нөхцөл бүрдсэн бөгөөд Монгол улсын соёл иргэншил, зан заншил, амьдралын хэв маягийн онцлогыг илэрхийлсэн хууль тогтоомжийн бааз суурьтай болох явдал нэн тэргүүний зорилт байв. Энэхүү зорилтыг хангах эхний алхам нь 1924 оны XI сарын 25-ны өдрийн 16 цаг 17 минутанд Ардын их хурлаас² Монгол улсын үндсэн хуулийг батлан гаргасан. Тус улсад энэ хуулийн дагуу бусад салбарын актуудыг шинээр батлах шаардлага зүй ёсоор тавигдав.

1925 оны 11-р сарын 20-ны өдөр БНМАУ-ын 2-р их хурлаас “Шүүх таслах хэргийг шинэтгэн байгуулах тухай” тогтоол батлан гаргасан бөгөөд тус тогтоолын 3-р зүйл 4 дэх хэсэгт “... Шүүх таслах газрууд нь аливаа хэргийг шийтгэхдээ тусгайлсан шинэ цааз хуулийг баримтлахаас гадна, манжийн хууль цааз бол ард түмнийг боолчлон дарласугай гэж захиасан бодлоготой учир даруй түүнийг устгаж цаазалбал зохино³.” гэж заасан нь шүүхээр зарга, маргааныг шийдвэрлэх шинэ хууль батлагдах нэг нөхцөл болсон.

Мөн нөгөө талаас 1925 оны 10-р сарын 26-ны өдөр батлагдсан Шүүх явдлын яамны дүрмийн 1-р зүйлд “... Шүүх явдлын яам нь тус улсын доторхи аливаа дотоод, гадаадын хүн ардын хүний амь, хулгай, худал зарга, зальхай, өр шир, самуун садрын зэрэг эрүүгийн ба иргэний шүүх таслахад холбогдсон хамаг хэргийг захиран шийтгэхээс гадна, аливаа зохих газруудад шүүх таслах газруудыг байгуулах, асуух дүрэм заавар гаргахыг хянан байцаах зэрэг явцыг бүрэн эрхлэн шийтгэнэ” гэж заасан байна⁴. Үүнтэй холбоотойгоор 1925 оны 11-р сарын 20-ны өдөр батлагдсан шүүх таслах газруудыг байгуулах тухай тогтоолын 1-р зүйлд “... Тус улсын дотор аливаа хэргийг шийтгэх таслахад нэгэн адил хууль дүрмийг батлах шүүх таслах газрууд нь: Хошууны жинхэнэ ардын шүүх, аймгууд, хотын шүүх таслах газар, дээд шүүх таслах газрыг байгуулах...” тухай заажээ.

Ардын засгийн дээрх бодлого, гаргаж байсан удирдамж, чиглэлүүд нь иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хууль батлан гаргах үндэслэлийг бий болгожээ гэж болно.

Энэхүү шаардлагаас үүдэн Засгийн газрын 1926 оны 26-р хурлын тогтоолоор баталсан Аливаа хэргийг шүүн таслах газруудыг байгуулах тухай дүрмийн 2-р зүйлд заасан Цэргийн болон Цаг зуурын хэргийг шүүн таслах

² Ч. Нямсүрэн, “ Эрх зүй, торийн ерөнхий онол”, УБ, 2004 он, 150 дахь тал

³ БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актыг эмхтгэл, УБ, 1966 он, 151 дэх тал

⁴ БНМАУ-н Үндсэн хууль түүнд холбогдох зарим актыг эмхтгэл, /1920-1940 он/, УБ, 1955 он, 192 дахь тал



газруудаас мөрдөн шийтгэхээр заасан хэргүүдээс зааглан “Монгол улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай”⁵ хуулийг батлан гаргасан байна.

БНМАУ-ын Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуульд Иргэний, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах журмыг хамтад нь хуульчилж өгсөн⁶ бөгөөд энэ нь Монгол Улсад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмыг зохицуулсан анхны нэгдмэл акт байснаараа түүхэн ач холбогдолтой байна. Оноо үеийн сэтгэлгээнээс авч үзэхэд уг актыг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталж байсан нь тэр үеийн онцлог байжээ гэж болно.

Уг хууль нь 9 бүлэг 111 зүйлтэй бөгөөд бүлэг бүрийн агуулгыг тодруулан авч үзвэл **нэгдүгээр бүлэг:** Шүүн таслах газар эрхлэн шийтгэвээс зохих хэргүүд /1-11-р зүйл/, **хоёрдугаар бүлэг:** Аливаа эрүүгийн хэргийг анх байцаах заавар /12-35-р зүйл/, **гуравдугаар бүлэг:** Аливаа иргэний хэрэг мэдүүлэх тухай заавар /36-47-р зүйл/, **дөрөвдүгээр бүлэг** Заалдсан ба гэрчийн зэрэг хүмүүсийг шүүх таслах газарт зарлан ирүүлэх тухай /48-60-р зүйл/, **тавдугаар бүлэг:** Аливаа хэргийг байцаах шийтгэхийн өмнө бэлтгэвэл зохих зүйлүүд нь /61-67-р зүйл/ , **зургаадугаар бүлэг:** Шүүх таслах газруудад аливаа хэргийг хуралдан шийтгэх тухай /68-93-р зүйл/, **долдугаар бүлэг:** Аливаа шийтгэснийг үл дагаж, заалдан мэдүүлэх тухай / 94-97-р зүйл /, **наймдугаар бүлэг:** Заалдан мэдүүлсэн хэргүүдийг аймаг, хот ба Дээд шүүх таслах газруудад байцаах шийтгэх тухай / 98-103-р зүйл/, **есдүгээр бүлэг:** Шүүх таслах газруудын тогтоолыг гүйцэтгэх тухай /104-111-р зүйл/ гэх мэт болно.

Энэхүү хуульд Улсын цааз хуулийг хянан зохиох тусгай комиссоос Орширийн зэрэг иргэний хэргийг хураангуйгаар хурдавчлан шийтгэх тухай 10-р бүлгийг 11 зүйлтэйгээр⁷ төлөвлөн 1928 оны 01-р сарын 27-ны өдрийн БНМАУ-ын Засгийн газрын 4-р хуралд оруулж, уг хурлын тогтоолоор Монгол улсын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуульд нэмж хуульчилсан.

Мөн 1929 оны 7-р сарын 05-ны өдрийн Засгийн газрын 21-р хурлын тогтоолын 3-р зүйлээр Монгол улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуульд Шүүх таслах газруудад өрширийн зэрэг иргэний

⁵ БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл №13, /Үндэсний архивын газар/, УБ, 1926 он, 8-9, 34-75 дэх тал

⁶ Ж. Болдбаатар, Д. Лүндээжанцан, “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал”, УБ, 1997 он, 274 дэх тал

⁷ БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл, №39, /Үндэсний архивын газар/, УБ, 1928 он, 8-9, 57-64 дэх тал



хэргийг таслан шийтгэсэн тогтоолыг гүйцэтгэх тухай уг хуулийн 9-р бүлэгт нэмэгдүүлэн зохиосон 11-р бүлгийг⁸ батлан гаргасан.

БНМАУ-н Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуулийн зарим онцлог шинжийг авч үзвэл:

- Иргэний процесс, Эрүүгийн процессийн хооронд төдийлөн зааг ялгаа байгаагүй /6-р бүлэг Шүүн таслах газруудад аливаа хэргийг хуралдан шийтгэх тухай гм.../

- Ард нийтийн бичиг үсгийн боловсрол муу байсантай холбоотойгоор нэхэмжлэлийг амаар гаргаж болохоор заасан.

- Шүүхийн харьяаллыг тодорхой зааж өгсөн. Тухайлбал нэгдүгээр бүлэг 2-р зүйл "... Аймгийн шүүн таслах газруудын эрхлэн шийдвэрлэх хэргүүдэд өр ширийн 1000 /нэг мянган/ төгрөгөөс дээш иргэний хэргийг харьяалан шийднэ." Мөн 3-р зүйл "Хошууны шүүх таслах газруудаас эрхлэн шийтгэх хэргүүд нь 2-р зүйлд зааснаас бусад цөм иргэний хэргүүдийг эрхлэн шийтгэнэ"

- Иргэний хэргийг давж заалдаж болохгүй үндэслэлийг хуульчлав. 94-р зүйлд "...Аливаа өр ширийн зэрэг иргэний хэрэг 100 төгрөг хүртэл буюу 4 бодоос дээш бус бол Хошууны шүүн таслах газрын тогтоолыг заалдан мэдүүлж үл болно" гэж заасан байна. Энэ нь нэг талаас Шүүн таслах газруудын ажлыг хөнгөвчилж байгаа боловч нөгөө талаас иргэний эрхийг хязгаарласан зохицуулалт байжээ гэж болно.

Уг хуулинд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн зохицуулалтуудыг тусгасан байдлыг авч үзвэл:

1. Хуулийн 3-р бүлэг /Аливаа иргэний хэрэг мэдүүлэх тухай заавар/ 36-р зүйлд "... Иргэний хэрэг гэдэгт: Аливаа өр шир нэхэмжлэх, аливаа гэрээг үл дагаваас үүссэн тэмцэл, өв тахилыг шилжүүлэх ба өмч хуваах, бэлэглэх, эр эм нийлэх салах, хүүхэд үрчлэх ба булаалдан тэмцэлдэх" зэрэг хэргүүдийг хамааруулжээ.

2. Иргэний хэргийн шүүхийн болон хэргийн харьяаллыг тодорхой заажээ. Тухайлбал 38-р зүйл "...Аливаа өр ширийн зэрэг иргэний хэргийг мэдүүлэхэд нөгөө этгээдийн үргэлж буюу түр суудаг газар" 39-р зүйл "... Нөгөө этгээдийн сууж буй газар үл мэдэгдэх бол түүний хөрөнгө бүхий газрын шүүх таслах газарт мэдүүлбэл зохино". 40-р зүйл "...Аливаа албаны ба ард олноор байгуулсан хоршооны зэрэг газраас нэхэмжлэх зүйл байвал тэдний эрхлэх

⁸ БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүд, № 50. /Үндэсний архивын газар/, УБ, 1930 он, 3-4, 17-70 дахь тал



газарт буй шүүх таслах газарт мэдүүлбэл зохино” мөн 2-р зүйлд “...Аймгийн шүүх таслах газарт өр ширийн зэрэг иргэний хэрэг 1000 төгрөгөөс дээш бол бусад хэргийг хошууны шүүх таслах газар шийдвэрлэнэ” гэж заасан нь давж заалдах асуудлыг нэг талаар хязгаарласан зүйл боловч нөгөө талаар иргэний хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлж өгсөн.

3. Хэргийн оролцогчид тэдний эрх, үүргийг тодорхой заагаагүй байна. Гэхдээ Иргэний хэргийг шийдвэрлэхэд оролцох этгээдийг дурджээ. Тухайлбал 49-р зүйлийн 2-т “...Уг хэргийн учир ба жич зарлан ирүүлэх заалдагсад, заалдуулагсад ба гэрч, шинжээч хэлсэн хэргийн учрыг шинжлэн мэдэх хүмүүс ба хэлмэрч зэрэг болно” гэж зааж өгсөн байна. Мөн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын насны доод хэмжээг 13 /арван гурван/ насаар тогтоож өгсөн байна.

4. Иргэний нэхэмжлэлийн зүйл, үнэ, болон бүрдүүлбэрийг зохицуулсан. Тухайлбал хуулийн 42-р зүйл “...Аливаа өр ширийн зэрэг анх бичгээр буюу амаар мэдүүлэхдээ өөрийн ба нөгөө этгээдийн нэр, овог суух газар ба нэхэмжилсэн зүйлийн үнэ тоо буюу тэмцсэн зүйл юу болох зэргийг цөм тодорхойгоор заахаас гадна батлах бичиг буюу гэрчийн зэрэг зүйл буй бол хамтаар мэдүүлбэл зохино” мөн 43-р зүйл “...Нэхэмжилсэн зүйлийн үнийн дээр зохих хүүг хэрэг мэдүүлсэн өдөр хүртэл нэмэгдүүлэн бодож шүүх таслах газарт дүрмийн ёсоор татварыг хураалгавал зохино” гэсэн байдлаар тусгаж өгсөн байна.

5. Шүүхэд хэрэг шийдвэрлэх хугацааг хуульчлахдаа. Хошууны болон аймгийн шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэргийг давж заалдах хугацааг 14 хоног, уг хэргийг шийдвэрлэх хугацааг 7 хоног гэж заасан.

6. Хуульд ноглох баримтын талаар тусгайлан заагаагүй боловч нотлох баримт бүрдүүлэх асуудлыг тусгажээ. Тухайлбал, заалдагсад, заалдуулагсад ба гэрч, шинжээч нар аливаа өр ширийн зэрэг анх бичгээр буюу амаар мэдүүлэхдээ... тэмцсэн зүйл юу болох зэргийг цөм тодорхойгоор заахаас гадна батлах бичиг буюу гэрчийн зэрэг зүйл буй бол хамтаар мэдүүлбэл зохино гэжээ.

7. Хуульд шүүхийн зардал болон тэмдэгтийн хураамжийн талаар заасан. Уг хуулийн 59-р зүйл “... Аливаа шүүх таслах газар шийтгэх иргэний хэргээс хураах татварын дүрмийн ёсоор гэрч нар ба хэлмэрчийн зэрэг хэрэглэх хүмүүсийн хөлс ба бусад зүйлийн зарлагын хэмжээг харьяат шүүх таслах



газар хэрэг шийтгэх тухай бүр тогтоовол зохино”. 60-р зүйл “...Дээрх зүйлд дурьдсан гэрчийн зэрэг хүмүүст хөлс сүйтгэлийг хэрэг буруудсан этгээд төлвөөс зохих бөгөөд үнэхээрийн хоосон ядуу болох аваас зохих хөлсийг улсын сан ба орон нутгийн захиргааны газраас тавьж олговол зохино. 45-р зүйл “...Шүүх таслах газарт тусгай дүрмийн ёсоор хураалгавал зохих аливаа татвар” зэргийг хэрэг мэдүүлэхийн хамт төлөвөөс зохино. Хэрэв үнэхээрийн төлж чадахгүй бол дуусахыг хүртэл татвар хураахыг алгуурлаж болно.” гэжээ.

8. Иргэний хэргийг хэлэлцэх шүүх хурлын бэлтгэл ажиллагааг тусгай бүлэг болгон хуульчилжээ. Үүнд шүүх таслах газар зарлан ирүүлэх хүмүүс тэдэнд зарлах бичиг хүргүүлэх талаар болон Шүүх таслах газар аливаа байцаах хэргүүдэд ээлж тогтоож, данс үйлдэж, түүнд байцаах шийтгэх өдөр, сар зэргийг тодорхойлж, тус газар илэрхий наалдуулж, олонд үзүүлж байвал зохино гэх мэт бусад арга хэмжээг хуульчлав.

9. Хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны журмыг хуульчлав. Тухайлбал шүүх бүрэлдэхүүн түүний дотор ардын төлөөлөгчийг татгалзан гаргах, мөн шүүх хуралдааны журам болон хэргийг шийдвэрлээд гаргах тогтоолын агуулгыг тухайлан зааж хуульчлав. Мөн аймаг, хогын шүүх болон дээд шүүхэд хэргийг давж заалдах журам, мөн шийдвэрлэх хугацааг тодорхойлжээ.

10. Хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тусгажээ. 105-р зүйл “...Аливаа иргэний хэргийг шийтгэсэн тогтоол хүчин төгөлдөр болсны дараа нэхэмжилсэн этгээдээс гуйвал уг хэргийг гүйцэтгэн шийтгүүлэхээр харьяат шүүх таслах газрын түшмэлээс түүнд тусгай хуудас олговол зохино”. Мөн шүүхийн шийдвэрт гүйцэтгэж болохгүй зүйлийг хуульчлав. Үүнд 110-р зүйлд “...Аливаа өр ширийн зүйлүүдийг нэхэмжлэгдсэн этгээдийн хөрөнгө хогшлыг дээр дурьдсан ёсоор битүүмжлэх ба худалдахад түүнийг эм хүн буюу ураг төрөлд нь зөвхөн амьдралын хувь үлдээхээс гадна аж үйлдвэрт чухам холбогдох бүхий зүйлүүдийг хураан авч үл болно”. Хэрэв төлбөр төлөх этгээд хоосон ядуу бол түүний эд хогшлыг нь хураан авахаар хуульд заажээ.

Мөн 1930 онд БНМАУ-ын 6-р их хуралд Засгийн газрын хэлэлцүүлсэн илтгэлийг сонсоод гаргасан тогтоолд хууль цаазын ба шүүх таслах хэргийн тухай хэсгийн 2-т “...Урьд тогтоосон Иргэний ба байцаан шийтгэх хуулиудын дотроо хуучирч битүүлэгдсэн буюу шинэчлэн зохих зүйлүүдийг залруулбал

* “Мэдүүлгийн хамт хураалгавал зохих татвар” гэдгийг “тэмдэгтийн хураамж” гэж ойлгох нь зүйтэй



зохино” гэж заасан чиглэлийн үргэлжлэл болгон Шүүх явдлын яамнаас 1930 онд Аливаа иргэний хэргийг шүүх таслах тухай тайлбар¹⁰ /заавар/-г батлан гаргасан. Тайлбар нь 8 бүлэг 57-н зүйлээс бүрдэх бөгөөд иргэний процессийг энэ зааварт эрүүгийн процессоос зааглан өгсөн түүхэн ач холбогдолтой албан ёсны тайлбар байсан.

Бүхэлд нь авч үзэхэд БНМАУ-ын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль нь иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг тохируулан зохицуулсан анхны нэгдмэл акт байжээ.

2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль /1952 он/ Монгол улс улс төрийн нийтээр хоморголсон хэлмэгдүүлэлт, Халх голын дайн зэрэг зовиур бэрхшээлийг амссаар 1940 онтой золгожээ.¹¹

1940 оны 6-р сарын 30-ны өдөр “... Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол эзэрхэг түрэмгий феодалын дарлалыг устгасан, цаашид нийгмийн журамд давшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж, бүхий хөдөлмөрчин /малчин, ажилчин, оюутан / ардын тусгаар тогтносон улс мөн болно” гэж улсын хөгжлийн зорилтыг тодорхойлсон Монгол улсын хоёрдугаар Үндсэн хуулийг Улсын VIII их хурлаас батлан гаргасан.¹² Үүнтэй уялдан Монгол улсын хөгжлийн зорилго, болон социалист эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх шаардлага урган гарч байв.

1952 оны 5-р сарын 27-ны өдөр Улсын их хурлын тэргүүлэгчдийн зарлигаар “...Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль”¹³ батлагдав.

Уг хууль нь “...БНМАУ-ын шүүхийн байгууллагад иргэний хэргийг хянан шийдвэрлэх журмыг энэ хуулиар тогтооно” гэсэн явдлыг зорилго болгосон, анхны төрөлжсөн хууль юм.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль нь 22 бүлэг, 161 зүйлтэй.

Энэхүү хуулийн онцлог шинж нь:

- Монгол улсын хөгжлийн зорилготой уялдан хөдөлмөрчдийн эрх ашгийг дээгүүрт тавьсан
- Иргэний хэргийн аль ч үе шатанд прокурор өөрийн үзэмжээр

¹⁰ Монголын Үндэсний Төв Архив, хөмрөг 284, данс 1, хувь нэгж 464

¹¹ Ж. Болдбаатар, Д. Лүндээжаниан, “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал”, УБ, 1997 он, 280 дахь тал

¹² БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох актын эмхтгэл, УБ, 1974 он, 6 дахь тал

¹³ Монгол Улсын Иргэний байцаан шийтгэх тухай хууль, УБ, 1952 он. /Үндэсний архивын газар/



оролцдог болов. Энэ нь хөдөлмөрчин ангийн эрх ашгийг хамгаалах зорилготой холбоотой.

- Иргэний хэргийн болон шүүхийн харьяаллыг тодорхой заажээ. Тухайлбал: Дээд шүүхэд 50 мянгаас дээш төгрөгийн нэхэмжлэлтэй иргэний бүх хэрэг харьяалагдан таслагддаг байв

- Тэмдэгтийн хураамж авах зүйл, хэмжээг нарийвчлан хуульчлав. Тухайлбал 150 хүртэл төгрөгийн нэхэмжлэлээс 2 төгрөг, 150-аас 750 хүртэл төгрөгийн нэхэмжлэлээс бүх нэхэмжлэлийн 2 хувь гэх мэт

- Нотлох баримтын асуудлыг бүлэг болгон хуульчилжээ.

- Шүүхийн шийдвэрийг Шүүх яамны сайд, улсын прокурор авч хянадаг байсан нь шүүхийн байгууллага хараат байсны нэг илрэл мөн.

3. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль 1967 он: 1960 оны Үндсэн хуулийн үзэл санааг тусгасан Социалист гэх тодотголтой Иргэний байцаан шийтгэх хуулийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын их хурлаас 1967 оны 6-р сарын 29-ны өдөр батлан гаргасан¹⁴.

Энэхүү хууль нь бүтцийн хувьд 6 хэсэг, 39 бүлэг 313 зүйлтэй бөгөөд "...Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэний шүүн таслах ажиллагааны зорилт нь тус улсын нийгмийн ба төрийн байгууламж, аж ахуйн социалист систем, социалист өмчийг хамгаалах, иргэдийн улс төр, хөдөлмөр, орон сууцны ба бусад хувийн болон эд хөрөнгийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол, түүнчлэн улсын албан байгууллага, үйлдвэрийн газар, хөдөө аж ахуйн нэгдэл бусад хоршоолол, олон нийтийн байгууллагын эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор иргэний хэргийг түргэн шаламгай, зөв шийдвэрлэх явдал мөн. Иргэний шүүн таслах ажиллагаа нь социалист Хууль ёсыг бэхжүүлэх, эрх зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх, иргэдийг эх орон, социализм коммунизмын үйл хэрэгт хязгааргүй үнэнч болгон хүмүүжүүлэх, БНМАУ-ын хуулийг хэлбэрэлтгүй биелүүлэх, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэн сахихад тус дөхөм үзүүлэх ёстой" хэмээн хуулийн зорилтыг тодорхойлов.

Иргэний байцаан шийтгэх тухай хуульд 1977 оны 5-р сарын 9-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд 1984 онд Д. Зундуй, Н. Чинбат нар албан бус тайлбар¹⁵ хийсэн нь иргэний байцаан шийтгэх хуулийн үзэл санааг ухаж ойлгоход дөхөм болсон. Энэхүү хуулийг 1952 оны Бүгд Найрамдах Монгол

¹⁴ БНМАУ-н хуулиуд. УБ. 1980 он, 426-542 дахь тал

¹⁵ Д. Зундуй, Н. Чинбат нар, "БНМАУ-н Иргэний байцаан шийтгэх хуулийн тайлбар", УБ, 1984 он



Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хуультай харьцуулан авч үзье.

| № | Харьцуулах шалгуур | 1952 оны хууль | 1967 оны хууль |
|---|--|--|---|
| 1 | Хуулийн журнал | БНМАУ-ын нүүдлийн байгууллагад иргэний хэргийг хянан шийдвэрлэх журмыг тогтоох | БНМАУ-ын нүүхүүдэл иргэний хэргийг байцаан шийтгэх журмыг тогтоох |
| 2 | Хуулийн бүтэн | Бүлэг /22/ зүйл /161/ | Хэсэг /6/ бүлэг /29/ зүйл 313 |
| 3 | Иргэний хэрэг үүсгэх үйлдлэл | Шүүхэд иргэний хэргийг дохигчдын нэхэмжлэлээр авч хянан шийдвэрлэнэ | Иргэний хэргийг нүүх: 1) Ооригийн эрх, хууднаар хамгаалагдсан ашиг сонирхлоо дорчилсон буюу маргаантай гэж үзээд гаргасан өргөдөл; 2) Улс, олон нийтийн ашиг сонирхол буюу иргэдийн эрх, хууднаар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзээд хэрэг үүсгэсэн прокурорын нэхэмжлэл; 3) Төрийн захиргааны ба улс, хориоолод, олон нийтийн байгууллага буюу иргэлээс сонирхогч этгээдийн шаардлагаас гадуур уг хэргийг хууль ёсоор нүүхэд мэдүүлж болох байвал тэлгээр байгууллага, иргэдийн өргөдлөөр үүсгэн хэлэлтэж болно. |
| 4 | Иргэний хэргийг хянагчлан шийдвэрлэх нүүхийн тогтолцоо | Аймаг, хот ба хэсгийн нүүх, Дээд нүүх, улсын арбитор | Аймаг, хот, дээд нүүх, Районы ба нүүдлийн нүүх, томвор ламын нүүх |
| 5 | Иргэний хэргийн орлологчид | Зохиогч тэдгээрийн тодонлогч, прокурор | Зохиогчид, гурвалдугаар этгээд, прокурор, улс, хориоолод, олон нийтийн байгууллага, иргэд, сонирхогч иргэд, төрийн захиргааны ба улс, хориоолод, олон нийтийн байгууллагыг иргэний хэргийн орлологчид гэнэ |
| 6 | Тэмлэгтийн хураамж | Дор дурдсан тэмлэгтийн татаарыг хураана. Үүнд: А. 150 хүртэл тоглогчийн нэхэмжлэлээс 2 тоглогч, Б. 150-аас 750 хүртэл тоглогчийн нэхэмжлэлээс бүх нэхэмжлэлийн 2 хуви, В. 750-аас дээш тоглогчийн нэхэмжлэлээс бүх нэхэмжлэлийн 3 хуви, Г. Эл хороонгийн чанартай бичиг хэргийн шийдвэрийг давж ялласан гомдлоос 3 тоглогч Д. Хэргийн шийдвэрийн хуудбар ба бусад баримт бичиг гэрлийг олгоход 2 тоглогч тус тус хураана. | Дор дурдсан хэмжээгээр улсын тэмлэгтийн хураамж авна: 1) Нэхэмжлэлийн үнэ 200 хүртэл тоглогч байвал 3 тоглогч; 2) Нэхэмжлэлийн үнэ 201-500 хүртэл тоглогч байвал 5 тоглогч; 3) Нэхэмжлэлийн үнэ 501-3000 хүртэл тоглогч байвал нэхэмжлэлийн үнийн 2%; 4) Нэхэмжлэлийн үнэ 3001-ээс дээш байвал нэхэмжлэлийн үнийн 5%; 5) Холдо аж ахуйн нэгдлүүдийн хооронд ба холдо аж ахуйн нэгдлээс улс, хориоолод, олон нийтийн байгууллагатай маргаж гаргасан нэхэмжлэлээс, түүний үнийн дүнгийн 1 хуви байх боловч нэг тоглогчоос багасгүй; 6) Хэлцлийн хүчин тогтоолор буюу хүчин тогтоолор бус гэж тооцуулахаар гаргасан нэхэмжлэлээс 3 тоглогч; 7) Эл хороонгийн чанартай бус нэхэмжлэл ба үнэлж болохгүй нэхэмжлэлээс 5 тоглогч; 8) Эл хороонг буюу орон сууцн холдох гэрээг оорилдох ба цуцлахаар гаргасан нэхэмжлэлээс 3 тоглогч; 9) Бичгүүмжилсэн эл хороонгийг чөлөөлүүлэхээр гаргасан нэхэмжлэлээс 5 тоглогч; 10) Гэрээг цуцлуулах ба байцаан шийтгэх, өнцгөн ажиллагааны татаар гаргасан өргөдлөөс улсын тэмлэгтийн хураамжит 5 тоглогч |



ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУДЫН ХӨГЖЛИЙН ТОЙМ

| | | | |
|----|---|---|---|
| 7 | Нотлох баримт | Зохигчдын гавлбарлал, гэрчийн мэдүүлэг, экспертний шинжилгээний дүн ба бичиг баримт зэргүүд болно. Зохиогч тус бүр ний баримт болгон үндэслэж байгаа зүйлээ нотлоход зохино. Нотлох баримтыг зохигчид нь гаргах ба мөн нүүх оорийн санаачилгаар цуглуулж болно. | Зохигчдоос оорийн явралтаа ба татгалдлаа үндэслэж байгаа зүйл нь бий эсэхийг хууль зассан журмаар нүүх тогтооход үндэ болсон ямар нэг баримт болон хэргийг зөв шинэвэрлэхээ ач холбогдол бүхий бусад зүйлийг иргэний хэргийг нотлох баримт гэнэ. |
| 8 | Иргэний байцаан шийтгэх ажиллагааны хугацаа | Иргэний хэргийг шүүхэд анх оролдог хүлээн авсан өдрөөс эхлэн 10 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд харин холдмөрийн нэхэмжлэлийг бол хүлээн авсан өдрөөс эхлэн 3 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. | Шүүх нь иргэний хэргийн нэхэмжлэл хүлээн авснаас хойш хүүхдийн тэтгэвэр болон тэжээгчээ алдсана тэтгэвэр гаргуулах, иргэдийн эрүүл мэндэл гэм хэр учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл, тэрчлэн холдмөрийн эрхийн харилцаанаас үүссэн маргааныг 14 хоногт, бусад маргааны талаар гарсан нэхэмжлэлийг 30 хүртэл хоногийн дотор аяч хэлэлцэнэ. |
| 9 | Иргэний байцаан шийтгэх ажиллагааны зарчим | Хуульчилж огоогүй | Шүүн таслах ажиллагаа нь иргэн бүр хууль ба шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг үндэслэх. Шүүн таслах ажиллагааг явуулах хэл, Шүүх хурлын ажиллагаа нь явагдах. Шүүх хурлын ажиллагаа амар, шуул, тасралтгүй явагдах. Хэргийн үзэнийг тогтоох ба оролдогчдын эрхийг хангах. Хэргийг дагаж шийтгүүлэн байгаа хууль тогтоомжийн үндсэн дээр шийдвэрлэх. |
| 10 | Давж явдалах гомдол гаргах | Шүүхээс гаргасан шийдвэр ба магадлалыг хэрэгт оролдогчдоос дээд шүүхэд 10 хоногийн дотор давж явдалах гомдлоо гаргаж болно. | Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор давж явдалах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичиж болно. |
| 11 | Шинээр илэрсэн нохиол байдал | 1. Шүүхээс гаргасан шийдвэр нь хуурамч буюу буруу баримт бичгийг үндэслэн хянан шийдвэрлэсэн болох нь хожим шүүхийн тогтоолоор буюу зохих байгууллагаас хүчингүй болгосон нь илэрсэл. 2. Шийдвэр нь гэрчийн этгээлийн худал мэдүүлгийг үндэслэсэн болох нь шүүхийн тогтоолоор илэрсэл. | 1. Шийдвэр, магадлал буюу тогтоол гаргах үед хүсэлт гаргагчид мэдэгдээгүй ба мэдэгдэх боломжгүй байсан нохиол байдал илэрсэл; 2. Шүүхийн шийдвэр, магадлал буюу тогтоол гаргахад үндэс болсон гэрчийн мэдүүлэг, шинжлээлийн магадлал худал байсан, орчуулга буруу байсан, бусад нотлох баримт хуурамч байсан буюу эсхүл шүүгч, зохигч, хэргийн бусад оролдогчдоос уг хэргийг шийдвэрлэх үед гаргасан гэм буруутай үйл ажиллагаа нь хуулийн хүчин тогтоолоор болсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор тогтоогловол; 3. Хэрэв шийдвэр, магадлал буюу тогтоол гаргах үндэслэл болсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол буюу шийдвэр, эсхүл торийн захиргааны байгууллагын тогтоол нь хожим хүчингүй болсон бол. |



4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ардчилсан маягийн хуулиуд:

Монгол улсад ардчилсан хөдөлгөөн өрнөж үүний үр дүнд 70 гаруй жилийн хөгжил бүхий социалист Үндсэн хуульт байгууллаас ангижран ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд батлан гаргаснаар социалист хэв маягийн хуулиудыг ардчилсан шинжтэй болгон шинэчлэх шаардлага гарч байлаа.

1992 оны Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх¹⁶ гэсэн хэсэгт хуульчилсан нь шүүхийн хараат бус, бие даан ажиллах боломжийг бүрдүүлэв.

Дээрх нийтлэг чиг хандлагаас үүдэн 1994 оны 5-р сарын 09-ны өдөр Улсын их хурлаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг батлан гаргасан.¹⁷

Шинэ хуулийн нэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хэмээн өөрчлөн томъёолсон нь байцаан шүүх зарчмаар явагдаж байсан иргэний процесс мэтгэлцэх зарчмаар явагдах болсонтой холбоотой.

Уг хуулийн зорилго болон бүтцийг 1967 оны Иргэний байцаан шийтгэх хуультай харьцуулж үзвэл,

| № | Харьцуулах шалгуур | 1967 оны ИБШ хууль | 1994 оны ИХШШ хууль |
|---|--------------------|--|---|
| 1 | Хуулийн зорилго | Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэний шүүн таслах ажиллагааны зорилт нь тус улсын нийгмийн ба төрийн байгууламж, аж ахуйн социалист систем, социалист өмчийг хамгаалах, иргэдийн улс төр, хөдөлмөр, орон сууцны ба бусад хувийн болон эд хөрөнгийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол, түүнтэн улсын албан байгууллага, үйлдвэрийн газар, хөдөө аж ахуйн нэгдэл бусад хориооодол, олон нийтийн байгууллагын эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор иргэний хэргийг түргэн шаламгай, зөв шийдвэрлэх явдал мөн. Иргэний шүүн таслах ажиллагаа нь социалист Хууль ёсыг бэхжүүлэх, эрх зөривгээх явдлаас урьдчилан сэргийлэх, иргэдийг эх орон, социализм коммунизмын үйл хэрэгт хязгааргүй үнэмч болгон хүмүүжүүлэх, БНМАУ-ын хуулийг хэлбэрэлтгүй биелүүлэх, хамтын аж байдалын социалист хэл журмыг хүндэтгэн сахихад тус зөхөм үзүүлэх ёстой. | Энэ хуулийн зорилт нь өөрийн буюу бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж иргэн, хуулийн этгээдээс нэхэмжлэл, хүсэлт, гомдол гарган мэдүүлсэн эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 2 | Хуулийн бүтэц | Хэсэг /6/, бүлэг /29/, зүйл /313/ | бүлэг/18/ зүйл/242/ |

¹⁶Монгол улсын Үндсэн хууль, УБ, 1992 он, “Төрийн мэдээлэл”, эмхтгэл, №1-р нийтлэгдсэн

¹⁷Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, УБ, 1994 он, № 8 нийтлэгдсэн



Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1994 оны хуулийг 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэхэд чиглэсэн томоохон өөрчлөлт орсон боловч уг хуулийн зарим заалтууд агуулгын хувьд хоорондоо зөрчилдөж, улмаар хийдэл гарч иргэний эрхийг зөрчих олон гарцтай болсон. Эл нөхцөл байдалд хууль тогтоогчид зохих дүн шинжилгээ хийж 2002 оны 01-р сарын 10-ны өдөр Улсын их хурлаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг 7 хэсэг, 20 бүлэг, 195 зүйлтэйгээр батлан гаргасан.¹⁸

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 оны 09-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн бөгөөд онөөг хүртэл уг хуульд нийт 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Энэхүү хуулийг 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай харьцуулан авч үзвэл дараах хэм хэмжээ шинээр хуульчлагдсан байна. Үүнд:

1. Иргэний хэргийг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг жил, хагас жил зэрэг тодорхой хугацаагаар тухайн шүүхийн шүүгчийн зөвлөгөөнөөс хуваарь гарган томилох

2. Тухайн шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг дээр дурдсан шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу томилох

3. Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал өөрчлөгдсөн:

- Сум буюу сум дундын, дүүргийн шүүх иргэний бүх хэргийг анхан шатны журмаар

- Аймаг, нийслэлийн шүүх нь иргэний хэргийг давж заалдах шатны журмаар

- Улсын дээд шүүх нь иргэний хэргийг ИХШХШ тухай хуулийн 172-р зүйлийн 2-т заасан үндэслэлээр хяналтын журмаар тус тус хянан шийдвэрлэдэг болов.

4. Нотлох баримтыг анхан шатны шүүх хуралдаан эхлэхийн өмнө гаргаж өгөх

5. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийг нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүний эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл нэхэмжлэлийг буцаах.

Хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол нэхэмжлэгч хэргийг түүний эзгүйд хянан шийдвэрлэх талаар хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд шүүх

¹⁸Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, УБ, 2002 он, №8 нийтлэгдсэн



нэхэмжлэгчээс гаргасан тайлбар болон бусад баримт нотолгоог үндэслэн хэргийг хянан шийдвэрлэнэ

Хэргийг зохигч талын эзгүйд хянан шийдвэрлэх тухай хүсэлтийг нэхэмжлэгч, хариуцагчийн аль аль нь гаргаагүй байсан ч хэргийг тухайн үед шугларсан нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан шүүх шийдвэрлэж болно. Ингэхдээ зохигч талуудаас урьд гаргасан тайлбарыг шүүх хуралдаан дээр гаргасантай адилтгаж үзнэ

6. Давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж байгаа этгээдээр улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлэх

7. Шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх

8. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шийдвэр, магадлалыг гардан авсан өдрөөс хойш давж заалдах журмаар бол 14 хоногийн дотор, хяналтын журмаар хэргийг хянуулахаар бол 30 хоногийн дотор тус тус гомдол гаргаж болно

9. Анхан шатны шүүхийн шийдвэрт зохигч гомдол гаргахдаа давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эсэхээ сонгон гомдлыг хэрэг хянан шийдвэрлэсэн тухайн шүүхэд ирүүлнэ

10. Зохигч талын нэг нь давж заалдах, эсрэг тал нь хяналтын журмаар гомдол гаргасан бол давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэх

11. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилсон шүүгч даргална

12. Энэ хуулийн 20.1;65.1.4,65.1.5;69.1;80 дугаар зүйл, 92.4; 97.1; 100.2; 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно

13. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх шийдвэрлэж тогтоол гаргана

14. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172-178-р зүйлд заасан журмыг баримтлах

• Хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээж авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, зохигчийн гомдлыг хавсарган гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд 3 хоногийн дотор, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.



• Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

• Иргэний танхимын шүүх хуралдааны тогтоолыг гомдол гаргагч этгээд хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт гаргаж уг хэргийг Улсын дээд шүүхийн хуралдаанд хэлэлцүүлнэ.

• Улсын дээд шүүхийн хуралдаан Улсын дээд шүүхийн нийт шүүгчдээс бүрдэнэ. Энэхүү хуралдаанаас тогтоол гаргах бөгөөд энэ нь эцсийн шийдвэр болно.¹⁹

Нюренберг хотын дээд шүүхийн тэргүүн шүүгч Ё. Кают 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн талаар тайлбарлахдаа "... Энэ хуулиараа Монгол улс нь хамгийн гол ач холбогдолтой асуудлуудын хувьд эрх зүйт төрийн шаардлагыг хангасан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйг бий болгож чадсан. Тийм учраас одоо шүүх болон бусад хуулийн байгууллагууд өдөр тутмын практик ажилдаа хуулиа хэрэглэхдээ зориулалтын утгыг зөв ойлгож хэрэгжүүлэх шаардлагатай"²⁰ гэж цохон тэмдэглэсэн байна.

Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиудыг түүхэн хөгжлийн талаас нь судлан авч үзэхэд уг хуулиуд улам боловсронгуй болон өөрчлөгдөж иржээ. Үүний үр дүнд:

1. Иргэний шүүн таслах ажиллагаа мөрдөн шүүдэг тогтолцооноос мэтгэлцэн шүүдэг тогтолцоонд шилжсэн,

2. Шүүгч, шүүхийн ажилтнууд төрийн ихэмсэг түшмэдийн байр сууриа өөрчилж хуульд захирагдан төрийн өмнөөс иргэд, хуулийн этгээдэд үйлчилдэг төрийн ажилтан болж ажиллах болсон

3. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч идэвхитэй ажиллах, мэтгэлцэх журмаар ажиллаж, маргаант асуудлуудаа шударга, хууль дээдэлдэг шүүхээр шүүлгэдэг журамд шилжих болов. Иргэний шүүн таслах ажиллагааны энэхүү өөрчлөлт өнөө үед гүнзгийрсээр байна

Эцэст нь хэлэхэд бид хуулиа нэг мөр ойлгож, зөв хэрэглэж чадсан цагт төрийн эрх зүйт, ардчилсан, мөн хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн тэрхүү эрхэм чанарыг бодитойгоор мэдрэх болов уу.

¹⁹ "Шүүгчийн ном", УБ, 2004 он, 146-147 дахь тал

²⁰ Ё. Кают, "Монгол улсын шинэ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй болон үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүй", тэргүүн дэлгэр, УБ, 2003 он, 5 дахь тал



АЖ ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРТӨНЦ ДЭХЬ СИНДИКАТИЙН ОРОН ЗАЙ, НИЙГМИЙН ХОР АЮУЛ

Хууль зүйн ухааны магистр Б.Намсрай

Өгүүлэлийн товчоон

- Оршил болгон өгүүлэх учир
- Синдикагын тухай ухагдахуун, хэлбэр
- Синдикатын нийгмийн хор аюул
- Синдикатуудын үйлддэг гэмт хэргийн хүрээ, газар авалт
- Эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам

Оршил болгон өгүүлэх учир

Саяхан болтол бид эдийн засгийн гэмт хэргийг дагнан үйлдэгчид, тэдгээрийн нэгдлийн талаар сонсохыг ч хүсэхгүй байлаа. Тийм учраас энэ төрлийн гэмт хэрэг, гэмт хэрэгтэнтэй тэмцэх арга зүй гэх зүйл хомсдож эхэлжээ. Нөгөө талаар хүн, төрд аюултай гэмт хэрэгтэй илүү тэмцэх нь тулгамдсан асуудал байсан бизээ.

Нийгэм, эдийн засгийн харилцаа сар жилээр биш, өдөр хоногоор өөрчлөгдөж, үүнийг даган эдийн засгийн гэмт хэргийн шинэ төрлүүд олширч, тэдгээр гэмт хэрэг үйлдэгчдийн нийгмийн хор аюул газар авч байгаа нь ирж буй олон аюулын нэгэн нь юм. Улс орон, олон нийт, олон улсын эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж, бизнес, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хор, хохирол учруулж буй этгээдүүд нь олон улсын хэллэгээр синдикат хэмээн тодорхойлогддог.

Синдикатийн хор аюулын тухай сүүлийн жилүүдэд олон улсад яригдаж, түүнтэй тэмцэх холбоо, түншлэлийг хууль хэрэгжүүлэгчид, судлаачид эрэлхийлж, онолын болон практик судалгаа хийх ажлыг хэдийнээс эхэлжээ.



Синдикат гэдэг нь нэр томъёоны хувьд нэгдүгээрт, хууль бус үйлдвэрлэл эрхлэгч, хоёрдугаарт хууль бус ашиг олохоор зохион байгуулагдсан нэгдэл хэмээх агуулгыг илэрхийлдэг. Синдикат гэдэг нь олон улсад нэгэнт дэлгэрч, хүлээн зөвшөөрөгдсөн томъёолол учир ганц үгээр Монгол хэлнээ авч үзэхийг төвдсөнгүй.

Синдикатын тухай ухагдахуун, хэлбэр

Зохион байгуулалттай гэмт явдал тэдгээрийг төлөөлөх бүлэглэлүүд үйлдэж буй гэмт хэргийнхээ төрөл аргаар бие биенээсээ ялгаатай болж бас хууль бус ажиллагаанд тус бүрнээ гаргуун болсон түүх дөнгөж зуугаадхан жилийн өмнө. Зохион байгуулалттай гэмт хэргийн төгс хэлбэр 20-р зууны эхэнд хүчээ авч эхэлсэн Хар гар, Коза ностра нарын бүлгүүдээр тодорхойлогдоно.

Доктор Д.Адъяабазар өөрийн бүтээлдээ зохион байгуулалттай гэмт хэрэг цэцэглэхэд хуулийн алдаатай зохицуулалт, толгойлогчдийн хоорондох чөлөө завгүй өрсөлдөөн байсныг тэмдэглээд Коза ностра мэтийн томоохон бүлэглэлүүд Америкийн нэгдсэн улсын жилийн төсвийн тавны нэг хувьтай тэнцэх хэмжээний цэвэр ашгийг гэмт хэргийн замаар олж байсныг дурьджээ.¹

Академич С.Нарангэрэл зохион байгуулалттай гэмт явдал ялангуяа синдикатын нийгмийн хор аюулын ихсэлтэд нөлөөлсөн шалтгааныг бүтээл туурвилаараа авч үзсэн юм.²

Шил шилээ даран гарч ирж, нэгэнт хүчирхэгжин бусдын анхаарлыг татахаа байсан зохион байгуулалттай гэмт байгууллага нь үйл ажиллагааныхаа чиглэлийг эдийн засаг, санхүүгийн тогтолцоотой уялдуулан гэгээн дүр төрхөө хувилгахаас өөр аргагүйд саяхнаас хүрсэн.

Мафийн хойно, түүний хойд насны гэгээн дүр болсон синдикат нь аж үйлдвэр, санхүүгийн үйл ажилгаанд идэвхтэй оролцож ердөө эдийн засгийн гэмт хэрэг дагнан үйлддэг зохион байгуулалттай гэмт этгээдүүдийн нэгдэл болов. Оөрөөр хэлбэл, зөвхөн эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж банк, санхүү, бизнес, худалдааны салбарт зохион байгуулагддагаараа синдикат нь мафиас ялгагдана.

Аж үйлвэрийн синдикат нь заавал олон улсад гэмт хэрэг үйлддэг. Энэ

¹ Д.Адъяабазар, Мафи, 1999, 24 тал

² С.Нарангэрэл, Зохион байгуулалттай гэмт явдал, 1991



нь өөрийн орны хяналт, татварын тогтолцооны хяналтаас ангид байх, бусад орнуудын эдийн засгийн цоорхой, сул хяналттай Засгийн газрын бодлого, банкны ажилчидын ёс зүйгүй байдлыг ашиглах зэрэг үр дүнг синдикатууд авчирдаг байна. Өөрөөр хэлбэл, эдийн засаг, хууль зүйн тогтолцооны гажилт, цооролтой, банк санхүүгийн бохирдсон улс орон синдикатуудын идэш болсон байдаг. Синдикат нь нүсэр их хөрөнгө цуглуулж, анхаарал татахуйц нэртэй компани корпораци байгуулж ажилладаг боловч үнэн хэрэгтээ үйл ажиллагааных нь 50% нь хууль ёсны явагдаж харин 50% нь хууль бус ажиллагаа байдаг.

Гадаад улсад үйл ажиллагаагаа явуулдаг ийм синдикатыг Offshore гэж нэрлэдэг. Олон улсын эрүүгийн цагдаа, Олон улсын цагдаагийн байгууллага, холбооны мөрдөх товчоо, европын цагдаагийн байгууллага зэрэг байгууллагаас хийсэн судалгаагаар синдикатууд толгойлогч үүрэг гүйцэтгэгчтэй байхаас гадна эдгээр үүрэг гүйцэтгэгчид луйвар хийх орнууд руугаа очин зохиомол компани байгуулах эсвэл хуурамч мөнгө үйлдэж нэг бол мөнгө угаах үйл хэргээ явуулан энэ үедээ бий болсон мөнгөн хуримтлалыг мөнгөн гуйвуулгаар эзэддээ илгээдэг болохыг тогтоожээ. Тухайлбал, Австралийн цагдаагийн байгууллага өөрийн нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулж байсан синдикатын дансанд 28 сая доллар гэнэтхэн ирсэнийг шалгахад энэ мөнгөнд гадаадын 3 компани холбоотой болох нь тогтоогдсон. Мэдээж энэ компаниуд эцэстээ зохиомол болох нь нотлох баримтаас харагдсан.

Олон улсад эдийн засгийн гэмт хэргийн үндсэн 3 төрөл байдаг.

1. Худалдааны луйвар
2. Мэдээлэл сүлжээний луйвар
3. Мөнгө угаах

Худалдааны луйварт, чанаргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах, хэрэглэгчийг хуурч мэхлэх, харин мэдээлэл сүлжээний луйварт дансны сүлжээнд нэвтрэн орж мөнгө хулгайлах, программ гэмтээх гэмт хэргүүд хамаарна.

Онөөдөр Австралийн компаниудын 33% бусад ихэнх улсуудад мөн ийм хувиар компаниуд синдикатуудын хууль бус үйлдлээр хохирол амсчээ.

Чикагогийн Бизнесийн их сургуулийн профессор Randell Krosner Олон улсын санхүүгийн салбарууд синдикатын нөлөөгөөр аюулд ороход ойрхон байна гэжээ. Зарим синдикатууд өөрсдийнхөө нутагт гэмт хэрэг үйлдэнэ. Тухайлбал, Нигер, Шинэ зиланд, Австралид гарч буй эдийн засгийн гэмт



хэргийн гол үйлдэгчид нь энэ улсын өөрийнх нь синдикат байхад америкт гэмт хэрэг үйлдэгчдийн дийлэнх нь Канад, Хятад, Оросын синдикат байх жишээтэй.

Синдикат нь зохион байгуулалттай гэмт хэргийн гол төлөөлөгчийн нэг болохын хувьд эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт хамтран оролцохын хэлбэрээр тодорхойлогдоно.¹ Гэмт хэрэгт хамтран оролцохын хэлбэр бол гэмт хэргийн зохион байгуулалтын хүрээгээр тодорхойлогдоно.

Өөрөөр хэлбэл синдикат нь урьдчилан үгсэж тохиролцсон бүлгээс зохион байгуулалттай бүлэг гэмт бүлэглэл хүртэлх гэмт хэрэгт хамтран оролцохын хэлбэрийг агуулдаг. Мөн синдикат нь амьдрал дахь нүүр царайгаараа чамин үнэт эдлэл зэргийг зүүж нүдэнд харагдтал худал ярьсан бүлэг луйварчид, зохион байгуулалттай хакерууд үгсэн тохиролцсон банкны цагаан захтнууд, сүржин нэртэй мөртлөө хууль бус ажиллагаатай компаниуд юм. Үүнээс үзвэл синдикат нь хууль бус эдийн засаг бизнесийн ажиллагаа явуулагчдын холбоо нэгдэл гэсэн ерөнхий ухагдахуунаас өргөн хүрээтэй болно.

Синдикатийн нийгмийн хор аюул

Нийгмийн хөгжлийн тулгуур нь үйлдвэрлэл, түүнтэй холбогдсон харилцаа бол² энэ харилцаанд хохирол учруулагч нь синдикатууд юм.

Синдикатын үйлддэг гэмт хэрэг нийгмийн хор аюулын хувьд үлэмж их байдаг. Нийгэмд эдийн засгийн зохистой хуваарилалт хийгдэж, санхүү банкны үйл ажиллагаа хуулийн шаардлагын дагуу явагдах нь зайлшгүй. Хэрвээ зах зээлд шударга өрсөлдөөнийг дэмжихгүй, шударга бус өрсөлдөөнийг хязгаарлахгүй бол энэ нь цаашлаад тэнцвэргүй байдал үүсгэх, авилгалыг өөгшүүлэх, нийгэмд далд эдийн засаг буй болгох хор аюултай. Зохион байгуулалттай синдикатууд нь үйл ажиллагаагаа өргөн хүрээнд явуулах, илүү их ашиг олохын тулд янз бүрийн өнгөлөн далдлалт хийж эдийн засгийн хууль ёсны үйл ажиллагаанд төөрөгдөл үүсгэдэг нь онц аюултай байдаг.

Далд эдийн засаг гэдэг нь хууль зүйн хүрээнд биш, түүнээс гадуурх хууль бус эдийн засгийн үйл ажиллагааны дүнд бүрэлдсэн байна. Хуулиар хориглосон зүйлсийг худалдах, арилжих, мөрийтэй тоглоом тоглох, татвар төлөхөөс зайлсхийх, мөнгө угаах, хуурамч зээлийн карт үйлдэх, зохиомол компани байгуулах, хилээр хууль бусаар бараа нэвтрүүлэх зэрэг нь далд

¹ Кулискова И.М., Уголовное право, Общая часть, 1995

² Марксист, Ленинист философийн үндсүүд, 1982, 245 тал



эдийн засгийг буй болгодог гол хүчин зүйл мөн. Далд эдийн засаг нь улс орны эдийн засгийн чадавхийг доройтуулдаг талаар Доктор Д.Адьяабазар “Мафи” бүтээлдээ өгүүлсэнийг миний бие дэмжиж байна.⁵ Энэ бүхнээс үзвэл Синдикат нь дараахь нийгмийн хор аюулыг бий болгодог.

1. Авилгалыг газар авахуулдаг.
2. Хууль ёсны эдийн засгийн үйл ажиллагааг тамирдуулдаг.
3. Гэнэн корпораци, банк, санхүүгийн байгууллагыг дампууруулдаг.
4. Шударга өрсөлдөөнд чөдөр тушаа болж, цаашид хийж болох бүтээн босголтоос татгалзахад хүргэдэг зэргийг нэрлэж болно.

Синдикатын үйлддэг гэмт хэргийн хүрээ, газар авалт

Синдикатын үйлддэг гэмт хэрэг хүрээгээрээ өмч, санхүүгийн харилцаанд халдсан байдаг онцлогтой. Сүүлийн жилүүдэд синдикатын үйлдэж моодорхох болсон гэмт хэрэг бол зээлийн карт, үнэт цаас, хуурамч мөнгө үйлдвэрлэх, мөнгө угаах, зохиомол дампуурлын хэргүүд юм.

Доктор Freda Adler нарын судлаачид контрабанда, хууль бус цагаачлал, хориглосон эм барааны наймаа зэрэг гэмт хэрэг нь гадаадын синдикатуудын байнгын үйл хэрэг болж байгааг жишээгээр тайлбарлажээ. Тухайлбал, олон мянган долларын урьдчилсан хөлсийг авч цагаачдыг Америкийн нэгдсэн улсад нэвтрүүлдэг Хятадын синдикатын үйл ажиллагааг тус улсын хууль хяналтын байгууллагынхан илрүүлжээ.⁶

Монгол улсын эрүүгийн хуульд хуульчлагдсан гэмт хэргүүдээс дараахь гэмт хэргүүдийг синдикатууд ихэвчлэн үйлддэг байдал илрэх болов.

- Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх
- Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх
- Бусдын эд хөрөнгийг завшин үрэгдүүлэх
- Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх
- Гэмт хэрэг үйлдэж олж авсан эд хөрөнгийг авах, борлуулах
- Банкны хууль тогтоомж зөрчих
- Хориглосон үйлдвэрлэл үйлчилгээ явуулах
- Үйлдвэрлэл үйчилгээ, худалдаа эрхлэх нэрээр халхавчлан хууль бус үйл ажиллагаа явуулах

⁵ Д.Адьяабазар, Мафи, 1999. 95-96 тал

⁶ F.Adler, Criminology, 1995. 4 page



аж үйлдвэр, үйлчилгээний ертөнц дэхь синдикатын орон зай, нийгмийн хэр агуул

- Санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох
- Дампууруулах
- Татвар төлөхөөс зайлсхийх
- Барааны тэмдэг аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашиглах
- Гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах
- Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах, хууль бусаар олж авсан хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулах гэмт хэргүүд хамаарч байна.

Монгол Улсын хэмжээнд мөрдөн шалгагдаж байгаа эдийн засгийн гэмт хэргүүдийн дийлэнх хувь нь ашиглалын болон залилан мэхлэх, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргүүд байгааг сүүлийн 12 жилийн тоон үзүүлэлт харуулж байна. 1991-2000 оны хооронд УБ-т үйлдэгдэж бүртгэгдсэн гэмт хэрэг нийтдээ дунджаар 8602 байсны 2122 нь ашиглал, аж ахуйн эсрэг гэмт хэрэг байсан бол сүүлийн 5 жил татвар төлөхөөс зайлсхийх, бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх, зохиомол аж ахуйн нэгж байгуулах гэмт хэргүүд эрс өсч эдгээр нарийн зохион байгуулалттай гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэх, синдикатын гэм бурууг тогтоох асуудалд ч янз бүрийн бэрхшээл учирч байгаа нь тодорхой болжээ.

Эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам

Эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам бол нэг их өргөн хүрээтэй тогтолцооны өөрчлөлт хийж ханаруулахын нэр биш юм.

Ерөөсөө синдикат гэж юу болохыг судалж түүнтэй тэмцэх зөв арга хэрэгслийг олж тогтоох явдал юм. Ойр зуурын хулгай хийх гэмт хэргийг синдикат үйлддэггүй гэдгийг анхаархаас эхэлж эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулна.

Синдикатын үйлддэг эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд 3 аргыг баримтлах зайлшгүй шаардлагатай.

- Хууль зүйн арга
- Эдийн засгийн арга
- Хосолмол арга

Хууль зүйн аргаар синдикат орших боломжийг бүрдүүлж байгаа цоорхой хуулийг хүчингүй болгох зохицуулалт, мөн синдикатыг оршиход нөлөө болж байгаа шударга бус өрсөлдөөний эдийн засгийн байгууллага,



10000 доллараас дээш мөнгөн гуйвуулгын эздийг заавал шалгаж, судалж байх хуулийн хэм хэмжээний практик дэлхийн олон улсад байна.

Хууль зүйн аргад мөн синдикатад эрүүгийн ямар бодлого хэрэгжих тухай түүнчлэн синдикатын үйлдэж байгаа эдийн засгийн гэмт хэргийг нотлох журам ямар байвал үр дүнтэй байхыг хамааруулна.

Эдийн засгийн арга бол эдийн засгийн тодорхой байдлын нүүр царай болсон банк санхүүгийн байгууллагууд хамтарч ажиллах, шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах асуудал хамаарна.

Эдийн засаг банк санхүүгийн системд ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчдийн компьютер, эдийн засгийн мэдлэгийг тэлэх, Синдикат гэж юу болох, түүний эрүүгийн эрх зүйн бодит шинжийг хуульчид олон нийт мэддэг болох, Олон улсын эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын шугамаар улс орнууд туршлага суралцах зэрэг нь синдикатын хууль бус ажиллагаатай тэмцэхэд ач холбогдолтой юм.



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ АСУУДАЛ

Докторант, Мэргэд овогтой Цолмонгийн Цэлмэг

Монгол Улс “НҮБ-н Хүүхдийн эрхийн тухай конвенци”, Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар НҮБ-с гаргасан “Эр-Риадын үндсэн зарчим”, насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-с гаргасан стандартын наад захын журам /Бээжингийн журам/, “Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан НҮБ-с гаргасан журам” зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдсэн орсоны хувьд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулах учиртай билээ.

Опөөдөр бидний хойч ирээдүй болсон олон мянган хүүхэд орон гэргүй тэнүүчилж, гэмт хэргийн замд хүссэн хүсээгүй татагдан орж байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна.

Монгол улсын хүн ам зүйн бүтцийн 46.6 хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзлэж байгаа бөгөөд хүүхэд, залуучуудын хүмүүжил, ёс суртахууны доголдол, тэднээс үйлдэж байгаа гэмт хэргийн шинж, нийгэмд учруулж буй хор хөнөөл нь анхаарал татахаас аргагүй байдалд хүргэж байгаа ба тэдний дотор гэмт хэрэг үйлдэгч насанд хүрээгүй хүмүүсийн зонхилох хэсэг болох 14-17 насныхан нийт хүүхдүүдийн 20 гаруй хувийг эзлэж байна¹.

Манай хуульчид насанд хүрээгүй хүн, хүүхэд гэдэг ойлголтуудыг зааглан авч үздэг нь буруу бөгөөд олон улсын гэрээ, хэлэлцээр үндэсний хууль тогтоомжийн дагуу 18 насанд хүрээгүй хүнийг хүүхэд гэдэг тул цаашид насанд хүрээгүй этгээл гэдэг нэр томъёог хүүхдийн гэж өөрчлөх нь олон улсын жишигт нийцэх юм.

Хүүхэд, залуучуудын амьдралын туршлага нимгэн, аливаа үзэгдэл үйл явдлын мөн чанарт буурь суурьтай хандах чадвар мөхөс, тэсвэр хатуужил

¹ Монгол улсын хүн амын тооллого, 2000 он. Үндэсний статистикийн газар



багатай, бусдыг дууриамтгай хэт сонниучхан байдаг шилжилтийн насны сэтгэхүйн онцлогуудаас шалтгаалан элдэв муу юманд өртөгдөх нь амархан байдаг².

Насанд хүрэгсдийн үйлдсэн хэрэгтэй харьцуулж үзвэл хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг нь ихэнхдээ учруулсан хохирлын хэмжээ, нийгмийн аюулаар харьцангуй бага байдаг ба гэмт хэрэг үйлдсэн аргын хувьд нарийн боловсруулагдаагүй, гэнэдэж осолдсон хандлагатай байх нь цөөнгүй юм.

Хүүхдүүдийн үйлдсэн хэргийн нилээд хэсэг нь хүүхдийн гэнэн томоогүй дүрсгүйтэл, тоглоом наадмаасаа болж, бие биенийхээ өмнө эр зоригтой, ухаан самбаатай бие даасан хүн болохоо харуулах гэсэн онгироо явдал, бусдыг даган дууриасанаас, тухайн цаг үеийн үйл явдал, нөхцөл байдлыг буруу үнэлсэнээс, сонирхсон эд зүйлийг олж авахыг эрмэлзсэн сэтгэхүйн дотоод тэмүүлэлдээ автсанаас шалтгаалсан байдаг.

Оөрөөр хэлбэл хүүхдийн үйлдэж байгаа хэргийн ихэнх нь оюун санаанд нь нийгэмд харш үзэл бодол хэвшил болон тогтсоноос шалтгаалдаггүй харин тухайн цаг үеийн нөхцөл байдал, болж буй үзэгдлийг зөв үнэлж түүнтэй холбогдуулж өөрийнхөө явуулж буй үйл ажиллагааны нийгмийн хор уршигийг богино хугацаанд бүрэн гүйцэд ойлгож үнэлэх дадлага, чадвар дутсантай холбоотойгоор гарч байгаа юм.

Чухам энэ гэмт хэрэг, зөрчил гаргасан хүүхдийг цээрлүүлэн шийтгэхийг урьтал болгохгүйгээр юуны өмнө хүмүүжлийн шинж чанартай арга хэмжээ авах нь илүү ач холбогдолтой юм.

Гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн дунд хөвгүүдийн эзлэх хувийн жин ямагт өндөр буюу 90-95 хувийг эзэлж байна.

Сүүлийн үеийн судалгаагаар гэмт хэрэг үйлдсэн сэтгэл зүйн гажигтай хүүхдүүдийн тоо нэмэгдэж байгаа байдал манай орны хувьд ажиглагдаж байна.

Энэ нь хэрэг хариуцах чадваргүй хүрээнд биш хариуцах чадвартай гэсэн эмнэлгийн дүгнэлт гарч байгаа хэдий ч сэтгэхүйн ямар нэг хэлбэрийн гаж соготой хүүхдүүд их байгаа тухай яриа юм. Гэтэл бидний хийсэн судалгаагаар гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн хэрэг хариуцах чадвартай эсэхэд болон ухаан санаа нь гүйцэд хөгжсөн эсэхэд эргэлзээ төрвөл шүүхийн

² Н.Жанцаг, Криминологи, УБ хот, 2003 он, 56-р тал.



сэтгэц эмгэг судлалын шинжилгээ хийнэ гэсэн заалт амьдрал дээр хэрэгждэггүй болох нь харагдаж гэмт хэрэг үйлдсэн 300 хүүхдийн нэгд нь ч шинжилгээ хийгээгүй байлаа.

Судалгаагаар гэмт хэрэг үйлдсэн 10 хүүхдийн нэг нь сэтгэл мэдрэлийн гаж согогтой байгаа бөгөөд ийм согог үүсэх нь төрөлтийн улмаас, эцэг эхийн удамшлаас, согтуу үедээ олдсон гэх мэт олон шалтгаантай байдаг.

Үүний зэрэгцээгээр хүүхдүүдийн дунд гэмт хэргийн бүлэг зохион байгуулагдах явдал ялангуяа хот суурин газар тохиолддогийг анхаарахгүй байж болохгүй бөгөөд энэ нь гол төлөв насанд хүрсэн гэмт этгээдийн удирдлага зохион байгуулалтын доор бий болж байдаг.

Сүүлийн 5 жилд хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл, хулгайлах 3565 гэмт хэрэг, хүчингийн 213 гэмт хэрэг, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 329, хүн амины 93 гэмт хэрэг, 460 танхайрах гэмт хэрэг, булаалт 48 гэмт хэрэг, дээрэмдэх 99 гэмт хэрэг, залилан мэхлэх 28 гэмт хэрэг тус тус үйлдсэн байна¹.

Статистик мэдээнээс үзэхэд нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн эзлэх хувийн жин дунджаар 5 орчим хувь болж байгаа бөгөөд цаашид өсөх хандлагатай байгааг харж болно.

Сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл 14-17 насны 150 хүүхэд тутмын нэг нь гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрын хувьд гудамж талбай, олон нийтийн газарт 1059 гэмт хэрэг, албан газарт 186, орон байранд 817, орц хонгилд 144 гэмт хэрэг тус тус үйлдэгджээ⁴.

Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн тоо бүртгэлийн мэдээгээр гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн тоо сүүлийн 10 жилд 2 дахин нэмэгдсэн бөгөөд жил бүр дунджаар 8-10 хувиар өссөн байна. Зарим нэгэн тоо баримтыг дурьяая.

а. Сүүлийн 5 жилд 5297 гэмт хэрэгт 8052 насанд хүрээгүйчүүд холбогдон шалгагдсан нь өмнөх 5 жилтэй харьцуулахад гэмт хэрэг 900 буюу 14.5 хувиар буурч, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо 1734-өөр буюу 27,4 хувиар өссөн байна.

Дээрх онуудад насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн бүх гэмт хэргийн 70 хувийг хулгайлах, 7.0 хувийг танхайрах гэмт хэргүүд эзэлж байна.

¹ Б.Болдбаатар. Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлын шалтгаан судлалын асуудал. УБ. 2004 он.

⁴ Мөнг тэнд



Насных нь байдлаар үзвэл 14 насанд хүрээгүй хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэргийн тоо жилд 80-100-гийн хооронд хэлбэлзэж ямар нэгэн хариуцлага тооцох боломжгүй, иргэд хохироод үлдсэн байхад 14 настай хүүхдүүдийн тоо 7 хувь, 15 настай хүүхдүүдийн эзлэх хувийн жин 17-18 хувь, 16 настай хүүхдүүд 30 хувь, 17 настай нь 45 хувийг эзлэж байна⁵.

б. Улсын хэмжээнд 2005 оны эхний 10 сарын байдлаар 828 гэмт хэрэгт 1239 насанд хүрээгүйчүүд холбогдсоныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 8.0-аар буюу 11.0 хувиар, холбогдогч нь 5 хувиар өссөн байна.

Энэ онд насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэгт ерөнхий боловсролын сургуулийн 429 сурагч холбогдсон нь өнгөрсөн оныхоос 12 хувиар өссөн байна.

2005 оны эхний 10 сарын байдлаар 1500 орчим хүүхэд хараа хяналтгүй тэнэж, 100 орчим хүүхэд траншейнд амьдарч байгаа гэсэн мэдээ байна.

Онөөдрийн байдлаар хорих 411 дүгээр ангид 110, цагдан хорих 461 дүгээр ангид 55, эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар ангид 9, нийт 184 насанд хүрээгүйчүүд хорих ял эдлэж байна.

Хүүхдийн гэмт хэрэгт шүүхээс аль болох хорихоос өөр төрлийн арга хэмжээ авдаг болох нь бидний судалгаанаас харагдсан бөгөөд 300 хавтаст хэргийг судлаж үзэхэд 10 хэргийг хэрэг бүртгэлтийн шатанд хэрэгсэхгүй болгосон, 14 хүүхдийн хорих ялыг тэнссэн, 229 хүүхдийн ялыг хойшлуулсан, хүнд гэмт хэрэг үйлдсэн 27 хүүхдийн хорих ялыг биечлэн эдлүүлэх, 6 хүүхдийг баривчлах ялаар шийтгэсэнээс харж болно⁶.

Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах, нөхөн сэргээх, насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг олж тогтоох, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга замыг сонгон авах, улмаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох нь энэ төрлийн гэмт явдлыг бууруулах гол нөхцөл юм.

Монгол Улсын хууль тогтоомжийг судлаад үзэхэд 53 хуульд хүүхдийн эрхийн талаархи хэм хэмжээг ямар нэгэн байдлаар тусгасан байгаагаас Үндсэн хууль, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай, Хүүхдийн

⁵ Судалгааны тайланг хавсраат 1-с үзнэ үү!

⁶ мөн тэнд



эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн тухай болон гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиуд, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиуд онцгой байр суурьтай байдаг.

Үндсэн хуулийн 16-р зүйлийн 11 дэх хэсэгт.. гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална, мөн зүйлийн 13 дахь хэсэгт.. хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно, хэнд ч болов эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй⁷ гэж заажээ.

Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ.

Мөн 16-р зүйлийн 14 дэх хэсэгт.. эрх эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нохон төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно гэж бас заасан нь хүүхдэд нэг адил хамаарна.

Бие хүний төлөвшилтөнд хамгийн гол нөлөөтэй анхдагч орчин, хүчин зүйл бол гэр бүл юм. Судлаачид бие хүн үзэл бодол, хүмүүжлийнхээ 80 хувийг гэр бүлийн орчинд байхдаа олж авдаг гэж үздэг. Хүний хүмүүжлийн анхдагч суурь нь гэр бүлийн хүмүүжил, эцэг эхийн зан төлөв, тэдний хоорондын харилцаан дээр үндэслэгдэж тогтдог.

Гэр бүл дэх хүмүүжлийн буруу нөлөө, гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нийгэмд харш зан төлөвтэй байх /хэт шуналтай, хувиа хичээсэн, байнга архидан согтуурдаг г.м/, эцэг эх нь хүүхдээ хүмүүжүүлэх буруу аргыг хэрэглэдэг /хэт эрхлүүлэх, зөнд нь орхих, бие биенээсээ үндэслэлгүй өмөөрөх г.м /, хүүхэдтэй зэрлэг догшин, бүдүүлэг харьцах, ад үзэх, гадуурхах, гэрээс хөөх, гэр бүлийн гишүүдээс хэн нэг нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэх, гэр орноо архидалт, тоглоомын газар болгох, бүтэхгүй явдалтай

⁷ Монгол Улсын Үндсэн хууль. ХЗҮТ. 2004 он.



хүмүүсийг гэртээ орогнуулах, гэр бүл салж сарних, байнгын хэрүүл тэмцэлтэй байх, эцэг эхийн хайр халамж дутах, хүүхдийг гэр орноосоо дайжихад хүргэх зэрэг нь хүүхэд хүмүүжлээр доголдох, зан авир нь эвдрэх үндэс болдог.⁸

Зөвхөн хүүхдийн хувьд ч биш гэр бүлийн бусад гишүүдийн хувьд ч гэр бүлийн орчин ямар байгаагаас цаашдынх нь үйл ажиллагаа шууд хамаардаг бөгөөд гэр бүл хэрүүл, шуугиангүй, хангалттай орлого олдог, эхнэр нөхөр эв найртай, ухаантай бол тэр гэр бүлийн гишүүд гэмт хэрэг бараг үйлддэггүй бол гэр бүлд нь хүчирхийлэл газар авсан, хэрүүл зодоонтой айлын гишүүд гэмт хэрэг үйлдэх магадлал өндөртөй.

Сүүлийн үед манай улсад гэр бүл дэх хүчирхийллийн шинж чанар, тоо огцом өсөж гэр бүлийн хүрээнд нийгэмд аюултай олон гэмт хэргүүд үйлдэгдэх болсон нь хүүхдийн хүмүүжил, сэтгэл зүйд томоохон цохилт өгч байгаа нь маргаангүй юм.

Судалгааны дүнгээр 3 эмэгтэй тутмын нэг нь хүчихийлэлд өртдөг гэдэг нь цаанаа 3 айл бүрийн нэгэнд эхнэр, хүүхдээ хүчирхийлэгч байгаа гэсэн хэрэг бөгөөд манай хуульчид гэр бүлийн хүчирхийллийн хуульд туйлын хойрго хандаж ... “эр эмийн хооронд илжиг бүү жороол” гэсэн байр суурьтай байдаг нь эцэстээ бүр хүнд гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл, суурийг тавьдаг.

Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шийдвэрлэх ажиллагааг анхааралдаа авч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат болгонд мэргэжлийн төдийгүй мэргэшсэн дадлага туршлагатай ажилтнууд эрхлэн явуулах нь зүйтэй.

Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийн хэргийн асуудлаар мэргэшсэн өмгөөлөгч, прокурор, шүүгч байхгүй байгаа учир хүүхдийн сэтгэл зүйг ойлгон мэдэрдэг, мэргэшсэн хуульчдыг бэлтгэн гаргах нь зайлшгүй шаардлагатай. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг мөрдөн байцаах үед сэтгэл судлаач төдийлөн оролцдоггүй ба сурган хүмүүжүүлэгч байлцдаг боловч процессийн ажиллагааны зорилтыг тэр бүр биелүүлдэггүй, хүүхдийн хэргийг хялбарчилсан байдлаар шийдвэрлэх журам хуулинд тусгагдаагүй, эрүүгийн хариуцлагаас чөлөөлж хүмүүжлийн арга хэмжээ авах тогтолцоо үгүйлэгдсээр байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд насанд хүрээгүй хүмүүсийн

⁸ Ц.Цэлмэг. Криминологи. УБ. 2005 он. 45-р тал.



өдүүлсэн гэмт үйлдлийг аль болох богино хугацаанд шийдвэрлэх, өмгөөлөгчийг эрүүгийн хэрэг үүсгэсэн үеэс татан оролцуулах практик тогтоох шаардлагатай.

Хүүхдийн эмзэг сэтгэхүйг харгалзан шүүх хуралдааныг хаалттай хийх, тэр ч бүү хэл хуралдааны танхимд хэнийг байлгах, байлгахгүйг шийдвэрлэдэг нэмэлт эрх хэмжээг шүүхэд олгож болох юм. Цаашид Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хөнгөн гэмт хэрэг болгосомжгүй үйлдсэн хүүхэд, хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдэж, сайн дураараа хэргээ илчлэн ирсэн, хохирлоо нөхөн төлсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлж болохоор хуульчлах нь хүмүүнлэг иргэний нийгмийн болон олон улсын жишигт нийцэх юм.

Түүнчлэн хорих ялыг тэнсэх үндэслэл журмыг хүүхдийн хувьд илүү боломж нээн өгч хүнд гэмт хэрэг анх удаа үйлдсэн, хохирлоо нөхөн төлсөн тохиолдолд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэж хянан харгалзах эрх, боломжийг шүүхэд өгөх шаардлагатай.

Хүүхэд анх удаа гэмт хэрэг үйлдээд, хохирлоо төлсөн тохиолдолд шүүхээс шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хойшлуулах ба энэ нь хүүхдийг тодорхой ажил сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар, сургуулиа өөрчилсөн тухайгаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх үүрэг өгч, түүнийг хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг эцэг эх, хамт олон, ойрын төрөл саданд нь хариуцуулдаг хуультай.

Хуулийн заалтаас үзэхэд ял хойшлуулах журмыг хэрэглэхэд гэмт хэргийн ангилалтыг шалгуур болголгүй хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд оногдуулсан хорих ялыг ч хойшлуулах боломжтой юм.

Амьдрал дээр шүүх нь ял хойшлуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзана гэсэн хуулийн заалтыг удирдлага болгон хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд оногдуулсан хорих ялыг хойшлуулалгүйгээр биечлэн хорих ялыг эдлүүлж байна.

Мөн насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн боловч мөрдөн байцаалт, шүүхийн шатанд 18 насанд хүрсэн бол хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулахгүйгээр ердийн журмаар



шийдвэрлэж байгааг өөрчлөх шаардлагатай бөгөөд нэгэнт гэмт хэрэг үйлдэх үедээ насанд хүрээгүй байсан л бол хөнгөлөлт эдлэх учиртай.

300 хүүхдэд ял оногдуулсан байдлаас харахад 229 хүүхдэд оногдуулсан хорих ялыг хойшлуулсан, зөвхөн 27 хүүхдийн хорих ялыг биечлэн эдлүүлэхээр заасан нь хүмүүнлэг ёсны зарчимтай нийцэж байна гэж дүгнэсэн.

Насанд хүрээгүй этгээд анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, түүнд ял оногдуулахгүй байх нь зохистой гэж шүүх үзвэл хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авна, хэрэв уг этгээд засарч хүмүүжсэн нь харагдахгүй, дахин зөрчил гаргавал түүнийг насанд хүрээгүй хүмүүсийн сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах арга хэмжээгээр сольж болно гэж заасан ч уг байгууллага нь одоо ч сураггүй хэвээр л.

Судалгаанаас үзэхэд шүүх 300 хүүхдийн 12 т нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан бөгөөд хугацаа тогтоож засарч хүмүүжихийг даалгасан тохиолдол 5, эцэг эхийнх нь хяналтанд өгсөн тохиолдол 7 удаа давтагдлаа.

Эрүүгийн хуульд гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд шүүх 7 төрлийн ял оногдуулахаар хуульчилсан бөгөөд элгээрээс торгох, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах гэсэн 4 төрлийн ялын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд зориулсан ямар нэгэн хөнгөлөлт байхгүй бусад 3 төрлийн ял дээр зохих хөнгөрүүлэх заалтууд байна.

Эрүүгийн хуулийн 51-р зүйлд баривчлах ялын талаар заасан бөгөөд 51.3 дахь хэсэгт..баривчлах ялыг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед 16 насанд хүрээгүй этгээдэд оногдуулахгүй, мөн хуулийн 52.3 дахь хэсэгт.. 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд 15 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй, 52.8 дахь хэсэгт.. хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан, хорих ял шийтгүүлсэн эмэгтэй ялтаны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ гэсэн энэрэнгүй заалтууд байдаг.

Эрүүгийн хуулийн 53.4-р зүйлд.. 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй гэсэн заалтуудаас үзэхэд онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүүхэд 15 жилээс хэтрэхгүй хорих ялаар шийтгэгдэх, хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид болон гянданд



эдлүүлэхгүй, зөвхөн насанд хүрээгүйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид ялыг эдлүүлэх нь тодорхой байна.

Эрүүгийн хуулинд зөвхөн дээр дурьдсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээнээс гадна эрүүл мэнд, хөдөлмөр, биений тамир, соёлын болон оюуны бүтээл туурвих хөтөлбөрт албадан хамруулах /түр сургалт, мэргэжил олгох, ажлын байраар хангах, эмчилгээнд хамруулах, тамирчин болгох г.м./, нийтийг хамарсан олон нийтийн ажилд татан оролцуулах, нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх, тодорхой субъектээс уучлал гүйлгах, хамт олны дунд сэтгэл зүйн ярилцлаганд оруулах, энцэг эх, хууль ёсны бусад төлөөлөгчийн зөвшөөрсөнөөр хүмүүжигдэх таатай засаг захиргааны нэгжийг сонгуулах, тодорхой орчны хүмүүстэй харьцахгүй байхыг даалгах, тодорхой цаг хугацаанд тухайн орчноос гадагш явахгүй байхыг даалгах, гэрийн хорионд байлгах зэрэг олон төрлийн арга хэмжээнүүдийг сонгон хэрэглэх эрх зүйн орчинг бий болгох зайлшгүй шаардлагатай юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулиар шүүхэд хуульд зааснаас доогуур ял шийтгэл оногдуулах эрхийг хассанаар /1986 оны Эрүүгийн хуулийн 39-р зүйлд байсан заалт/ олон улсын жишгээс нэг алхам ухарсан бөгөөд одоо энэ нь амьдрал дээр тохирохгүй байгаа нь нэгэнт тодорхой болсон учир ядахдаа л насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн хэрэгт ял оногдуулахдаа хуульд зааснаас хөнгөн ял шийтгэл оногдуулах эрхийг шүүхэд өгөх нь зүйтэй юм.

Насанд хүрээгүй ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй гэсэн боловч жилд 8-аас дээшгүй удаа удаан хугацааны уулзалт хийж болно, насанд хүрээгүй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол сард нэг удаа түр, 2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно гэсэн заалтууд нь хоорондоо зөрчилтэй хүүхдийн эрхийг зөрчсөн заалтууд учир цаашдаа түр болон удаан уулзалт хийх, илгээмж авах тоог хязгаарлах ёсгүй гэж үзнэ.

Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буяны болон бусад байгууллага, иргэнийг оролцуулж болох ба ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор ялтны сайн дурын байгууллага ажиллуулж болно.

Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн



хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ, боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна, хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно, хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна гэсэн заалтууд ч хуульд бий. Үүнийг бүрэн биелүүлж чадахгүй байна.

Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг хорьж мөрдөх үндсэн хугацаа 1 сар, сунгах дээд хугацаа нь 18 сар байгаа нь насанд хүрэгсэдтэй харьцуулахад харьцангуй бага байгаа мэт харагдавч урт хугацаагаар цагдан хорьж хүүхдийн эрхийг зөрчихөд хүргэж байгаа учир хуулинд өөрчлөлт оруулах замаар хорьж мөрдөх нийт хугацааг 6 сараас хэтрэхгүйгээр хуульчлан тогтоох шаардлагатай.

Эрүүгийн хуульд хүнд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг хохирол төлсөн байсан ч оногдуулсан хорих ялыг тэнсэх боломжгүй, гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй байгаад хожим шүүх хуралдааны үед насанд хүрсэн хүнийг хүүхэд гэж үзэлгүй ямар нэгэн хөнгөлөлтгүйгээр ял оногдуулдаг, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах журмыг гэмт хэргийн ангилалт харгалзалгүйгээр хэрэглэх боломжийг хуульд нээлттэй орхисон ч шүүх хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд уг журмыг хэрэглэдэггүй, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудын насанд хүрээгүй этгээдтэй холбогдох заалтуудыг тайлбарласан албан ёсны тайлбар байхгүй, хуульд заагдсан боловч “Хүүхдийн асуудал эрхэлсэн сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага”, хүүхдийн хэрэг эрхлэх хороог байгуулаагүй зэрэг анхаарвал зохих ноцтой зөрчил дутагдлууд цөөнгүй байсаар байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг зөвхөн хууль тогтоомжийг боловсронгуй болгосоноор асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй бөгөөд хууль сахиулах байгууллагуудын ажилтануудыг байнгын сургалтанд хамруулах, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх, прокурор, мөрдөн байцаагчийг бэлтгэх, ажиллах нөхцөл боломжийг хангах, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэхдээ энэрэнгүй, зөөлөн сэтгэлээр ханддаг болгох ажлыг зохион байгуулах нь чухал.



Эцэст нь дүгнэхэд манай улсын хууль тогтоомжийг судлахад хүүхдийн эрхийн асуудлыг олон улсын жишигт ойртуулан хуульчилсан, гэмт хэрэг зөрчилд холбогдсон хүүхдэд оногдуулах ял шийтгэл харьцангуй зөөлөн, уян хатан байгаа зэрэг сайн талууд байгаа ч анхаарах ёстой дутагдалтай асуудал ч цөөнгүй байгаа юм.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийн эрхийн тухайд дараахь асуудлыг зайлшгүй хөндөж, Эрүүгийн болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж зохиогчийн зүгээс үздэг. Үүнд:

1. Хорих ялыг зөвхөн хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн, хохирлоо нөхөн төлсөн этгээдэд хэрэглэдэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хувьд хүнд гэмт хэрэг үйлдсэн байсан ч шүүх хэргийн болон хувийн байдлыг харгалзан оногдуулсан ялыг тэнсэх бололцоотой байхаар Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах.

2. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хувьд шүүх тухайн хүүхдийн хувийн байдал болон үйлдсэн хэргийн нөхцөл байдлыг харгалзан хуульд зааснаас доогуур ял оногдуулах эрхийг шүүхэд олгохоор Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах

3. Хөнгөн гэмт хэрэг болгоомжгүй үйлдсэн болон хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн боловч хэргээ илчлэн ирсэн, хохирлоо нөхөн төлсөн, хүүхэд нь хүч, заналхийлэлд өртсөн, бусдын эрхшээлд байсны улмаас гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүүхдийг хэргийн болон хувийн байдлыг нь харгалзан шүүх эрүүгийн хариушлагаас чөлөөлөх эрх зүйн орчин, боломжийг бүрдүүлэх

4. Хүүхдийн асуудал эрхэлсэн сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага болон Хүүхдийн хэрэг эрхлэх хороог даруй байгуулах

5. Гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй л бол хүүхэд гэж тооцон Эрүүгийн хариушлага хүлээлгэхдээ хөнгөлөлттэй хандах.

6. Хүүхдийн гэмт хэргийг мөрдөн шалгах мэргэшсэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий прокурор, шүүгч болон өмгөөлөгчийг бэлтгэх, тэднийг дагнан ажиллах нөхцөл боломжоор хангах

7. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг олшруулж, аль болох эхний ээлжинд хэрэглэх ёстойг хуульчилж өгөх шаардлагатай. Тухайлбал, гэрийн хорионд байлгах, уучлал гуйлгах, ярилцлаганд оруулах, тодорхой орчны хүмүүстэй харьцахгүй байхыг даалгах,



тодорхой цагт гадагш гарахгүй байхыг даалгах г.м .

8. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хүмүүжлийн чанартай албадагын арга хэмжээ авах, оршоол, уучлал үзүүлэх журмыг хуульчилж өгөх

9. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг 18 сар хүртэл цагдан хорих боломжтой байгаа өнөөгийн хуулийг өөрчилж хүндэтгэр гэмт хэрэгт онцгой тохиолдолд 2 сар хүртэл, хүнд гэмт хэрэгт 4 сар, онц хүнд гэмт хэрэгт 6 сараас хэтрэхгүйгээр цагдан хорьж болохоор хуульчлах.

10. Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар гэр бүлийн шүүх байгуулах, ажиллах үндэслэл, журмыг хуульчилж өгөх.

11. Баривчлах ялтай хүүхдүүдийг хорих ял эдлэж байгаа хүүхдүүдтэй бөөнд нь хорьж байгаа нь хүүхдийн эрх болон Эрүүгийн хуулийн заалтыг ноцтой зөрчиж байгааг анхаарч цаашид тусгай байранд ганцаарчлан хорих талаар арга хэмжээ авах зохистой.



ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ: МОДЕРН БА ПОСТМОДЕРН ХАНДЛАГА

(Хууль зүйн шинжлэх ухааны ерөнхий онолын асуудалд)

*М.Батсуурь (докторант)**МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш*

“Орчин үеийн сэтгэлгээ, орчин үеийн асуудлууд гэдэг нь сонгодог сэтгэгчдийн бидний зүг чулуудсан шинэ шинэ гэрэл гэгээ, оюун бодлыг дахин тунгаах, сөхөн тавих явдал билээ”.¹

М.Д.А. Фреман

Эрх зүй хэмээх ойлголтыг танин мэдэх гэсэн оюуны эрэлхийлэл нь хүн төрөлхтний түүхийн мянга мянган жилтэй холбогддог боловч түүнийг оюуны бусад хэрэглүүрээс зааглан тодорхойлж, гагцхүү өөрсдийн хэрэглээндээ хамаатуулан шинжлэх ухаанч байдлаар авч үзэх болсон нь өнгөрөгч хоёр зууны ололт билээ. Гэхдээ би энэ илтгэлдээ хүн төрөлхтний мөнхийн асуултын нэг болсон “эрх зүй гэж юу вэ” гэсэн асуултад цэг тавих гэсэнгүй бөгөөд тавих ч боломжгүй биз ээ. Харин энэ асуултад хариулахыг оролдож буй орчин үеийн зарим хандлагыг тодорхойлж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөхийг зорилгоо.

Сэдвийн томъёолол

- I. Эрх зүйн модерн хандлагын хөгжил, хүрсэн үр дүн
- II. Хууль зүйн постмодерн хандлага
 - a. Постмодерн хандлагын тухай ерөнхийлвөл
 - b. Эрх зүй дэх постмодерн хандлагын нөлөө
- III. Дүгнэлт

¹ Freeman M.D.A. Lloyd's Introduction to Jurisprudence. London., 2001. p. 15



“Онгөрсөн үе бидний ирээдүйд харах цонхыг нээлээ” хэмээн Тейяр де Шардений тэмдэглэсэнчлэн орчин үеийн эрх зүйн үзэл баримтлал, философийн хөгжил нь дундад зууны үеийн схоластик эрх зүйн философитой салшгүй холбоотой. Эрх зүйн хэм хэмжээнүүд нь хоорондоо мөргөлдөөнд орж, бие биетэйгээ зөрчилдсөн тохиолдолд хууль эрх зүйн шударга ёсны *aequitas* үзлийн үүднээс сонголт хийж болно хэмээн түүнийг шударга ёсны шүүлт болгох² үзлээс энэ хандлага үүсэлтэй. Тиймээс энэ үеийн сэтгэгчдийн дунд эрх зүйн төрөлх эхэнлэг чанарыг танин мэдэхүйгээс чанад ахуйд буюу хэт бурханлаг үзэл, философиос эрэх хайгуул улам бүр хүчтэй байсан. Профессор Ж.Робертсын тэмдэглэсэнээр: “а. Бурхан байх бөгөөд, б. Хүмүүний амьдралыг төлөвлөн зохицуулж, в. Хэн бурханы төлөвлөгөөнд зааснаар амьдрах аваас сайн, г. Хэн бурханы төлөвлөснөөс гажвал буруу номтон гэсэн сонгодог жам ёсны эрх зүйн онолд тулгуурлаж байсан”³. Тиймээс хүний хууль нь дээд бурхан хийгээд байгалийн хуульд нийцэж байх ёстой гэсэн сургааль үүдэж⁴, түүнд нийцээгүй хуулийг Augustine(Августин) “*lex injusta non est lex*”⁵ буюу “шударга бус хууль нь угаас хууль биш” хэмээн зарчим болгон тунхагласан. “Хүчин төгөлдөр хууль бүр ямар нэгэн шалтгааны хууль байдаг...Шалтгааны хуулийг хүчин төгөлдөр хуулиас ялгаж, салгах нь тун төвөгтэй” хэмээн XVI зууны английн хуульч Кристофер Жерман хэлсэн⁶ нь эл үеийн эрх зүйн сэтгэлгээний тод илрэл мөн.

Харин XVIII-XIX зуунд байгалийн шинжлэх ухаанд гарсан нээлтүүд нь нийгэм хийгээд хүмүнлэгийн ухааны асуудлуудыг шинээр авч үзэхэд хүргэсэн бөгөөд энэ нь эрх зүй судлалыг ч мөн тойрсонгүй. Тухайн үед шинжлэх ухааны хүрээнд гарсан гэгээрэл нь хүнийг мистицизм буюу домог, сүсэг бишрэл, байгал хийгээд дээд ухамсарт захирагдах байдлыг түүний өөрийнх нь оюун ухаанаар чөлөөлөхийг эрмэлзэв. Ингэснээр, бидний өөрсдийн амьдралын ирээдүй гагцхүү бидний оюун ухаанаас үүдэлтэй гэх рационал үзэл улам бүр хүчтэй дэлгэрэх болжээ. Үүнд тулгуурлан орчин үеийн буюу модерн гэх нийгмийн үндэс нь гагцхүү оюун ухаанд итгэх итгэл дээр шууд

² Н.Лүндэндорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002. 38 дахь тал.

³ J.M.Roberts. History of the World. 1993. New-York: Oxford University press. p. 42

⁴ Т.Акинн мөнхийн, жам ёсны, бурхны, хүн төрөлхтний гэсэн дөрвөн төрлийн хуулийг заагласан бөгөөд эдгээр нь дээрхи дарааллаар бие биетээ захирагдах ёстой ажгуу. Thomas Aquinas. Summa Theologica. Part II. Question XCVI. 4 th article.

⁵ St Augustine. The Libero Arbitrio. I. v. II.

⁶ Жам ёсны эрх зүйн аргумент. Freeman M.D.A. Lloyd's Introduction to Jurisprudence. London., 2001



суурилж босч ирсэн.

Бурханаас юм уу, түүний хүслээр тогтоосон ямар ч дээд эрх зүй гэж байхгүй. Мөн байгалиас буюу жам ёсны ямар нэг хатуу тогтоосон зарлиг, хэм хэмжээ гэж үгүй бөгөөд түүнд дулдуйдсан ямар ч нийгмийн бүтэц, давхраа гэж байхгүй. Бүгд л оюуны хэрэглүүр, хүний өөрийнх нь бүтээл учраас хүнийг хүнээс өөр хэн ч аврахгүй. “Тиймээс хүмүүсийн нийгмийн хяналтын хэрэглүүр болох эрх зүйн тогтолцоог тэд өөрсдөө бүтээж чадах бөгөөд чадах ч ёстой” гэсэн үзэл санааг рационалистууд дэвшүүлсэн.⁷ Үүнд үндэслэж ёс суртахууны үнэт зүйлээс эрх зүйг зааглах ёстой эсэх дээр хуваагддагаас үл хамааран орчин үеийн жам ёсны эрх зүйчид хийгээд позитивистүүд бүгд байгалийн хуулиас хүн төрөлхтний хуулийг зааглан салгах шаардлагыг хүлээн зөвшөөрдөг.

Байгалийн хуулиас хүн төрөлхтний хуулийг зааглах оролдлогыг хамгийн анх английн эрх зүй судлаачид болох Ж.Остин, Ж.Бентам нар хийсэн. Тухайлбал, Ж.Остин: “Эрх зүй нь өөрт тавигдах шаардлагын дагуу бүтээгдсэн бол эрх зүй бөгөөд дээд тэнгэр хийгээд бурханд нийцэх албагүй”⁸ хэмээн тэмдэглэсэн бөгөөд цааш нь өөрийн онолыг тодотгон “хуулийг позитив хэмээн нэрлэх шалтгаан нь хүнээс эхэнлэг гэдгийг тодотгож буйн зэрэгцээ бурхны хийгээд байгалийн хуультай өөр өөр ойлголтыг хооронд нь хольж хутгахаас сэрэмжлэв” хэмээжээ. Энэ үндсэн дээр тэрээр, хууль гэдэг бол бүрэн эрхтийн захирамж” хэмээн тодорхойлсон. Харин Ж.Бентам “Эрх зүйн тогтолцооны хамгийн чухал үүрэг, зорилтын нэг бол өөрийнхөө хэм хэмжээ зарчмуудын тусламжтайгаар хүмүүсийн хоорондын аливаа нэгэн харилцааг нийгмийн ба хууль зүйн мэргэжлийн ухамсар ба практикт эрх зүйн харилцаа болгон хэвшүүлэхэд оршино.”⁹ Тиймээс аливаа хуулийг шалгах шалгуур нь дээрхтэй уялдаж практик зорилгыг хангах чадвартай байна уу гэсэн үндэслэл болохоос биш дээд хуульд харшлах тухай биш”¹⁰ хэмээн үзсэн. Мөн тэрээр “жам ёсны эрх”-ийн талаархи ямар нэг ойлголтоос үргэлж татгалзаж, цааргалж ирсэн бөгөөд түүний судалгаа эрх чөлөө, тэгш эрх, өмч хөрөнгө зэрэг ойлголтуудыг бүхэлд нь үнэ цэнэ, үнэлэмжийнхээ хүрээнд авч үздэг юм. “Эрх” гэдэг бол хууль зүйн ойлголт бөгөөд бид “эрх”, “үүрэг”-ийн тухай

⁷ Stuart Henry, Dragan Milovanovic. A Constitutive Theory of Justice. 1991

⁸ Freeman M.D.M. Lloyd's Introduction to Jurisprudence. London. 2001. p.

⁹ Law is command of Sovieregn

¹⁰ С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 60 дахь тал.

¹¹ Freeman M.D.A. Lloyd's Introduction to Jurisprudence. London., 2001. p.



ярихдаа юун түрүүн хуулиар л сэтгэдэг. Хууль л танд сонгох, сонгогдох, цалин мөнгө авах, цагдаагаар хамгаалуулах эрхийг өгдөг.¹² Харин жам ёсны эрх гэдэг бол модон хөлтэй хүүхэлдэй.¹³

Ж.Бентамын дэвшүүлсэн нэг чухал санаа бол эрх зүйг ашигт чанарын онол хэмээн нэрийдсэн утилитаризмын үүднээс тайлбарлахыг оролдсонд байдаг. Тодруулбал, ашигт чанарын зарчим нь эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийн аз жаргалын нэмэгдүүлэх эсхүл хорогдуулах байдлаас нь хамааруулж аливаа үйлдэл бүрийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх зарчмыг хэлнэ. Ашигт чанар гэдэг нь ямар нэгэн объект түүнийг хөндөж буй этгээдэд үр өгөөж, давуу тал, цэнгэл, сайн сайхан, аз жаргал бий болгох эсхүл гэм хор, өвчин шаналал, муу муухай, зовлон зүдгүүр учрахаас сэргийлэх шинж чанарыг хэлнэ¹⁴. Тиймээс ашигт чанар нь тухайн хүн амын дийлэнх хэсэгт хамаарах ёстой бөгөөд хууль нь хүний амьдралын асуудлуудын дийлэнх хэсгийг шийдвэрлэх чадвартай бол уг хуулийг даган мөрдөх ёстой ажээ.¹⁵

Тэдний үзлийг австрийн эрх зүйн онолч Х.Кельзен, английн хуульч Г.Харт¹⁶ нар үргэлжлүүлэн хөгжүүлсэн. Х.Кельзен¹⁷ эрх зүйг дээд бурханлаг үзлээс салгах явдлыг бүрэн дэмжээд зогсохгүй мөн объектив мэдлэгийн бусад салбараас зааглах оролдлого хийсэн. Аливаа нийгмийн харилцаа өөрийн зохист байдлаар зохицуулагдан өрнөж байгаа нь ид шид биш, гагцхүү эрх зүйн гайхамшигт хүч. “Эдүгээ хууль зүй нь шинжлэх ухааныхаа хувьд утгаа алдаж дуусчээ. Учир юу гэвэл хуульчид сэтгэл зүй, биологи эдийн засаг, улс төр, шашин, суртлын холимог бантан болсон тодийгүй эдгээр ухаанаас хэн их хуулснаараа гайхуулах болсон нь дээр өгүүлж буй утгын алдалт болж буй

¹² Bentham J. Anarchical Fallacies. 1987. p 73(дам ишлэл). Ч.Өнөрбаяр. Хууль зүйн позитивизм, түүний чиг хандлага. Эрх зүй сэтгүүл. №13-14. УБ., 2004. дэх тал

¹³ Моисеев. Философия права. Новосибирск. 2003

¹⁴ Ibid. p.

¹⁵ Сонголог потяивистуудын дэвшүүлсэн санааг талаархан дэмжиж америкийн реалистууд гарч ирсэн. Гэхдээ тэд эрх зүйг бурхан хийгээд хүний итгэл үнэмшлээс зааглах хандлагатай нэгддэг боловч эрх зүйг тодорхойлох хандлага дээр эрс өөр байр суурьтай байдаг. Тодруулбал, прагматизмын үзэл дээр суурилж Оливер Венделл Холмс, Ж.Франк (1889-1957), К.Ллеселли (1893-1962) нар эрх зүй амьдралаас хэт тасарсан бийдлыг арилгахыг оролдсон. Тэдний үзлээр эрх зүйн мөн чанарыг танин мэдэхийн тулд хийсвэр онолуудад анхаарал хандуула

хаас илүүтэйгээр шүүхийн практикт анхаарах нь чухал. Эрх зүй нь уг гарвалаараа тэнгэрийнх бус, газар дэлхийнх бөгөөд хэрэглэгдэхүйц шинжтэй, эрх зүй бол “тэнгэрт лэмхрэх хоосон бодол биш” бөгөөд товчоор “энэ нь шүүхийн шийдвэр юм” гэж тодорхойлсон.

¹⁶ Түүний үзлийг H.L.A. Hart. The Concept of Law. Clarendon Law Series. Second edition. Oxford University press. 1994 номноос дэлгэрүүлэн үзнэ үү.

¹⁷ Kelsen H. Pure Theory of Law. Translation from the second. 1989. номноос дэлгэрүүлж харна уу.



юм”¹⁸ хэмээн эрх зүйг мистицизм төдийгүй нийгмийн баримжаатай судлах хандлагад дайралт хийсэн. Хамгийн гол нь эрх зүйг цэвэр байлгаснаар хэн нэгний хүсэл зориг хийгээд бусад субъектив үнэлэмж шингэхийг хаах ажээ. Харин цэвэр эрх зүй бол хэм хэмжээ нь формаль тэгш байдлын зарчмаар харилцааг зохицуулж, хэн юу хийх ёстой үгүйг зааварлагч хэм хэмжээний нийлбэр цогц¹⁹ ажээ.

Английн эрх зүйн онолч Г.Харт “эрх зүй нь горим журмын цогц бөгөөд эдгээр горим журам өөрийн онцлогоос хамааран анхдагч ба хоёрдагч гэсэн үүрэгт хуваарилагдана. Анхдагч горим журам нь хүмүүсийн зан үйлийг тэдгээрийн хүсэл зоригоос үл хамааруулан дэглэж байдаг.”²⁰ Оөрөөр хэлбэл, үүрэгжүүлсэн горим журам. Хулгай хийх, улаан гэрлээр гарахыг хориглож буй нь үүний жишээ. Харин анхдагч горим журмын шаарлагын үүднээс бүрэн эрх олгодог горим журам үүддэг. Тодруулбал, нэгдүгээрт, хүн амын дунд үйлчилж буй горим журмын төөрөгдөл үүсэх магадалалтай байдаг. Хоёрдугаарт, анхдагч горим журмын хөшүүн байдал, гуравдугаарт, үр нөлөөгүй болох зэрэг нь горим журмын тухай горим журам буюу хоёрдагч горим журмыг бий болгодог. Хоёрдагч горим журам нь дээрхи шалтгаантай уялдаж хүлээн зөвшөөрөх, өөрчлөх, шийдвэр гаргах гэсэн төрлүүдтэй²¹ байдаг. Тиймээс Хартын хувьд “эрх зүй гэдэг нь анхдагч хийгээд хоёрдагч горим журмын хөг нийлүүлсэн хослол бөгөөд ямар ч эрх зүйн тогтолцооны зүрх”²² ажээ.

Тэрээр Ж.Бентамын ашигт чанарын онолын гаргалгаанд суурилж “Бараг оршин буй бүхий л эрх зүйн тогтолцоо нь хоёр нийгмийн зорилгыг хангахад чиглэгддэг буюу эхнийх нь хүмүүсийн амьдралын зайлшгүй хүрээг горим журмуудаар дэглэх. Ингэснээр амьдралын тохиолдол бүрт эрх бүхий этгээдээс тухайн үед хэрхэх тухай шийдвэр гаргуулахаар хандах шаардлагагүй болдог. Харин бүрхэг ойлголттой тулгарахад сөргөлдөх хоёр ашиг сонирхолуудын дундаас тухайн горим журмын бүрхэг хэсгийг тодотгох замаар анхныхаа зорилгыг илүү нээдэг... Харин нээлттэй эрх зүйн бүтэц нь тохиолдлоос тохиолдол бүрт хувьсаж байдаг сөргөлдөх хоёр талын ашиг сонирхолыг заримдаа баланслах эрх бүхий этгээд(шүүх)-ээр тогтоолгох явдал байдгийг

¹⁸ Х.Тэмүүжин. *Jus fraas* буюу *Ёст* үг. УБ., 2004. 24 дэх тал.

¹⁹ Kelsen H. *Pure Theory of Law*. Translation from the second. 1989.

²⁰ Hart H.L. *The Concept of Law*. Clarendon Law Series. Second edition. Oxford University press. 1994.p. 94

²¹ *Ibid*. p. 79-98

²² *Ibid*. p. 79



үгүйсгэх аргагүй. Гэсэн хэдий ч дийлэнх үед амьд эрх зүй нь эрх бүхий этгээдэд тохиолдол бүрт шинэ эрэл хайлт хийх шаарддаггүйгээр асуудлуудыг тогтоосон горим журмын дагуу шийдвэрлэх гарц болж чаддаг²³ гэж нөмлож, эрх зүйн чиг үүргийг дийлэнх асуудлыг шийдвэрлэх чадвараар хязгаарласан.

Хэдийгээр эрх зүйг нийгмийн баримжаатай судлахаас татгалздаг позитивистүүдийн үзлийг дэмждэггүй ч хэт бурханлаг үзлээс ангид судлах хандлагыг дэмжиж буйгаа профессор Л.Фуллер(Lon Fuller)²⁴, Ж.Финнис нар өөрсдийн бүтээлдээ харуулсан. Тухайбал, Л.Фуллер “эрх зүй нь уг гарвалаараа газар дэлхийнх бөгөөд хэрэглэгдэхүйц шинжтэй. Эрх зүй бол тэнгэрт замхрах хоосон бодол биш... Үнэхээр дээд эрх зүй гэж байвал миний өгүүлж буй жам ёсны эрх зүйн үзэл доод буюу хүн төрөлхтний эрх зүйд хамаарна” хэмээсэн. Цааш нь “эрх зүйн нэн чухал чиг үүрэг бол хүмүүсийн зан үйлийг өөрсдөө тэдгээр зан үйлээ хянах нийтлэг горим журамд захируулах замаар нийгмийн дэг тогтоох явдал”²⁵ бөгөөд хэрэв зээ зан үйлийг хянах хуулийн энэ чиг үүргэд нийцээгүй хууль бол хууль биш. Харин энэ чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд горим журмуудын тогтолцоо нь дараахь зарчмуудыг бүрэн тусгасан байх ёстой. Үүнд: (1) Горим журмууд нь нийтлэг нөхцлөөр илрэх ёстой; (2) Горим журмууд нь нийтэд зарлагдсан байх ёстой; (3) Горим журмууд нь үйлчлэх ирээдүйтэй байх ёстой; (4) Горим журмууд нь маш ойлгомжтой нөхцлөөр илэрхийлэгдсэн байх ёстой; (5) Горим журмууд нь бие биеэ малгайлан захирсан байх ёстой; (6) Горим журмууд нь хамрагдаж буй талуудын бүрэн эрхэд үл хамаарах зан үйлийг шаардах эрхгүй; (7) Горим журмууд нь субъект түүнд итгэл найдвараа алдтал байнга өөрчлөгдөх ёсгүй; (8) Горим журмууд нь үндсэн хэв маяг бүхий тогтолцоондоо захирагдах ёстой” гэжээ. Үүгээрээ эрх зүй нийтлэг шаардлагыг хангах ёстой гэсэн Ж.Бентамын үзлийг баримталсан.

Дээрхи сэтгэгчдийн үзлээс дүгнэвэл, эрх зүйн модерн хандлагын үнэлж барашгүй ач гавьяа нь эрх зүйг мистицизм хийгээд дээд тэнгэрлэг, бурханы хүсэл зоригтой хутгаж байсан сэтгэлгээнээс хүн төрөлхтнийг салгаад зогсохгүй хууль зүйн хандлагатайгаар судлах гарцыг нээсэнд оршино. Гэхдээ эрх зүй ба ёс суртахуун хоёрын хооронд хөшиг бий эсэх асуудал дээр дотроо

²³ Hart H.L. The Concept of Law. p. 129-135.

²⁴ Түүний онолыг “The Morality of Law”. New Heaven. Revised edition. Yale University press. 1964; “A Reply to Professors Cohen and Dworkin”. 10 Villanova Law Review 655. 1965; “Positivism and the Fidelity to Law—a Reply to Professor Hart”, 71. Harvard Law Review 630. 1958 зэрэг бүтээлүүдээс цэлгэрүүлэн үзэж болно.

²⁵ Ibid. p. 657.



позитивизм ба жам ёсны эрх зүйн онол гэсэн томоохон урсгалд хуваагддаг. Харин тэдний зүгээс эрх зүйд тавьдаг нийтлэг шаардлага бол амьдралд тохиолдох асуудлын дийлэнхийг нь хэм хэмжээ буюу горим журмад үндэслэн шийдвэрлэх чадвартай байх явдал.

II

А. XX зуун сүүлчид Франкфуртын их сургуулиас гарсан хүчтэй давалгаа нь ганцхан эрх зүй судлалын төдийгүй нийт сэтгэлгээний төвшинд хувьсгал хийв.²⁶ Тэдний үзлээр объектив бодит байдал гэж байхгүй. Бодит байдал гэдэг бол социал бүтэц бөгөөд энэ нь бидний мэндлэхээс өмнө аль хэдийн угсрагдсан байдаг. Тиймээс бидэнд жам ёсны гэх нэрийн дор хүлээн зөвшөөрөгдсөн үнэн чанартаа зохиомол ертөнц юм. Үүнийг менарратив хэмээдэг. Тухайлбал, марксизм, фрейдын психоанализ, либерализм гэсэн нэрийн дор хөгжиж буй метанарративууд биднийг нэг хэвэнд цугтан, гагцхүү нэг логикт захируулж, нийгэм даяар өөрийн хяналтыг бүрэн тогтоож чаддаг. Үүний үндсэн дээр жинхэнэ би гэж байхгүй болдог. Амьдарч буй нийгмээ төсөөлөх миний өнцөг өмнө нь байсан бөгөөд хэн нэгэн надад үүнийг өвлөсөн юм.

Түүнчлэн, мэдлэг бол хүч. Хэрэв зээ үнэхээр бодит байдал нийгмийн зохиомол ертөнц байх аваас түүнийг зохиосон, сэдсэн этгээд агуу их эрх мэдэлтэй. Учир нь тэр биднийг өөрөө ямар байдлаар ертөнцийг харахыг хүсэж байна, тийм байдлаар биднийг харахыг шаардаж байна. Тэгээд үүнийг жам ёсны хэмээн нэрийдлээр бидэнд ухуулга хийдэг. Жишээ нь, өнөөдөр эрэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь харьцангуй өндөр байгаа үед шударга ёсны бидний төсөөлөл тэгш эрхийн зарчмын үүднээс хэр үнэн зөв байж чадах вэ? Шударга ёсны нийгмийн үнэлэмж үүн дээр суурилагагүй гэж үү? Яагаад бидний төсөөлөлд эмэгтэй хүн сайн улс төрч, удирдагчийн дүрээр бус, харин гэрийн эзэгтэй, сайн ээж хэмээн буудаг юм бэ? Мөн үүнтэй адил гэрлэлт. Байгалаас бидэнд огогдсон сексийн харилцааны мөн чанар нь үр удмаа үлдээх гэснээс өөрцгүй. Харин үр удмаа үлдээнэ гэдэг нь эдгээр харилцааны жам ёсны зорилго юм. Үүнтэй уялдаж, энэ зорилгод харш сексийн үйлдлүүд нь мэдээж жам ёсны хуулийн эсрэг болж таарна. Тиймээс мастурбаши хийгээд гомосексуализм, жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэлтэй үйлдэж буй секс зэрэг нь шийтгэгдэх болж, энэ нь хоёр эрэгтэй, хоёр эмэгтэй

²⁶ Теодор Адорно (1903-1969), Макс Хоркхаймер (1895-1973), Герберт Маркузе (1898-1979), Эрих Фромм (1900-1980), Вальтер Беньямин (1892-1940), Юрген Хабермас нар үлэмж хувь нэмэр оруулжээ.



хүнийг хооронд гэрлэхийг хязгаарлах үндэс мөн үү?

Дээрхи олон шалтгааны улмаас тэд сэтгэлгээний зохиомол бүтцийг эвдэж, деконструкци хийхийг эрмэлздэг. Деконструкци – зохиогчийн хүсэл зоригоос үл хамааран текстэнд дадал туршлагаас ангид сэтгэлгээний хэв маягийг тодорхойлох үйл явц, арга хэрэгсэл мөн. Энэ үндсэн дээр постмодерн хэлбэр нь бидний илүү гүнзгий бодож олсон ертөнц рүү шигдэж, илүү уран сайхны, нийгмийг тайзчилсан, театрчилсан хэв маяг төрхийг нэгэнтээ олох болсонд²⁷ Ж.Бодрийяр синволик ертөнц дэх симулякр хэмээн томьёолсон биз ээ.

Б. Тэгэхлээр, дээрхтэй уялдаж постмодерн хандлага эрх зүйтэй ямар хамааралтай гэсэн асуулт тавигдана. Сэтгэлгээний өөрчлөлт өөрөө нийгмийн өөрчлөлтийг дагуулдаг гэсэн ерөнхий зүй тогтлын өнцгөөс ажиглавал эрх зүй нь нийгмийн хяналтын хэрэглүүр болохын хувьд шууд хамааралтай гэсэн үг. Хүний оюуны хөгжил нь амьдралыг цоо шинэ хуудас, хэмнэлээр дүүргэх болж, түүгээр ч үл барам эрх зүйг энэ харилцааг хамгаалах чадвартай, түүнд хүрч үйлчлэх илүү үр нөлөөтэй байхыг шаардах болжээ. Үүнд тулгуурлан постмодернистүүд уламжлалт эрх зүйн онолд шүүмжлэлтэй хандах болсон.

Уламжлалт сэтгэлгээний хэв маяг, түүнд тулгуурласан эрх зүйн онолд няцалт хийхийг зорьсон анхны оролдлогын нэг нь Английн засгийн газарт хандсан Вольфендены комиссын илтгэл байлаа. Тухайн үед буюу 1950-иад оны үед гомосексуализм, бие үнэлэх, аборт хийлгэх, порно үзүүлбэр зэрэг нь гэмт хэрэгт тооцогдож байсанд шүүмжлэлтэй хандан: “Эрүүгийн эрх зүйн бодлого нь нийгмийн дэг журмыг хангаж, ёс суртахуунгүй муу зүйлээс иргэнийг...ялангуяа, сул дорой, залуу, туршлага муутай хүмүүст халдахаас хамгаалах бөгөөд...үүнээс үүдэж, зан үйлийн тодорхой журам сахиулах үүднээс хувь хүний амьдрал руу хэт халдах нь эрүүгийн эрх зүйн бодлого биш билээ...Хулийн ёс суртахууны хүрээ байх ёстой бөгөөд шууд хэлэхэд хууль оролцох ёсгүй хувийн орчин гэж байдаг хэмээн биз үзэж байна”²⁸ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Вольфендены комиссын илтгэл нь Ж.С.Миллийн “On Liberty” эссенд дурдсан: “...Соёл иргэншсэн нийтлэгийн аливаа гишүүнийг зүй ёсоор дарамталж, түүний хүслийн эсрэг эрх мэдэлтнээс үйлдэж болох цор ганц шалтгаан бол бусдад хор хөнөөл учруулахыг нь зогсоох явдал. Бие бялдар,

²⁷ Монссен С.В. Философия права. Новосибирск. 2003. с.188

²⁸ Wolfenden Committee. Report of the Committee on Homosexual Offence and Prostitution. London. 1957



ёс суртахууны баялаг нь түүнийг цагаатгах үндэс болж чадахгүй”²⁹ гэсэн үзэл санаад шууд суурилж байсан нь тухайн үедээ нэлээд шуугиан тарьсан боловч хүлээн зөвшөөрөгдөөгүй. Харин арваад жилийн дараа 1967 онд насанд хүрсэн хоёр эрэгтэйн сайн дурын үндсэн дээр гэрлэхийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэхээ больсон нь уг ажлын томоохон үр дүн байв.

Эрх зүй нь нийтлэг ашиг сонирхолыг хамгаалах ёстой боловч түүгээр бамбай хийн хувь хүний эрх чөлөө, ашиг сонирхолын ертөнцөд халдах эрхгүй бөгөөд энэ нь түүнд нэвтрэх виз биш. Түүгээр ч үл барам эрх зүй нь зүй ёсны хувь ашиг сонирхолыг дэмжих хэрэгсэл мөн. Тиймээс эрх зүйг хэм хэмжээ, горим журам хэмээн үзэх уламжлалт хандлага нь “тэг эсхүл, үгүй”(all-or-nothing)³⁰ срөнхий туйлд баригддаг учраас түүний дунд орших асар олон хувилбарт сэтгэх боломжийг хааж³¹, дээрхи шаардлагыг биелүүлэхэд хүчин мөхөсддөг. Эрх зүйн энэ болхи чанар нь эрх зүйг хатуу тогтоосон позитив гэхээсээ мөн харьцангуй уян хатан байхыг үгүйлээд зогсохгүй энэ чадвараар нөлөөтэй эрх зүйн зарчмуудын үүргийг улам бүр өсгөх болжээ. Үүнийг онолын түвшинд боловсруулсан сэтгэгч бол Р.Дворкин(R.Dworkin)³² юм.

Тэрээр юун түрүүнд горим журам, эрх зүйн зарчим хоёрыг зааглах оролдлогыг хийв. Горим журмууд нь бие биентэй зөрчилдвөл “тэг, эсхүл үгүй” гэсэн зарчмын дагуу аль нэг нь хүчингүй болох буюу эсхүл зөрчилдсөн тохиолдолд аль нэг нь илүү хүчин чадалтай байхаар тунхаглагдана³³. Жишээ нь, “хэнийг ч түүний оршин суугаа газартай нь холбогдуулан ажилд авахаас татгалзаж болохгүй” гэсэн горим журамтай “гал түймэртэй тэмцэх албаны ажилтан нь ажиллаж буй хотын оршин суугч байх ёстой” гэсэн журам мөргөлдсөн тохиолдолд аль нэг нь хүчингүй болох буюу өөрчлөгдөх, эсхүл нэг нь давуу эрхтэй хэмээн тунхаглагдана. “Харин зарчмууд нь “тэг, эсхүл үгүй” гэсэн үндэслэгээнд баригдахгүй, тодорхой хэрэгт бие биеэ үгүйсгэсэн байдлаар зэрэгцэн орших бүрэн боломжтой бөгөөд зарим нь маш цөөхөн

²⁹ Mill J.S. On Liberty. p. 135. лам ишлэв. Вольф Ж. Улс төрийн философиин удиртгал. УБ., 2002. 137 дахь тал.

³⁰ Dworkin R. Is Law a System of Rules? Harvard Law Review, p. 45.

³¹ “Ба, бөгөөд, энэ тохиолдолд, магадгүй, эсхүл” гэсэн асар олон хувилбаруудад хөрвөн сэтгэж чадлагаараа хүний оюун ухаан гайхамшигтай бөгөөд энэ чанараар дээрхи срөнхий нөхцөлд л ажиллах чадвартай зохимол оюун болох компьютерээс эрс ялгарна.

³² Түүний үзлийг Dworkin R. Law's Empire. Cambridge: Harvard University Press. 1986; Dworkin R. Taking Rights Seriously. Cambridge: Harvard University Press. 1977; Dworkin R. Is Law a System of Rules? Harvard Law Review. зэрэг бүтээлүүдээс дэлгэрүүлэн сонирхож болно.

³³ Ibid. p. 45.



хэрэгт л шийдвэрлэх гарц болох боломжтойг үгүйсгэхгүй. Гагцхүү, маргаантай байж болох асуудал бол тухайн хэрэгт аль зарчим давуу эрхтэй вээ гэдэгт л орших бөгөөд харин ялагдсан зарчим хэзээ ч жийгдэхгүйгээр дараагийн тулаанд орох бэлэн байдаг³⁴ ажээ.

Позитив онол нь хийсвэр горим журмуудад хэт их анхаарал хандуулснаас болж амьдрал дээр гарч буй хэрэг маргааныг шүүхээс шийдвэрлэх зарим тохиолдолд хүчин мөхөсддөг. Амьдралын тодорхой асуудлуудад хүрч үйлчилж чадахгүй горим журам бол “өвчтэй” журам бөгөөд тиймээс шүүх бэрхшээлтэй хэрэг маргааныг шийдвэрлэхдээ нийгмийн зарим үнэт зүйлсийн стандартыг баримтлахаас зугтах шаардлагагүй³⁵ гэжээ. Үүнийг нотлохын тулд дараахь жишээ авдаг³⁶.

Риггс Пальмерын эсрэг (*Riggs v. Palmer*) хэрэг. 16 настай Элмер Пальмер өвөө нь өөрийнхөө хөрөнгийг өөрт нь өв залгамжлахгүй, өөр этгээдэд (хөгшин эр гэрлэхээр зэхэж байж) шилжүүлж магадгүй гэдгээс айн өвөөгөө алжээ. Элмер бусдыг алсан хэрэгтээ хорих ял сонсож, эдэлж дуусаад өв хөрөнгөө авхаар шүүхэд нэхэмжилжээ.³⁷

Хеннигсен Блумфилд моторсын эсрэг (*Henningsen v. Bloomfield Motors Inc.*) хэрэг. Хеннигсен гэгч машин худалдан авчээ. Ингэхдээ машинд ямар нэгэн гэмтэл илэрсэн тохиолдолд худалдагч бүх гэмтлийг арилгах үүрэг хүлээх гэрээ байгуулжээ. Гэтэл машинд гэмтэл илрээд зогссонгүй үүний үр дүнд Хеннигсен аварт орж, яс нь хугарсан байна. Хохирогч машин үйлдвэрлэгчээс машины гэмтлийг арилгаад зогсохгүй мөн авараас үүдэж гарсан бүр зардлыг, ялангуяа эмчилгээний зардлыг даахыг шаардсан (гэрээгээр үүнийг тохироогүй).³⁸

Эдгээр тохиолдолд шүүх горим журамд захирагдвал зүй ёсны шаардлагыг хангах боломжгүй. Тиймээс шүүгчид бодитой үйлчилж буй горим журам нь шударга үйлчилж чадахгүй үед хянаж, зөв гольдролд нь оруулах арга байж болохыг илрүүлсэн³⁹ хэмээн тэмдэглэсэн байдаг.

³⁴ Мюнстер В.С. Философия права. Новосибирск. 2003. с.63.

³⁵ Dworkin R. *Taking Rights Seriously*. Cambridge: Harvard University Press. 1977.p.40.

³⁶ Энэ талаар дэлгэрүүлэн Dworkin R. *Is Law a System of Rules?* Harvard Law Review гэсэн өгүүллээс үншиж болно.

³⁷ 115. N.Y. 506. 22. N.E. 188 (1989). (Дам вилэн.) Dworkin R. *Is Law a System of Rules?* Harvard Law Review.p. 44

³⁸ Ibid. at 511. 22. N.E. at 190. (Дам вилэн.) Dworkin R. *Is Law a System of Rules?* Harvard Law Review.p. 44

³⁹ Dworkin R. *Taking Rights Seriously*. Cambridge: Harvard University Press. 1977.p. 29.



“Шүүгч нарын үүрэг хэлэлцэж буй хэрэг нь ямар ч хүнд хэцүү байлаа гэсэн тухайн тохиолдолд хамгийн зөв гэсэн хариултыг олоход л оршдог” хэмээсэн ба Дворкиныхаар зөв хариу үргэлж байдаг. Харин бид түүнийг тэр олж чаддаггүй бөгөөд түүнийг хууль тогтоох ба шүүхийн горим журам, шүүхийн шийдвэрийн цогц хийгээд эрх зүйн бичигдээгүй зарчмуудад агуулагдсан эх сурвалжуудаас хайх ёстой гэнэ.

“Шүүгч нь эдгээр материалуудаар зэвсэглэсний үндсэн дээр тохирсон эрх зүйн онолыг боловсруулж, шийдвэрийг гаргана. Гэхдээ энэ шийдвэр(зарчим хэмээн өөрөө томъёолсон) нь удаах хоёр нөхцлийг хангасан байх шаардлагатай. Үүнд: (1) Зарчмууд нь хуулийн материал(баримт-М.Б.)-уудад сайтар тулсан байх ёстой; (2) Зарчмууд нь шударга ёс, эрх чөлөө, тэгш эрх, шүүхийн зөв процесс(due process) хийгээд хувь этгээдийн эрх чөлөөны үнэт зүйлсүүдэд суурилсан улс төр, ёс суртахууны угга агуулгыг эрх зүйгээр дамжуулан хамгийн боломжит байдлаар гэрэлтүүлэх (in its best possible light) ёстой” ажээ.

Уг онолоо Дворкин “Нэгдмэл эрх зүй”(М.Б. - Law as Integrity)-н онол хэмээн нэрийдсэн бөгөөд өөрийнхөө онолыг уран зохиолын номыг тайлбарлахтай адилтгаж үзсэн. Хэрэв номыг хэсэг бүлэг зохиолчид хамтран бичих болж хэмээн төсөөлбөл, оролцож буй зохиолч бүр өөрийнх нь бичих хэсэг хүртэл бичсэн тэр хэсэг дээр үндэслэж, цааш нь тайлбарлах ёстой. Шинэ бүлэг бүр өмнө нь бичигдсэн зүйлстэй нэгд нэгэнгүй таарч байх нь чухал. Мэдээж эхний бүлэгт гол дүр нь Долгор байснаа дараагийн бүлэгт Бурмаа болвол уншигч авхай нарт хачирхалтай санагдах болно. Тиймээс зохиогч бүрт өмнө буй баримт дээр үйл явдлыг цааш нь хэрхэн сонирхолтой байдлаар өрнүүлэх вэ гэдэг үүрэг л оногдоно. Яг үүн лугаа шүүгч нар байгаа хуулийн баримт дээр суурилж, улс төр, ёс суртахууны үүднээс хамгийн зөв тайлбар хийхийг эрмэлзэх ёстой. Үүний “эрхэм зорилт бол нэгдмэл эрх зүйн онолын агуулгад үндэслэж хүнд хэцүү хэргийг оновчтой байдлаар шийдвэрлэх явдал”⁴⁰ гэжээ.

Түүний онол ёсоор хамгийн зөв хуулийн зарчмууд бол хуулийг ёс суртахууны хүрээнд хамгийн сайн байлгаж чадах тэр зарчмууд мөн бөгөөд үүнтэй холбогдуулан шүүхийн шийдвэр нь горим журмуудыг хэрэглэх бэрхшээлтэй үед хамгийн гүн гүнзгий үндсэн хуулийн горим журмуудаас

⁴⁰ Dworkin R. Law & Empire. Cambridge: Harvard University Press. 1986, p. 229.



эхлээд ердийн гэрээний журам хүртэл бүхий л эх сурвалжид үндэслэн улс төр, ёс суртахууны өнцгөөс хамгийн зөв зарчмуудыг нээн илрүүлэх ёстой байна.

Үнэхээр, либерал ардчилсан эрх зүй хүн бүрт сэтгэх эрх чөлөөг баталгаажуулсан нь оюуны хөгжлийн хувьд илүү боломжийг нээгээд зогсохгүй мөн түүний үр дүнг эрх зүйгээр хамгаалах зүй ёсны шаардлагыг хууль зүйн шинжлэх ухаанд асуудал болгон тавьж байна.

III

Тэгэхлээр, модернистууд эрх зүй судлалыг мистицизм хийгээд дээд бурханлаг төрхөөс ангижруулж, цэвэр оюун ухаанаас үүдэлтэй шинж дээр санал нэгддэг боловч эрх зүй ба ёс суртахуун хоёрын хооронд хөшиг бий эсэх асуудал дээр санал зөрдөг. Харин тэдний зүгээс эрх зүйд тавьдаг нийтлэг шаардлага бол хүний амьдралын дийлэнх асуудлыг шийдвэрлэх чадвартай байх ёстой. Энэ нь ерөнхий нөхцөл болох “тэг, эсхүл үгүй” гэсэн логикт үндэслэж байсан.

Харин эрх зүйн постмодерн хандлага нь эрх зүйг амьдралын тодорхой тохиолдол бүрт хүрч үйлчлэх ёстой шаардлагын үүднээс ерөнхий нөхцөл болсон хоёр туйлт сэтгэлгээнээс тэдгээрийн дунд байх олон хувилбарт хөрвөх илүү ухаалаг хийгээд уян хатан байх чанарыг дэвшүүлсэн.

Дээрхи бүгдээс дүгнэн үзвэл эрх зүйн орчин үеийн хөгжил нь эрх зүйг тодорхой байх ёстойн үүднээс нийтлэг нөхцөлд захирагдах ёстой хэмээх хандлагаас эрх зүй нь нийгмийн харилцаанд хүрч үйлчлэх шаардлагын улмаас илүү уян байх ёстой гэсэн хандлагад тэмүүлж байна.



МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДАХЬ “ЗАСАГ” ХЭМЭЭХ ҮГИЙН ТУХАЙД

Хууль зүйн ухааны магистр Ч.Өнөрбаяр

Монголчуудын оюун соёлын язгуур их өвийг хадгалж үлдсэн XIII зууны үеийн эрх зүйн үзэл, сэтгэлгээний гол эх сурвалж Монголын нууц товчоо хэмээх судар бичиг нь төгөлдөржсөн үнэний тухай, шударга ёс, тэнгэрлэг ёс суртахуун, түүнд нийцсэн ёс заншил, хэв ёсыг бий болгох оюун санааны эх үндсийг бий болгосон гэж үзэж болно. Энэ үндэс суурин дээр монголчуудын хууль цаазын үзэл, сэтгэлгээ бүрэлдэн хөгжсөн болой.

Би бээр эл өгүүлэлдээ энэ бүгдийг судалж, шинжилж өөрийн дүгнэлт, таамнал дэвшүүлэх гэсэнгүй. Харин судлаачдын анхаарлыг өнөө хэр татсаар буй Монголын нууц товчоон дахь “засаг” гэх үгийн хууль зүйн утга агуулга, мөн чанарыг тайлахыг оролдов. Энд засаг хэмээх үгийн хууль зүйн утга, агуулгын тайлалыг мөшгөхийн урьд түүнээс өмнө монголчуудын төр ёс, эрх зүйн сэтгэлгээнд хэрэглэгдэж байсан байх магадтай цааз хэмээх үгийн тухайд хэдэн зүйл өгүүлэх ану.

Монголын нууц товчоон дахь цааз¹ гэсэн үг нь мөн чанар, агуулгын хувьдаа хүмүүний зарим нэг зан үйлийг хааж, хориглосон утгыг илүүтэй илэрхийлж байсан нь анзаарагддаг. Ерөөс өрнө, дорнын ард түмний сэтгэлгээн дэх аливаа хуулийн үндсэн концепци нь ямар нэгэн субъектийн зан үйлийг хориглосон шинжтэй байдаг. Гагцхүү тэрхүү хуулиуд нь тогтсон ёс заншил, уламжлалыг хамгаалахад чиглэж байна уу? эсхүл ямар нэг хувь этгээдийн хүсэл зориг, эрхийг хамгаалж байна уу? гэдгээс үүдэн эрхийн соёлыг өрнийн буюу эрхээр дулдуйдаж үүргийг тодорхойлдог бардам (schalcz) соёл, дорнын буюу үүргийг дагалдуулж эрхийг тодорхойлдог бүрэг (scham) соёл хэмээн хуваадаг болсон байх. Эл үеийн монголчуудын эрхийн сэтгэлгээ

¹ Цааз гэдгийг Я.Цэцэгийн Монгол хэлний тэнц тайлбар тольд мөрдөн дагуулахаар зааж тогтоосон дүрэм журам гэж тайлбарлажээ.



нь Дорнын иргэншил соёлын хүрээнд багтдаг. Иймд Монголын нууц товчоонд өгүүлэх “цааз” нь нэг талаас тогтсон хэв ёс, заншлийг хамгаалж нөгөө талаас хүмүүсийн зан төлөв, оюун ухааны үйдлийг хянагч стандарт, оорсдийн үйл ажиллагаанд мөрдлөгө болгох горим журам болж байв.

Энэ тухай Монголын нууц товчооны 153-р зүйлд: Чингис хаан цааз өгүүллүүн: “Дайсныг даралцахад олзонд бүү хоргод. Даран дуусгаваас тэр олз биднийх болно. Бид хуваалдана. Дайсан хүмүүнд няцаагдваас түрүүчийн довтолсон (газартаа) эс эргэсэн хүнийг алтугай хэмээн *засаглалдав*”² хэмээсэн бол 197-р зүйлд: Чингис хаан Наяг “Яахан саатуулав чи?” хэмээн маш хилэгнэж “Хатуу шаргаан асууж цааз болгоё”³ хэмээн байцаан бүхүйд...” гэснээс тодорхой байна. Үүний хажуугаар монголчуудын сэтгэлгээнд өдгөө ч хэрэглэгдсээр буй “цааз” гэх үгээс үндэс язгууртай “цаазат” хэмээх нэршил нь цааз бүхий (хуулиар хамгаалагдсан), цаазтай (хуульчлагдсан) гэсэн утга агуулгыг илэрхийлж, түүнээс улбаалан “дархан цаазат ан”, “дархан цаазат уул” гэх хууль зүйн ойлголтууд бий болсон байхыг үгүйсгэх аргагүй ээ.

Энд нэг үг миний сонирхлыг ихэд татсан бөгөөд Монголын нууц товчооны 153-р зүйлийн дээрхи текстэд *засаглал* гэсэн үг орсон байна. Энэхүү үгийг герменевтик онол, арга зүйн үүднээс авч үзвэл, засаглал гэх нэр томъёо улсын хэргийг засаж залруулах ёс, тогтоосон дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд шийтгэх ёсыг багтааж, улмаар хууль зүйн хувьд дээд хүчин чадалтай цаазыг хэлэлцэж, шийдвэрлэх процессыг илэрхийлсэн ойлголт болох нь анзаарагддаг. Тодруулбал, Монголын нууц товчооны 153-р зүйлд: “Цагаан Татаар, Алчи Татаар, Тутауг Татаар, Алухай Татаар эрхт хүмүүсийг дарахад *засаглан* хэлэлцсэн үгэнд Алтан, Хучир, Даридай гурав үгэндээ үл хүрэн олзонд шуначахуй. Үгэндээ эс хүрэв хэмээн Зэбэ, Хубилай хоёрыг илгээж олзлон авсан адуу юу хэ авсан бүхнийг хураалгав”⁴ хэмээжээ.

Тэгэхлээр, Монголын нууц товчоонд өгүүлэх “цааз” хэмээх нэршил нь бүх нийтээр дагаж, мөрдөх хуулийн агуулгыг илүүтэй илэрхийлж “засаглал” гэх үг нь түүнийг хэлэлцэх процессын ойлголт байжээ хэмээн үзэж болохоор байна. Үүний зэрэгцээ цааз нь цэрэг дайны үед даган баримтлах горим

² Монголын нууц товчоо. Д.Цэрэнсодном. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. УБ., 2000. 87 дахь тал.

³ Мөн тэнд. 123 дахь тал

⁴ Мөн тэнд.



журмыг илэрхийлж байсан нь анзаарагддаг. Энэ ч бас тодорхой учир шалтгаантай. Тодруулбал, Хүннүгээс эхлэн Их монгол улсыг хүртэлх монголчуудын төр ёс, эрх зүйн үзэл санаа, түүнд дулдуйдсан иргэншил соёлыг дэглэм сайтай цэргийн зохион байгуулалт, хатуу дэг ёс, аравтын системээс нь ангид төсөөлөх аргагүй юм. Тухайлбал, Таян хааны удаах их мэдлийн ноён Хорисубэчи өгүүллрүүн: “Хайран Хөгсэү Сабраг өглөхөөр юунд бидний цэргийн цааз сулрах болов”⁵ хэмээсэн бол Чингис хаан Сүбээдэйг Тогтоагийн Худу, Хал, Чулуун тэргүүтэн хөвүүдийг нь нэхүүлэн зарлиг болгохдоо: “Хазаар үл нөмөргөн амгайвчилж явтугай. Тийн журамлаж явбаас цэргийн хүмүүн уулгалан хэрхэн чадна. Ийн цаазлах бөгөөд цааз давагсадыг барьж балбатугай”⁶ гэжээ. Мөн түүнчлэн цаазыг хэлэлцэн тогтоож, нийтээр даган мөрдүүлэх үйл хэргийг эгэл жирийн хүмүүс бус эзэн хаан, түүний ойрын төрлөөс бүрдсэн алтан ургийнхан, сэцэд, сайд эрхэлж байсан нь ажиглагддаг. Энэ тухай Монголын нууц товчоонд:

Халиар мангираар тэжээсэн хөвүүд

Хаад болоход хүрэв.

Зарчимтай Үжин эхийн

Заргасаар тэжээсэн хөвүүд

Засагтан сэцэд болов.

Гоо Үжиний

Гогод мангираар тэжээсэн

Хорчгор хүүхдүүд

Хуультан сайцуул болов”⁷ хэмээжээ. Тиймээс энд өгүүлэх “*Засагтан сэцэд*” гэх холбоо үгс төр улсын хэргийг эрхлэх бүрэн эрхт субъектүүд⁸ тэдгээрийн эрх хэмжээг агуулсан ойлголт болох нь харагдаж байна. Энэ тухай Монголын нууц товчоонд тэмдэглэснээр Чингис хаан өөрийн өргөмөл дүү Шигихутугт соёрхохдоо:

“Гүр улсын

Хулгайг гэсгээж

Худлыг мохоож

⁵ Монголын нууц товчоо. Д.Цэрэнсолном. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. УБ., 2000. 118 дахь тал.

⁶ Мөн тэнд. 127 дахь тал.

⁷ Мөн тэнд. 45 дахь тал.

⁸ Алтан ургийнхан болон хааны ойр төрлийн сайд, түшмэл



Үхүүлэх ёстойг

Үхүүл

Алуулах ёстойг

Алуул хэмээн гүр улсын дээд заргачаар (шүүгч) тушаав” хэмээжээ. Мөн дээрхи санаа Чингис хааны айлтгасан “Цааз хэмээгч эзнээс үүсэн түшмэлээр залармой” гэх сургаалиар тайлбарлагдах ажгуу. Хожим Манж-Чин улсын үед хошуу захирсан хүнийг “засаг” гэдэг¹⁰ болсон нь дээрхи засагтан гэдгээс улбаатай байж ч болох юм. Харин “Хуультан сайцуул” хэмээх ойлголтын тухайд судлаачид янз бүрээр тайлбарласан байна. Тухайлбал, Алтан-Очир (1942, 23) “Хуягт сайд”, Ц.Дамдинсүрэн (1976, 37) “Хутагтан сайд”, Дугаржав (1984, 25) “Хурц сайд” Мансаан (1985, 46) “Эзэн сайд” гэх зэргээр хөрвүүлсэн байна. Харин Бөхшиг (1941, 31) “хуульт сайд”, Д.Цэрэнсодном “хуультан сайцуул” гэж буулгасан нь нэлээд үндэслэгээтэй юм. Учир нь МНТ-ны хятад галигт **хойир(л)а`ут** гэснийг нягталвал, монгол хэлэнд р-л авиа сэлгэхийн хамт, хятад хэлэнд монгол хэлний р-л авиаг хольж хутгадаг эл үг нь угтаа “хуульт” байх бүрэн үндэстэй юм. Нөгөө талаас “хуультан” гэх үгтэй эн зэрэгцүүлсэн мөрөнд бичигдсэн “засагтан” гэдгийг хятад галигт “хууль ёстой” гэж буулгажээ.

Чингис хаан 1206 онд Монголын нэгдсэн тулгар төр байгуулсан үеэс эхлэн “цааз” хэмээх ойлголт улс иргэнийг засах хуулийн хэмжээнд хэрэглэгдэхээ больж, түүний оронд “засаг” гэх нэршил монголчуудын хууль цаазын сэтгэлгээнд орж ирсэн бололтой. Харин цааз нь зөвхөн цэрэг, дайны үед дагаж мөрдөх горим журмыг илэрхийлэх угтаа хадгалж үлдэх болсон байна. Энэ тухай академич Ш.Бира “Чингис ба түүний дараахь хаадын үед олон хууль гарч түүнийгээ засаг хэмээн тусгайлан нэрлэж байсан”¹¹ гэжээ.

Эндээс засаг хэмээх нэр томъёо монголчуудын хууль цаазын сэтгэлгээнд хэрхэн хаанаас орж ирэв? үнэхээр цааз гэх үгтэй адил утгатай ойлголт байв уу? гэдэгт судлаачдын санал, дүгнэлт хараахан нэг мөр болоогүй байна. Бидний мөшгөж буй Засаг хэмээх үг нь одоогийн дуудлагаар сонгодог монгол хэлний өмнөх үед *jasay*(жаса) гэж байсан бөгөөд тэр нь “жаса” буюу засах хэмээсэн үгийн язгуурт “г” дагаварыг залгаж “жасаг”(засаг) хэмээх нэр үгийг бүтээжээ.

¹⁰ В.Инжиши. Хөх судар. 1179-1180 дахь тал.

¹¹ Монголын түүхийн бага нэвтэрхий толь. I. УБ. 1998. 206

¹² Ш.Бира. Монголын түүх, соёл. түүх бичлэгийн судалгаа. 256 дахь тал.



Эртний үндсэн утга нь одоогийн хууль цааз хэмээсэнтэй учир утга адилхан байсан хэмээн үзэж болно.¹² Тодруулбал, 1978 онд Москвад гурав дахь удаагаа хэвлэгдсэн “Большая советская энциклопедия”-ийн 561-р талд “Яса Чингис хана(яса-тюрк. Форма монг. Джасак букв.-закон)...” гэж бичсэн буй. Энд анхаарваас зохих зүйл бол яса буюу ясак гэдэг нь түрэг үг. Түүний монгол хэлбэр нь джасак/засаг/үгчилсэн утга закон/хууль/ гэж тайлбарласан бол Оросын эрдэмтэн Даль толь бичигтээ ясак гэдэг үгийг эртний татар үг гэж хаалтанд тайлбарлажээ. Эл үед татар гэж монголчуудыг нийтэд нь нэрлэж байсан юм.

Монгол хэлний “засах” гэдэг үгтэй язгуур нэг “засаг”, “засуул” гэдэг үг орос хэлэнд дундад зууны үед оржээ.¹³ Үүний зэрэгцээ монгол хэл үүсэл гарвалын хувьд алтай язгуурын хэлний айд багтдаг. Монгол хэлтэй нэгэн адил алтай язгуурын хэлний айд багтах эртний түрэг хэлэнд засаг гэдгийг Йасак(Ясак) гэдэг. Бидний тодруулж буй Засаг хэмээх үгийн эртний утга нь хууль цааз, горим журам, хэв ёс байсны бас нэг нотолгоо бол эртний түрэг хэлний толь бичигт Йасак гэдэг нь: 1/хориглох 2/тогтоол, хууль цаазын бичиг, журам 3/торгууль, ял шийтгэл 4/алба, барьцаа 5/цэрэг дайны журам гэсэн утгатай байжээ. Мөн түүнчлэн XVIII зууны эхэн үед зохиосон “Хорин нэгтийн тайлбар тольд: “Мууг сайн болгон халах, тэнгэрийн доорхи хэргийг шийтгэх, бичгийн үгийг зохистой сайн болгох, төвийг үзэн, тушаа захиран тэгш нийгэм болгохыг засна хэмээн” тайлбарласан буй.

Энэхүү жаса буюу засах гэх үгээс язгууртай *засаглал* нь урьд өмнө цааз хэлэлцэх горим журмыг илэрхийлж байсныг дээр дурдсан билээ. Тэгэхлээр, монголын төр ёсны түүхэн дэх анхны бичмэл хуульд тооцогдох “Их засаг”, зарим судлаачдын ташаарснаар “Их ёс”-ын монголчуудын язгуур сэтгэлгээн дэх жинхэнэ нэршил нь “Ихийг засах бичиг” байх үндэстэй юм. Эдүгээ ч монгол хэлний сан хөмрөгт “засаг” хэмээх үг ямар нэг юмыг засч сайжруулах буюу мөрдөн журамлах¹⁴ хэмээх утгыг илэрхийлэхийн хамтаар өнөөгийн баруун Монголын дөрвөд, торгууд, захчин, өөлд, урианхай, баяд, хотонд Яасах(йасах)¹⁵ гэсэн үгэнд дээрхийн адил ямар нэг юмыг засах, сайжруулах

¹²Мөн тэнд.

¹³Ш.Чоймаа. Монгол хэлшинжлэл. 287 дахь тал.

¹⁴Я.Цэлэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1963.269 дэх тал.

¹⁵“Ж.Цолоо”БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг”. УБ.1988. 505 дахь тал.



гэх утга хадгалагдсаар байна.

Бидний үзлээр Чингис хаан Дорно-Орнийн уулзвар дээр орших олон нүүдэлчин овог, аймгуудыг нэг тэнгэрийн дор нэгтгэснээр өмнө мөрдөгдөж байсан олон арван зарлиг, цааз шинэ улс иргэнийг засахад хангалттай бус болж, үүнээс үүдэн тэдгээр эрээвэр, хураавар хэм хэмжээнүүд (цааз, зарлигууд)-ийг нэгтгэж системчлэх болсон байна. Үүнийг XIII зууны Ираны түүхч Жувейни судалгаа нотолдог. Тэрбээр бичихдээ: “Оөрийн бодсон санасан ёсоор тэр нь (Чингис хаан) хэрэг бүрд хууль дүрэм, юм бүхэнд журам дүрэм тогтоохын хамтад гэм бүрд зохих ял шийтгэл оноожээ. Татар хүмүүс (монголчууд) өөрийн гэх бичиг үсэггүй байсан учир, Чингис хаан монгол хүүхдийг уйгар бичигт сургах хийгээд эдгээр засаг ба зарлиг дүрмийг хуйлмал цаасан дээр бичиж тэмдэглэхийг зарлиг болгожээ.¹⁶ Мөн Пол Чений өгүүснээр Юан улсын сударт буюу “Юан-ши”-д: “Та ча-са (Их жаса) бол Чингис хааны хуулийн эмхтгэл (хятадаар та-фа-лин) хэмээн алдаршсан бөгөөд түүнийг Тай-цзун(Огэдэй хаан) Чингис хааны залгамжлагчаар өргөмжлөгдсөн 1229 онд тунхаглан гаргажээ.¹⁷ Ийнхүү олон арван цааз, зарлиг, хэв ёсыг нэгтгэсэн ухагдахуунаа “Их засаг” хэмээн нэршүүлэн хэрэглэх болсон байх.

Гэсэн хэдий ч “Их засаг”-ийг орчин үеийн төрөлжүүлэн нэгтгэсэн хууль (оросоор Кодекс, англиар Code) байсан гэж үзэж болохгүй. Тэгэхлээр, монголчуудын хууль цаазын сэтгэлгээн дэх “засаг”, “цааз” хэмээх үгс нь өнөөгийн бидний ойлгодог хууль(эрх зүй) гэдгийн утга агуулгыг илэрхийлж байсан гэж үзэж болохоор байна. Тийм ч учраас монголчуудын язгуур сэтгэлгээнд “засаг, цааз” гэх үгс сэлгэн хэрэглэгдэх, “цааз нь засаг” гэх үгтэй ханьсаж ойлгогдох болсон биз. Үүний нотолгоо бол “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир”-т:

“Бор дарсны зориг буюу

Богд эзний маань засаг үгүй

Хар архины дур буюу

Хаан эзний минь цааз үгүй буюу” гэсэн бол XIII зууны, Чингисийн билиг сургаалиас эх сурвалжтай “Оюун түлхүүр” хэмээх зохиолд:

¹⁶Ati-Malik Juvaini. The History of the World-Conqueror. Translated by J.A. Boyle. Manchester University Press. 1958. 6om. 1. p 25

¹⁷Paul Heng-chao Chen. Chinese legal tradition under the Mongols. The code of 1291 as reconstructed. Princeton. Princeton University Press. 1979. тал 4



“Засаг цаазыг номын ёсоор барьж

Олон амьтныг жаргаланд зохиож...” гэж буй. Онөөгийн бидний ойлгож хэрэглэдэг “хууль” гэдэг үг Манж-Чин улсын үед буюу XVII зууны эхэн үеэс *kooli*¹⁸ гэх үгнээс уламжлагдан хожим монголчуудын эрх зүйн соёл, сэтгэлгээнд нэвтэрсэн болохоор Монголын нууц товчоо бичигдэх үед хамаарахгүй юм. Харин хууль хэмээх үгийн утга, агуулга мөн чанарыг эхлээд цааз, Чингис хааны үеэс засаг(жаса-засах) хэмээх үг илтгэх болсон байна. “Цааз” болон “засаг” гэх үгс утга агуулга, мөн чанарын хувьдаа ойролцоо хэдий ч, ялгаатай байсныг Персийн түүхч Жувейний судалгаа ч нотолдог. Түүний бичвэрлэсэн “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” хэмээх шаштирт: “Цааз” хийгээд “Засаг” нь Чингис хаан өөрийн тархи толгойгоороо бүтээсэн зүйл, оюунаа зарж ном судар ашигласан ч юм бас биш цөм түүний ухаарлын үр, билиг сургаалийнх нь дээж байсан”¹⁹ хэмээжээ. Мөн засгийг зарлигтай адилтгаж яавч болохгүй юм. Энэ тухай Рахевильтз “Энэхүү засаг бол хааны хууль буюу төр улсын хууль мөн учир тэр нь “захирамж”(government), дүрэм(rule) хэмээсэн өргөтгөсөн утгыг илэрхийлж байна. Нэг буюу хэд хэдэн “зарлиг” нь хэрэв хаан тэдгээрийг тийм чухал гэж үзвэл “засгийн чанартай зүйл” мөн хэмээн авч үзэж болох юм. Хэдий тийм боловч засгийг зарлигтай адилтгаж хэрхэвч болохгүй, учир нь зарлиг, хэдийгээр түүнийг мөн хаан гаргасан боловч, үнэндээ засгийн адил хэм хэмжээний(normative) хүчин чадалтай байсангүй. Зарлигийг засагтай адил “дүрэм, захирамж” хэмээх утгаар хэзээ ч ойлгож болохгүй”²⁰ гэжээ.

Зарим судлаачид “засаг” хэмээх үгийн тухайд нэлээд эргэлзэж, харин эл үеийн монголчуудын хууль цааз хэмээх утгыг “ёс” хэмээн нэрийддэг байсан²¹ эсхүл ёс төр – засаг гэх ойлголтууд агуулга, мөн чанар, хууль зүйн хүчин чадлын хувьдаа адил түвшиний ухагдахуун болох тухай санааг дэвшүүлсэн²² нь нэн сонирхолтой боловч, арай ташаарсан байна. Энэ нь эртний монгол

¹⁸Б. Баярсайхан. Хууль зүйн тайлбар толь. УБ.2003. 199 дэх тал.

¹⁹Ata-Malik Juvaini.

The History of the World-Conqueror. Translated by J.A.Boyle.Manchester University Press. 1958.

²⁰Рахевильтийн гадигласан эх. Index to the Secret History of the Mongols. Bloomington. 1972. p 98

²¹Х.Тэмүүжин. Jus frat буюу Ёс үг. УБ.,2004. 47дахь тал.

²²Гарольд Лэмб. Дэлхийн эзэн Чингис хаан. УБ.,2003.55 дахь тал,Артүр Лундквист. Тэнгэрийн зарлигаар.

УБ.,2003. 81 дэх тал.



хэлэнд “засаг” гэдэг нь “цааз” болоод “ёс” хэмээх утгаар хэрэглэгдэж байсныг хожим Цахар гэвш Лувсанчүлтэм өөрөөр хөрвүүлснээс үүдэж, дээрхи судлаачид ташаарсан байж болох юм. Үлгэрлэвэл, Сажа бандид Гунгаажалцангийн зохиосон Эрдэнийн сан “Субашид” хэмээх сургаалийн XIV зууны үеийн Сономгарагийн орчуулгад “Аль хүн засгийг хөндвөөс л...” гэснийг XVIII зууны үед Цахар гэвш Лувсанчүлтэм “Аль хүн цааз ёсноос этгээд явбал” гэж хөрвүүлснийг эрдэмтэн судлаач Ш.Чоймаа тэмдэглэжээ.

Монголчууд эртнээс өөрсдийн хууль цаазын ерөнхийлсөн нэр болоод мон чанарыг “ёс”²³ хэмээх үгээр илтгэж байсан нь маргаангүй үнэн. Энэ тухай Монголын нууц товчоонд мэдээлснээр Чингис хаан Жүндүгийн алт, мөнгө эд агуурс, юмыг тоолуулахаар Онгүр буурч, Архай Хасар, Шихихутуг гурвыг илгээв. Эд гурвыг айсуй хэмээн Хада эсрэг угтан алтат артай агуурс бариад Жүндүгээс гарч угтан ирэв. Хадад Шихихутуг өгүүллүүн: “Урьд энэ Жүндүгийн эд мон Жүндү Алтан ханых ажгуу. Эдүгээ Жүндүү Чингис хааных буй за. Чингис хааны эд агуурсыг эчнээ яахин хулгайлж авчирч өгмүү чи. Би үл авна” хэмээж Шихихутуг эс авав. Онгүр буурч, Архай хоёр авав. Эд гурав Жүндүгийн эд юмыг тоолж ирэв. Тэнд Чингис хаан Онгүр, Архай, Шихихутуг гурваас “Хада юу өгөв?” хэмээн асуув. Шихихутуг өгүүллүүн: Алтат артай эд агуурс авчирч өглөө. Би өгүүллүүн: “Урьд энэ Жүндү Алтан ханых ажгуу. Эдүгээ Чингис хааных болов. Чи Хада Чингис хааны эд эчнээгээр хулгайлж яахан өгмүү чи? Хэмээж би эс авав. Онгүр, Архай хоёр өгснийг нь авлаа” хэмээв. Чингис хаанд тэнд Онгүр, Архай хоёрыг машид донгодов. Шихихутугийг “Их ёсыг сэтгэж чи” хэмээн машид соёрхож,²⁴ хэмээв. Гэвч энэхүү “Их ёс”-ын бичвэрлэгдсэн нь “Их засаг” болов уу. Тодруулбал, Рахевильтийн галигласан Монголын нууц товчоонд мэдээлснээр 1206 онд Тэмүжин Чингис хаан хэмээн өргөмжлөгдөх үедээ Татаарын Шихихутугт ийнхүү зарлиг болруун: “гүр иргэний хувь хувилгасаны жаргу(зарга) жаргулагсаны хох дэвтэр бичиг бичиж дэвтэрлэж, ургийн ураг хүртэл Шихихутугийн надтай эстэж(зөвлөж) ёслажу хөх бичиг цагаан цаалсунд дэвтэрлэсэнийг бүү юүтгэтүгэй(өөрчилтүгэй), юүтгэхүн(өөрчилсөн) харан алдалтан(гэмтэн) болтугай”²⁵ хэмээснийг

²³Ёс гэдгийг юмны зайлшгүй зүй тогтол хийгээд хүний дагаж баримтлах хэн хууль, журам, зарчим, зан суртал” хэмээн Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар тольд тайлбарласан ажгуу.

²⁴Монголын нууц товчоо.Д.Цэрэнсодном. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. УБ.,2000. 166 дахь тал.

²⁵Рахевильтийн галигласан эх. Index to the Secret History of the Mongols. Bloomington. 1972. p 116



нягталвал, “ёс”-ыг бичвэрлэсэн болох нь тодорхой байна.

Үүний зэрэгцээ энэхүү бичмэл хуулийг “ёс” биш “засаг” хэмээн нэрийддэг байсан нь дараахь баримтуудаар нотлогддог. Тухайлбал, Чингис хаан зарлиг болж тургуудын дөрвөн ээлжийн ахлаачдыг тушаахдаа: “Засаг хөндвөөс надад зааж өгөгтүн. Мөхөөх ёстой бөгөөс бид мөхөөе. Балбах ёстой бөгөөс хэвтүүлж балбая. Ахлав гэдгээр сацуу(эрхт) хэшигтэнийг минь өөрийн гар хөл хүргэж бэрээдвээс бэрээний хариуг бэрээгээр, нударганы хариуг нударгаар хариултугай хэмээв”²⁶ гэсэн бол Монгол нууц товчоонд мэдээлснээр Огэдэй хаан зарлиг болруун: “Засаг хөндвөөс бидэнд хэлтүгэй. Алах ёстой бөгөөс бид мөхөөрүүлье. Гэсгээн ёстой бөгөөс бид шийтгэе”²⁷ хэмээжээ. Тэгэхлээр, монголчуудын язгуур сэтгэлгээ тэр дундаа Монголын нууц товчоо хэмээх судар бичигт өгүүлэх “Засаг” хэмээх ойлголт нэг талаас тогтсон хэв ёс, заншлыг хамгаалсан горим журам, нөгөө талаас хүмүүний даган баримтлах ёсны норматив илэрхийлэл болохын хамтаар нүүдэлчдийн дунд олон жил бичигдмэл бус байдлаар мөрдөгдөж байсан эрх зүйн эх сурвалжууд (зарлиг, хэв ёс, цааз)-ын эмхтгэл байжээ хэмээн үзэж болохоор байна.

²⁶Монголын нууц товчоо Д.Цэрэнсодном. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. УБ.,2000. 149 дэх тал.

²⁷Мөн тэнд. 187 дахь тал.



**"ЭЦЭГ ЭХИЙНХЭЭ СЭТГЭЛД ХҮРСЭН
ҮРГЭЛЖЛЭЛ НЬ БАЙХ ЮМСАН"**



Хүн бүхэн өөрийн зурсан зураг, төрсөн төөрөгтэй. Хүний хувь заяа өөрийн гар хүрэх газар оршдог ч гэж ярилцдаг. Бас өөрөө өөртөө, хувь заяандаа эзэн болохын утга учрын тухай өтгөсгийн хууч яриа ч их бий. Энэ үгний учрыг ухааран ойлгож хувь заяандаа эзэн болж яваа нэгэн бүсгүйн тухай өгүүлье. Энэ бүсгүй бол Монгол улсын Үндсэн хуулийн иэцийн гишүүн, МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн багш, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төслийн удирдагч, доктор, профессор Ц.Сарантуяа юм.

Цэрэнбалтавын Сарантуяа хуульч мэргэжлээр хорь гаруй жил ажиллаж байна. Тэрбээр Воронежскийн Улсын их сургуулийн хуулийн факультетийг төгсөөд Нийгмийн ухааны институтэд эрдэм шинжилгээний ажилтнаар орж хуульчийн гараагаа эхлэн улмаар МУИС-д багшлан, өөрийн сурсан мэдсэнээ одоо ч шавь наргаа хүртээсээр явна.

Ц.Сарантуяа удам дагасан хуульч. Түүний аав Д.Цэрэнбалтав өөрийн амьдралаа Монгол улсын шүүхийн байгууллагын ажил үйлсэд зориулсан ахмад хуульч, ахмад дайчин хүн. Аав нь хуульч болохоор Сарантуяаг хар бага байхаас л тэдний гэрт хуулийн сэдэвтэй дотоод, гадаадын хэвлэл, сонин, ном тасарна гэж үгүй. Тэр бүхнийг охин нь сонирхон уншина. Аавыг нь шударга сайн хуульч хэмээн хүмүүс хүндэлнэ. Эдүгээ түүнийг Цэрэнбалтавын



гэхээсээ Цэцийн Сарантуяа гэгцгээдэг. 1992 оноос эхлэн МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутнуудад “Үндсэн хуулийн процессийн эрх зүй” хичээлийг заахын зэрэгцээ 1994-1995 онд Монгол улсын Үндсэн хуулийн цэцэд түшмэл, 1998-2001 онуудад Монголын худалдаа аж үйлдвэрийн дэргэдэх Гадаад худалдааны арбитраж арбитрч, 1999–2001 онуудад Үндсэн хуулийн цэцэд зөвлөх, 2001 оноос өдгөөг хүртэл Цэцийн гишүүнээр ажиллаж байна.

Энэ их ажлын хажуугаар шавь нартаа зориулан олон ном бичиж хэвлүүлсэн. Тухайлбал: “Монгол улсын тор эрх зүйн үндэс” хамтарсан бүтээл, “Төрийн ерөнхий онол” нэг сэдэвт бүтээл”, “Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ёс зүйн үндэс” зэрэг хэд хэдэн номыг нэрлэж болно. “Эргэцүүлэл” сэтгүүлийн ерөнхий редактороор ажиллаж, 50 гаруй өгүүдэл, нийтлэлийг нийтийн хүртгээл болгон хэвлүүлж, хууль, эрх зүйн тулгамдсан асуудлаар бичсэн олон илтгэлийг чуулга уулзалт, олон улсын болон үндэсний хэмжээний онол, практикийн бага хурлаар хэлэлцүүлжээ.

Ц.Сарантуяа 1992 оны шинэ Үндсэн хуулийг боловсруулах ажлын хэсэгт томилогдон Үндсэн хуулийн “Монгол улсын бүрэн эрхт байдал”, “Хүний эрх”, “Монгол улсын төрийн байгуулал”, “Монгол улсын Үндсэн хуулийн цэц” бүлгийг боловсруулах ажилд оролцсон нь Үндсэн хуулийг бүтээхэд түүний оруулсан чухал хувь нэмэр юм. Одоо тэрээр бүтээсэн тэрхүү үнэт зүйлийнхээ торгон хилийн манаач буюу Үндсэн хуулийг хамгаалах ариун үйлсийн эгнээнд бусадтайгаа мөр зэрэгцэн өөрийн ачааг үүрсээр явна.

Ц.Сарантуяа “Хоолоо хувааж байж цаггалан, мөнгөө хувааж байж баян явна” гэсэн зарчмыг баримталдаг. Тиймдээ тэрээр мэдлэгээ олон түмэнтэйгээ хуваалцдаг нэгэн.

Сарантуяа нэгэн айлыг эхнээс нь аваад өдгөөг хүртэл ээж шиг нь авч явна. Энэ бол Ханнис-Зайделийн сан юм. Тус сан Монголд ажиллаж буй гадны олон байгууллагаас төслийнхөө удирдагчаар анхнаас нь монгол хүнийг ажиллуулж байгаа байгууллага. Магадгүй энэ шийдэл Сарантуяа докторын ажил хэрэгч, шударга чанар, өндөр мэдлэгтэй холбоотой байж болно.

1990-д оны эхээр тэрээр Германы эрдмийн солилцооны албаны



шугамаар Бонн, Хайдельберг хотноо давтан сургалтанд сууж байлаа. Энэ үед МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор профессор И.Дашнямаас нэгэн захидал хүлээн авчээ. Тэр нь Монгол улсад зохиогдох “Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл” сэдэвт олон улсын семинарт Германы эрдэмтдийг оролцуулах тухай урилга байв.

Энэ урилгыг гардуулахаар Сарантуяа Монгол улсаас ХБНГУ-д сууж байсан Онц бөгөөд бүрэн эрхэт элчин сайд ноён А.Цолмон болон Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга, ноён Б.Баярсайхан нартай уулзахад тэд “Конрад Аденауэрийн” сан Монголд үйл ажиллагаа явуулдаг учраас өөр байгууллага олох хэрэгтэй. Баварид Ханнс-Зайделийн сан гэж Монголд үйл ажиллагаагаа явуулдаггүй байгууллага бий гэжээ. Сарантуяа Ханнс-Зайделийн сантай холбогдон Олон улсын харилцаа, хамтын ажиллагааны институтын орлогч захирал Р.Бабелттай уулзах цаг авч Хайделберг хотоос шөнийн галт тэргээр Мюнхэн хот руу зорьжээ. Сангийн зүгээс түүнийг найрсгаар хүлээн авсны дараа олон улсын симпозиумын урилгын утга агуулгыг сайтар тайлбарлан өгчээ.

Ц.Сарантуяа нутагтаа ирээд нэлээд хугацаа өнгөрсний хойно Монгол улстай хамтран ажиллах боломжийг судлахаар хоёр Герман мэргэжилтэн ирэх тухай мэдээ хүлээн авчээ.

Тухайн үед “Ханнс-Зайделийн” сан Монгол гэж чухам ямар улс байдгий, тэр улс нь эрх зүйн ямар тогтолцоотой юм гэдгийг мэдэхгүй байсан нь мэдээж. Үүнээс хоёр жилийн дараа “Ханнс-Зайделийн сан” Монгол улсын эрх зүйн салбарт түүн дотроо нийтийн эрх зүйн салбарт дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам зөвшөөрчээ.

Энэ үе бол 1993-1995 он бөгөөд Монгол улс ардчилсан эрх зүйт төрийн тулгын чулууг тавьж байлаа.

Онөөдөр “Ханнс-Зайделийн сан” Монгол улсын Засгийн газартай байгуулсан хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, УИХ-ын тамгын газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль болон



Удирдлагын академтай тослийн түншлэгч байгууллагын хүрээнд хамтран үр бүтээлтэй ажиллаж байна. Энэ хугацаанд тус сан Монгол улсын хууль зүйн салбарт төсөл хэрэгжүүлэн нийт 20 гаруй хуулийг шинэчлэн найруулж боловсруулахад оролцоод байна.

Монгол улсад анх удаагаа дагнасан шүүх буюу Захиргааны хэргийн шүүх байгуулахад доктор, профессор Ц. Сарантуяагийн оруулсан хувь нэмэрийг үнэлж баршгүй юм. Түүнийг удирдагч багш нар нь туйлын өндөр үнэлж байсан гэдэг. Ажилдаа хичээнгүй, зорьсондоо хүрэх шаргуу хөдөлмөрч зан Германчуудын бахархлыг төрүүлжээ. Германчууд яс зантай, ажилдаа нэг минут хоцрохыг үздэггүй улс. Тийм улсад тоогдоно гэдэг Сарантуяагийн ямархуу эмэгтэй гэдгийг тодотгож байгаа хэрэг.

Сарантуяа ийм л бүсгүй. Монгол хүний сор болсон ухаалаг эмэгтэйчүүдийн нэг. Ээж хүний зөөлөн чанар, багш хүний шавийгаа хайрладаг сайхан зан чанар шингэсэн эмэгтэй гэж түүнийг хүмүүс хүндэлдэг юм билээ.

Төслийг нь боловсруулахад хамтран ажилласан хуулиудаа нэг мөр ойлгох, хэрэглэх үндсийг бүрдүүлэхийн тулд "Эрх зүйн боловсрол" академи байгуулах тухай Сарантуяагийн санал Ханнс- Зайделийн сангийн Мюнхен дэх төвийн дэмжлэгийг авч тус академи байгуулагдсанаар хот, хөдөөгийн хуульчид, төрийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтыг 4 дэх жилдээ хийж байна. Тиймээс ч түүнийг олон нийт "Ханнс-Зайделийн Сарантуяа" хэмээн өргөмжлөн нэрлэдэг юм.

Эрх зүйн тулгуур хуулиудын уг үндэс нь аль угсааны хуулийг баримталж байгаагаас хамааралтай. Манай улс Германы хуулийн үндсийг баримтлах нь зүйтэй гэдэгт хуульчид, гадаадынхан ч санал нэгтэй байдаг.

Хууль гэдэг нийгмийн хамгийн нарийн зохицуулалт. Цаг хугацаа урсахын хэрээр нийгмийн харилцаа өөрчлөгдөж байдаг. Тэгэхдээ хүний эрхийн хэзээ ч өөрчлөгдөшгүй чанаруудыг хуулинд суулгаж өгөх нь зайлбаргүй. Сарантуяа хуульч үүний төлөө ажиллаж байна.

Монгол улсын гавъяат хуульч, доктор, профессор Н.Жанцан хэлэхдээ "Үндсэн хуулийн цэцийн гишүүн Сарантуяаг би олон жилийн өмнөөс мэднэ. Түүнтэй олон жил хамтран ажиллаа. Сарантуяа өөрийгөө боловсруулахын



төлөө цаг үргэлж тэмцдэг, ажил хэрэгч, хийж байгаа ажилдаа тун үнэнч эмэгтэй. Сарантуяаг Үндсэн хуулийн цэцийн гишүүнийх нь хувьд үнэлбэл мэдлэгтэй бөгөөд шударга шүүгч. Түүнд хөндлөнгөөс нөлөөлнө гэж бодохын ч хэрэггүй. Түүнийг багшийнх нь хувьд үнэлбэл хичээлээ зааж чаддаг багш. Дүгнэж хэлбэл тэрээр Монголын төрд хэрэгтэй боловсон хүчин” гэсэн юм. Энэ бол илүү дутуу, уран сайханчилсан, хоосон магтаалын үнэлэлт биш. Ерөөсөө Сарантуяаг энгийн үнэн үгээр тодорхойлсон нь энэ.

Ц.Сарантуяагийн хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас өндрөөр үнэлж “Алтан гадас одон”, “Хөдөлмөрийн хүндэт медаль”, “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан”, “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдэг—ээр тус тус шагнажээ. Тэрээр хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн хүн.

“Эцэг эх ах дүүсийнхээ хувьд сэтгэлд нь хүрсэн үргэлжлэл нь байх юмсан” хэмээн бодон санаж, зүтгэж яваа Сарантуяа “Дэлхий бол нэг гэр бүл, тиймээс хэнийг ч ялгаварлах хэрэггүй. Хүн болгон бурханлиг учраас хүн бүрийг хүндэтгэх хэрэгтэй” гэж шавь нартаа сургадаг.

Тэрээр өөрийн хүү болон оюутнуудаараа бахархдаг. “Оюутнууд маань өндөр мэдлэгтэй болж байгаа нь миний хамгийн том бахархал” гэж үздэг. Түүнийхээр “Бэрхшээл бол бурхнаас илгээсэн ухаарал” гэж боддог.

Чөлөөт цагаараа аль болох гэртээ байж өвөрмөц хоол хийж гэрийнхэнтэйгээ хамт зооглох дуртай. Сарантуяа маань орос, англи, герман хэлийг чөлөөтэй эзэмшсэн бүсгүй. Тэрээр Оросын зохиолчдоос Пушкин, Лермонтов, Некрасов, Есениний урт шүлгүүдээс цээжээрээ мэднэ. Ямарч хүн хэн байх нь хамаагүй, төрсөн нутаг эх орныхоо ачийг хариулах хэрэгтэй гэж үргэлж санаашрана.

Сонгодог хөгжим сонсох дуртай тэрээр Чайковский, Бетховен, Моцарт, Шуберт, Шумани нарын бүтээлийн арвин баялаг цуглуулгатай. Байгалийн үзэсгэлэнт газруудаар явган аялах дуртай, нарны энергийг өөртөө шингээх дуртай бөгөөд 6-р ангиасаа хойш үлгэрийн баатруудын дүрс цуглуулж өрөөгөө чимэглэж, сайн чанарын үзэг цуглуулах хоббитой.



Үндсэн хууль бол төрийн өндөрлөг. Түүний манаанд Үндсэн хуулийн цэц зогсож байгаа гэж Үндсэн хуулийн олон удаагийн лекц, хурал, уулзалтууд дээр сонсогдож байсан агаад ийм үгийг оюун ухааны багш Цэрэнбалтавын Сарантуяа хэлж байлаа. Сарантуяа бол ийм үзэл санаагаа бүрэн хэрэгжүүлсэн багш хүн. Түүгээр ч барахгүй төрийн нурууг түшилцэж Монгол улсын олон хууль тогтоомжийг шинэчлэн найруулж боловсруулахад өөрийн нөр их зүтгэлээ оруулж буй манай шилдэг хуульч эмэгтэйчүүдийн нэг билээ.

*Хууль зүйн ухааны магистр,
Нийхихутуг ХЗДС-ийн багш Ц.Ундармаа*



ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮН ГЭЖ ХЭН БЭ?



*Омгөөлөгч, хууль зүйн ухааны
магистр М.Алтан-Өлзий*

Монгол улс зах зээлийн нийгмийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжсэн тэр цаг үеэс нэг талаас, банк санхүү, зээлийн харилцаанд нийгмийн масс оролцох хүсэл зориг, сонирхол, шаардлага өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, нөгөө талаас, хууль тогтоох байгууллага энэ харилцааг нийгэмд аль болох ашигтай хувилбараар зохицуулах зорилгоор шинээр хууль батлах, боловсронгуй болгох замаар оролцогч талуудад харилцан ашигтай, эрсдэл багатай байх нөхцөл боломжийг хуулиар зохицуулж ирсэн билээ. Үүний нэг илрэл нь 1998 оны шинэчилэн найруулсан Хоршооны тухай хууль гэж ойлгож болно.

Шинэчилэн найруулсан Хоршооны тухай хууль үйлчлэх болсон нь нийгэмд ад үзэгдэж байсан ломбардын замбараагүй, бараг зохицуулалтгүй үйлчилгээг халах үндэс болж, түүний оронд Хадгаламж Зээлийн Хоршоод их л хүчтэйгээр түрэн гарч ирж, ард иргэдийнхээ жижиг бизнесийн хэрэгцээг зарим талаар ханган ажиллаж байгаа сайн талтай ч, үйл ажиллагааг нь зохицуулж байгаа Хоршооны тухай хуулийн үндсэн санаа, агуулга, хууль санаачлагчийн үзэл баримтлалыг санаатайгаар гажуудуулж, явцуу эрх ашгийн хүрээнд өөрөөр хэлбэл үүсгэн байгуулсан хэдэн хүн, компанид санхүүгийн ашигтай нөхцөл байдал бий болгож, тэдний бизнэсийн хэрэгцээ, шаардлагыг хангах хэрэгсэл болсон нь нийтлэг шинжтэй байна.



Оөрөөр хэлбэл гишүүдийнхээ нийтлэг ашиг сонирхолыг дэмжиж ажиллах зорилготой Хоршоо маань реклам, зар сурталчилгаа, албан бус зуучлагчаар дамжуулан иргэдийг хэлбэрийн төдий гишүүнээр элсүүлсэн дүр эсгэж, тэдний эргэлтийн хөрөнгийг төвлөрүүлэх зорилготой “машин” болж хувираад байна.

Үүнээс харахад Хадгаламж зээлийн хоршоод нь гишүүдийнхээ нийтлэг ашиг сонирхолыг дэмжиж ажиллахгүй байна, гишүүдээ зохих ёсоор бүртгэлд хамруулахгүй байна, хуулиар хориглосоор байхад үндэслэл муутай хүү амласан реклам, зар сурталчилгаагаар иргэдийг татаж эргэлтийн хөрөнгө хуримтлуулж байна, төвлөрүүлсэн хөрөнгөө гишүүдийнхээ нийтлэг ашиг сонирхол, хэрэгцээнд зориулахгүй, зөвхөн үүсгэн байгуулсан хэдэн хүний бизнесийн санхүүжилт болгож байна гэх мэтчилэн олон асуудал гарч ирж байна.

Гэхдээ эдгээрээс Хадгаламж зээлийн хоршоо шинээр гишүүн элсүүлэх, тэднийг бүртгэх байгууллагад бүртгүүлэхтэй холбогдсон асуудал нь практикт ихээхэн маргаантай байгаа бөгөөд, үүнийг нэг мөр ойлгохгүй, шүүхийн зөв практик тогтоохгүй тохиолдолд Хадгаламж зээлийн хоршоо талаасаа ч тэр, шинээр элссэн гишүүд талаасаа ч тэр ихээхэн эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна. Энэ ч утгаар сүүлийн үед Хадгаламж зээлийн Хоршоо дампуурлаа, хадгаламж эзэмшигч гишүүдийнхээ хадгаламжийг үрэгдүүлж, завшсан байна, шалгах явцад гишүүд нь бүртгэлгүй байна гэдэг асуудал ихээхэн гарах болсон байна. Иймд шинээр гишүүн элсүүлэх, бүртгүүлэхтэй холбоотой асуудлын талаар санал бодлоо хэлэхэд...

Нэгэнт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хувьд дагаж мөрдөх, биелүүлэх, хэрэгжүүлэх гэсэн ойлголт л байх нь зүйн хэрэг. Гэхдээ амьдрал дээр ихээхэн зөрүүтэй ойлголт байгаагийн зэрэгцээ Хоршооны зүгээс явцуу эрх ашгийн үүднээс холбогдох хууль тогтоомжоо санаатай буюу болгоомжгүйгээр дагаж мөрдөж биелүүлэхгүй байгаа тохиолдолд, хууль хэрэгжүүлэгч субъект болох шүүх түүнийг яаж ойлгож, тайлбарлаж байна гэдэг нь практик талаасаа ихээхэн ач холбогдолтой юм.

Хадгаламж зээлийн хоршооны зээл, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой аливаа маргааныг шүүхийн шатанд хянан шийдвэрлэх явцад



талууд тухайн хуулийн зарим заалтуудын талаар зарчмын зөрүүтэй ойлгож, тайлбарлаж байгаа байдал нийтлэг байдаг. Тэр дундаа Хадгаламж зээлийн хоршооны гишүүнчлэлийн асуудал ихээхэн маргаантай байдаг бөгөөд энэ талаар одоогоор албан ёсны ямар нэг тайлбар байхгүй байна.

Хоршооны тухай хуулийн 48².1-д “Хоршоо нь өөрийн гишүүнээс мөнгөн хөрөнгийн хадгаламж авч болно, ингэхдээ Иргэний хуулийн 454-456 дугаар зүйлд заасны дагуу бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр мөнгөн хөрөнгө хадгална, хадгаламж дахь хөрөнгийг зөвхөн хоршооны зээлийн сангийн эх үүсвэр болгон ашиглаж болно”, 48³.1-д “Зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь гишүүндээ хоршооны зээлийн сангийн хөрөнгөнөөс дүрэмд зээсэн журмын дагуу зээл олгоно” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл Хадгаламж зээлийн хоршоо нь хуульд зааснаар зөвхөн гишүүддээ л үйлчлэх ёстой өөрийн гэсэн онцлогтой хуулийн этгээд юм.

Иргэний хуулийн 56.1.9-д “хуулийн этгээд үйл ажиллагааныхаа үндсэн зорилгыг зөрчиж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна” гэж заасан байдаг. Үүнийг Хоршооны тухай хуультай уялдуулан тайлбарлавал Хадгаламж зээлийн хоршоо нь зөвхөн гишүүддээ зээл олгож, гишүүдээсээ л хадгалмж авах эрхтэй гэсэн дүгнэлт гарч байна. Бусад тохиолдолд буюу гишүүн биш этгээдтэй хадгаламж, зээлийн үйлчилгээний талаар ямарваа хэлцэл хийсэн байвал тэр нь Иргэний хуулийн 56.1.9-д зааснаар хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцогдох үндэс болж байна. Энэ бол Хадгаламж зээлийн хоршооны гишүүнчлэлийн асуудлыг хурцатгаж байгаа хамгийн гол хууль зүйн үндэслэл.

Хоршооны гишүүн гэдэг бол Хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар:

- Гишүүний зүгээс - тухайн хоршооны дүрмийг хүлээн зовшөөрсөн
 - гишүүнээр элсэхийг хүссэн өргөдлөө Тэргүүлэгчдэд гаргасан
- ХЗХ-ны зүгээс - дүрмэнд өөрөөр заагаагүй бол гишүүнд элсүүлэх асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэсэн
 - гишүүнээр элсэхийг хүссэн өргөдөл, гишүүнээр элсүүлсэн тухай шийдвэрийг нь бүртгэх байгууллагад бүртгүүлнэ... гэжээ.



Гэтэл ихэнх тохиолдолд Хадгаламж зээлийн хоршоо шинээр элсэж байгаа гишүүний өргөдлийг бланкаар авдаг, түүнийг элсүүлэх асуудлыг шийдвэрлэсэн эсэхээ хариу мэдэгддэггүй, шинээр элссэн этгээдийн өргөдөл, элсүүлсэн тухай шийдвэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлдэггүй гэсэн нийтлэг зөрчил гаргадаг бөгөөд үүнийгээ зөвтгөх үүднээс Хоршооны хууль амьдралд нийцэхгүй байна гэж тайлбарлаж байгаа нь явцуу эрх ашгийн үүднээс хийж байгаа тайлбар бөгөөд маргааны гол үндэс болдог байна.

Татварын срөнхий газрын бүртгэлийн алба, энэ талаар Хадгаламж зээлийн хоршоод үүсгэн байгуулсан гишүүдээ бүртгүүлчихээд, шинээр элссэн гишүүдээ ихэнх тохиолдолд бүртгүүлдэггүй гэсэн тайлбарыг хийдэг.

Шүүхийн практикаас харж байхад Хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан заалтууд нь захирамжилсан шинжтэй биш, харин журам тогтоосон шинжтэй, өөрөөр хэлбэл Хадгаламж Зээлийн Хоршооны зүгээс гишүүний өргөдөл, түүнийг элсүүлсэн тухай шийдвэрийг бүртгэх байгууллагад бүртгүүлэх асуудлыг үүрэг болгоогүй гэсэн тайлбар хийж, энэ нь шүүхээс гарч байгаа шийдвэр, магадлал, тогтоолд тусгалаа олсоор байна.

Гэтэл бодит байдал дээр Хадгаламж зээлийн хоршоо маань нэг хэсэг буюу үүсгэн байгуулсан гишүүдээ бүртгэх байгууллагад бүртгүүлчихээд шинээр элссэн гишүүдээ бүртгүүлэхгүй байгаа нь нийтлэг шинжтэй байна. Өөрөөр хэлбэл Хадгаламж Зээлийн Хоршооны бүртгэлтэй гишүүд, бүртгэлгүй гишүүд гэсэн 2 ойлголтыг өөрийн эрхгүй төрүүлж байгаа болно. Үүнээс харахад эдгээр заалтуудыг маш зөв тайлбарлах нь онолын болоод, практикийн ихээхэн ач холбогдолтой асуудал болох нь харагдаж байна.

Амьдрал практик дээр гарч байгаа хэрэг маргааныг шийдвэрлэх явцад дүгнэлт хийхэд Хадгаламж зээлийн хоршоод нь бүх гишүүдээ Татварын ерөнхий газрын бүртгэлийн албанд бүртгүүлж байх ёстой. Үүний тулд...

- Гишүүнээр элсэх хүсэлт гаргасан этгээд тухайн хоршооны дүрэмтэй нэгд нэгэнгүй танилцах буюу ойлгохгүй байвал хоршооны зүгээс тайлбарлаж огох, танилцсан талаар болон дүрмийг хүлээн зөвшөөрч байгаа талаар элсэх өргөдөлдөө дурьдаж, өргөдлөө өөрийн гараар бичгээр үйлдсэн байх:

- Хоршооны зүгээс элсэхийг хүссэн этгээдийн өргөдлийг хүлээн авч, ямарч тохиолдолд бүх гишүүдийнхээ хурлаар буюу дүрмэндээ заасан бол



Тэргүүлэгчдийнхээ хурлаар шийдвэрлэж, элсүүлсэн гэж шийдвэр гаргасан тохиолдолд түүнийгээ, шинэ гишүүний өргөдлийн хамт Татварын ерөнхий газрын бүртгэлийн албанд бүртгүүлэх зэрэг үйлдлүүдэд ач холбогдол өгч байвал зохино.

Гишүүний бүртгэл нь гишүүнийг эрх зүйн үүднээс баталгаажуулах зорилготой бөгөөд мөн тухайн Хадгаламж зээлийн хоршооны талаарх мэдээллээр Бүртгэлийн алба сонирхсон эдгээдийг хангах зорилготой байдаг.

Ингэж Хадгаламж зээлийн хоршооны гишүүнчлэлийн асуудлыг нэг мөр ойлгож, дагаж мөрдөж ажиллах нь нэг талаар Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны болон гишүүдийн эрсдлийг багасгаж, тогтвортой үйл ажиллагааг хангахаас гадна, тэдгээрийн хадгаламж, зээлийн үйл ажиллагаатай холбогдож гарсан маргаан шүүхээс омнох шатанд шийдвэрлэгдэх ихээхэн ач холбогдолтой байгаа нь харагддаг.



ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Омгөөлөгч М.Алтан-Олзийгийн дараах хууль зүйн зөвлөгөөг нийтлэв. Түүний мэргэшсэн чиглэл бол гэрээний эрх зүй, үл хөдлөх эд хөрөнгө, зээл, эд хөрөнгийн болон барьцааны эрхийн хэрэг маргаан юм.

Иргэн: Би 2 сарын өмнө таксигаар зорчин явж байгаад замын тээврийн осолд орж, тухайн үедээ хүнд гэмтэл авч эмнэлэгт хүргэгдэн эмчүүлсэн. Миний явсан такситай мөргөлдсөн машины жолооч нь цагдаагийн ажилтан байсан бөгөөд тэрээр тухайн үедээ согтуу байсан эсрэг урсгалруу орж ирж мөргөлдсөн учир түүний буруу болох нь ойлгомжтой байсан. Замын цагдаагийн газраас хүмүүс ирж хэмжилт хийж байсан. Осол гаргасан жолооч буюу тэр цагдаагийн ажилтан бидэнтэй тохиролцоё гэж хэлж ярьж байсан боловч намайг эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байх хооронд жолоочтой тохирч асуудлаа зохицуулчихаад харин миний хохирлыг өнөөдрийг хүртэл барагдуулаагүй байна. Одоо би яаж хохирлоо барагдуулах вэ?

Хуульч: Авто ослын улмаас таны бие махбодид хүнд гэмтэл учирсан нь шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон бол энэ үйлдлийг зайлшгүй эрүүгийн хэрэг үүсгэж шалгах ёстой. Нэгэнт хохирогчийн эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан бол талууд харилцан тохиролцож хохирлын асуудлаа шийдвэрлэх нь учир дутагдалтай. Учир нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зорчсоний улмаас хүний бие махбодид хүнд гэмтэл учруулсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215.2-т заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулж байдаг.

Дээрх ослыг үйлдсэн жолооч нь цагдаагийн байгууллагын ажилтан байсан бол энэ хэргийг Замын цагдаагийн хэрэг бүртгэх алба биш харин Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгаж, шийдвэрлэх ёстой.

х х х

Иргэн: Би таньдаг хүндээ ихээхэн хэмжээний мөнгө хүүтэй зээлдүүлж, түүний өмчлөлийн 5 өрөө орон сууцыг барьцаалах гэрээ хийх гэсэн юм. Гэрээг хийхэд юуг анхаарах нь зүйтэй вэ?

Хуульч: Иргэний хуулиар иргэд хооронд хүүтэй зээлийн гэрээ



байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангах арга болгож барьцааны гэрээ байгуулах зэрэг нь ихээхэн тохиолддог боловч дараахь хэдэн зүйлд таныг анхаарахыг хүсэж байна.

Юуны өмнө зээлийн болон барьцааны гэрээнүүдээ бичгээр байгуулахын зэрэгцээ барьцаанд бариулах гэж байгаа орон сууцны насанд хүрсэн хамтран өмчлөгч нар зөвшөөрөл өгөх эсэхийг мэдэх ёстой. Барьцааны гэрээнд талуудын нэр, оршин суугаа болон оршин байгаа газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана.

Барьцааны гэрээг бичгээр байгуулсны дараа танд барьцаанд бариулж байгаа тухайн орон сууцны насанд хүрсэн хамтран өмчлөгч нарын зөвшөөрлийг бичгээр авах ёстой. Ингэхдээ зүгээр нэг нотариат дээр аваачаад гарын үсэг зуруулах нь хангалтгүй. Учир нь хамтран өмчлөгч нар хэрвээ зээлдэгч зээлийн гэрээнийхээ үүргийг хугацаандаа гүйцэтгэж чадаагүй тохиолдолд барьцаалж байгаа орон сууцны өөрт ноогдох хувиа зээлдэгчийн үүргийн хувьд баталгаа болгож барьцаалж байна гэдгийг тодорхой бичсэн, тэгж ойлгож байвал зохино. Ийм тодорхой ойлголт байгаагүйгээс шалтгаалж зээлдэгч зээлийн гэрээнийхээ үүргийг хугацаандаа гүйцэтгэж чадаагүйгаас гарсан хэрэг маргааныг шүүхийн шатанд шийдвэрлэхэд ихээхэн хүндрэл учирдаг.

Үүний дараа зээлийн болон барьцааны гэрээнүүдээ насанд хүрсэн хамтран өмчлөгч нарын зөвшөөрлийн хамт барьцаанд тавьж байгаа орон сууцны байрладаг дүүрэгт нотариатын үйлчилгээ үзүүлдэг нотариатаар гэрчлүүлж, улмаар Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын харьяа Эрхийн улсын бүртгэлийн албанд бүртгүүлснээр үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан барьцааны гэрээ буюу Ипотек хүчин төгөлдөр болно. Дээрх шаардлагуудыг хангаагүй тохиолдолд барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус болдог гэдгийг онцгой анхаарах нь зүйтэй.

Жич: Та бүхэн хууль зүйн зөвлөгөө авахыг хүсвэл
омгөөлөгч М.Алтан-Олзийгийн доорхи утсанд хандан уу!

Утас: 99191041

1916 “Хууль зүйн лавлах”



О.АМАРХҮҮ БАГШ ГАВЪЯАТ ЦОЛ ХҮРТЭВ

БНМАУ-ын анхдугаар Үндсэн хууль батлагдаж, улс тунхагласны 81 жилийн ойн баярын өмнөхөн тус сургуулийн тэнхимийн эрхлэгч, магистрын сургалтын албаны эрхлэгч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Осорын Амархүү багшид маань Монгол Улсын Ерөнхийлөгч “Монгол улсын гавъяат хуульч” хэмээх төрийн эрхэм дээл алдар цол хүртээн бид бүхнийг байрлуулав.



Эх болсон газар дэлхий, унаган байгаль, газар нутгаа дээдлэн шүтэж, хайрлан хамгаалахуйн учрыг зүрхэндээ шингээж, бүтээн туурвиж явдаг Амархүү багшийн туулж өнгөрүүлсэн, бүтээн цогцлуулсан, судлан шинжилсэн бүхнийг харахад “бахархан дуурайх үйлстэн” мөнөөс мон. Энэ хүний олон жилийн нөр их хөдөлмөрийг тоочин сийрүүлбэл нэлээд олон хуудас болох тул энэ удаад уншигчиддаа багшийн хийж бүтээсэн ажил хөдөлмөрийн талаар тоймлон хүргэе.

Амархүү багш 1962 оноос эхлэн төрийн хууль тогтоомжийг бүртгэн судалж ангилан системчлэх, хуулиуд хийгээд Засгийн газрын тогтоол, дүрэм



зааврын төсөл боловсруулж хэлэлцүүлэн батлах онол, практикийн нарийн түвэгтэй нүсэр ажилд 40 гаруй жил тасралтгүй хүчин зүтгэсний зэрэгцээ эрдэм ном, судалгаа, сургалтын эрхэм үйлст давхар хүчин чармайлт гаргасны үр дүнд өдгөө шинжлэх ухааны доктор, профессор хүргэл өсөн хөгжжээ.

О.Амархүү багшийн хуулийн мэргэжлийн чанар чансааг шалгасан нэг гол ажил бол хуулийн төсөл боловсруулах нэр хүндтэй ажил байв. Энэ чиглэлээр түүний хийсэн ажил өнгөрсөн нийгмийн үед ч, одоогийн үед ч нийгэм, улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн салбарын аль алиных нь өргөн ач холбогдотойг тэмдэглэх нь зохистой.

Сүүлийн 10 гаруй жилд байгаль орчны үйлст олон нийтийн хүсэлт, сонгуулиар дагнасан хүчин чармайлт гаргаж Монголын байгаль орчныг хамгаалах холбооны ерөнхийлөгчөөр хоёр удаа сонгогдон ажиллахдаа Монголд Тахь сэргээн нутагшуулах сонирхолтой бөгөөд цоо шинэ ажлыг амжуулан хийсэн нь улс орны төдийгүй олон улсын анхаарлыг татах болсон юм.

Багш маань тор, олон нийтийн нор их ажлын зэрэгцээ хууль зүйн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун ухаанаа олон жил дайчлан ажиллаж зуу зуун шавь төдийгүй хэд хэдэн эрдэмтэн, судлаачдыг эрдэм номын аянд дорөөлүүлэн хөтөлсөөр яваа багш сурган хүмүүжүүлэгч билээ. Тэрээр 20 шахам ном зохиол, сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлсэн эрдэмтэн багш гэж зүй ёсоор нэрлэгдсээр явна.

Багшийн маань хөдөлмөр зүтгэл, бүтээл, үр дүнг төр засаг өндрөөр үнэлж Монгол Улсын Ерөнхийлөгч 2006 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 107 дугаар зарлигт: “Төрийн болон төрийн бус байгууллагад олон жил санаачлага үр бүтээлтэй ажиллаж хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдгээрийг системчлэн эмхтгэж судлан шинжлэх, байгаль хамгаалах, хуулийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч Осорын Амархүүд Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээсүгэй” хэмээн заан тэмдэглэжээ.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Монгол Улсын гавьяат хуульч Осорын Амархүү багшдаа урт насалж улам ихийг бүтээж, мөнгөл эрдэмтний оюун суут, сэцэн билигт үйлээ түгээн дэлгэрүүлж явахын өлзий билигт сроөлийг өргөн дэвшүүлье.

Багш Б.Бат-Ерөөлт



ШИХИХУТУГИЙН ХӨШӨӨ СҮНДЭРЛЭЛЭЭ

Монгол Улсын шинэ үндсэн хууль батлагдсан ойн өдөр Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн амьдралд онцлох үйл явдал болж өнгөрлөө. Энэ нь Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн захиргаа, төгсөгчдийн холбооноос



санаачлан зохион байгуулсан Монголын төр, хууль цаазны түүхэнд мөнхрөн үлдсэн, эзэнт гүрний их заргач Шихихутугийн сүрлэг, амгалан, тэргүүн бадрангуй хөшөөг нээсэн ёслолын ажиллагаа юм. Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Д.Жанцанноровын “Монгол аялгуу”-г морин хуурчид эгшиглүүлэн эхэлсэн уг ёслолын ажиллагааг нээж Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн захирал, дэд профессор Д.Оюунцэцэг үг хэлэв. Тэрээр хэлсэн үгэндээ Монголын түүх шаштитр Шихихутугаас өөр нэг ч монгол хүн цааз эрхэмжийн номлол, дэг сургуулиа дэлхий дахинд хүлээн зөвшөөрүүлж

байгаагүй юм гээд Шихихутугийн үйл хэргийг нэр төртэй үргэлжлүүлэхийн тулд сургуулиа орчин цагийн сургалтын түвшинд ойрын үед хүргэх их зорилгыг өвөрлөн эхний алхам болгон цахим сургуулийн хэв төрхөд оруулж, бүхий л үйл ажиллагаагаа дотоод сүлжээнд холбож, багш, суралцагсад интернетээр мэдээлэл авах бүрэн бололцоо нээгдлээ гэж онцлон тэмдэглэв. Дараа нь Монгол Улсын Шинжлэх ухааны академийн академич Ж.Болдбаатар Шихихутугийн амьдрал, тэмцэл, түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар сонирхолтой илтгэл тавив.

Энэхүү ёслолын ажиллагаанд хүндэт зочидоор Улсын Их Хурлын дэд дарга, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын гавьяат хуульч Б.Цэрэндорж, Их Монгол улс байгуулагдсний 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үндэсний комиссын ерөнхий зохицуулагч



Б.Гарам-Очир, МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн дэд захирал Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж, Монголын их, дээд сургуулиудын холбооны тамгын газрын дарга Д.Авир зэрэг хүмүүс оролцов. Үүний зэрэгцээ Шихихутуг хууль зүйн дээд сургуультай хамтран ажилладаг байгууллага хамт олны зочид, төлөөлөгч нар олноор хүрэлцэн иржээ.

Энэ үеэр Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Шихихутуг Хууль зүйн дээд сургуулийн эчнээ салбарын эрхлэгч С.Оюунбилэгийг “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, багш Б.Бат-Ерөөлт, Төгсөгчдийн холбооны дарга Н.Одон нарыг “Хууль зүй, дотоод хэргийн яамны хүндэт жуух” бичгээр тус тус шагнав.

Шихихутугийн хөшөөг төрнийн дархан Б.Даваа, Соелын тэргүүний ажилтан О.Батцэнгэл, уран барималч Т.Мандир нар урлан бүтээжээ.

Ийнхүү Монголд анх удаа Чингис хааны есөн өрлөг жанжны нэг Шихихутугийн хөшөө тус сургуулийн хичээлийн байранд сүндэрлэн боссон нь Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээнүүдэд тус сургуулиас оруулж буй хувь нэмрийн нэг болов

СУРГУУЛИЙН МЭДЭЭЛЭЛ

- Шихихутуг ХЗДС нь “MAGIC PR” судалгааны төв, “TV-9” телевизээс 2005 онд бүх ард түмний дунд зохион байгуулсан “Mongolian-TOP” шалгаруулах санал асуулгын дүнгээр Монгол улсын Их Дээд сургуулиудаас Монголын TOP-3 сургуулийн нэгээр шалгарч нийт эрдэмтэн багш, оюутан залуучууддаа улам ихийг бүтээх урам зориг хайрласан тэмдэглэлт үйл явдал боллоо.
- Шихихутуг ХЗДС-ийн багш Б.Бат-Ерөөлт Монголын Мэтгэлцээний Нэгдсэн Ассоциациас 2005 оны “шилдгийн шилдэг шүүгч”-ээр шалгарав.
- Энэ хичээлийн жилд “Цахим сургууль” болох зорилт дэвшүүлэн хэд хэдэн томоохон ажлыг хийж гүйцэтгэлээ. Сургуулийн веб сайтыг хийн, дотоод үйл ажиллагааг сүлжээний горимд шилжүүлэн компьютерийн лабораторыг шинэчлэж профессор багш, оюутнууд 24 цагийн турш интернетэд холбогдож мэдээлэл авах бүрэн бололцоо нээгдлээ. Энэ нь мэдээлэллээг түргэн шуурхай авах, сургуулийнхаа эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой боллоо.



ШИХИХУТУГ ХУУЛЬЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬД 2006-2007 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Оюутан элсүүлэхэд Монгол Улсын БСШУ-ны сайдын 2005 оны 422-р тушаалаар баталсан журам болон энэ журмыг баримтална.

Нэг.Ерөнхий зохион байгуулалт

1.Оюутан элсүүлэх ажлыг 2 үе шаттай зохион байгуулна.

Шихихутуг ХЗДС-д элсэх хүсэлтэй иргэн энэхүү журмын 8-д заасан ерөнхий шалгалт /ЕШ/ өгнө. Хоёр дахь шатанд: ЕШ өгч энэхүү журмын 9-т заасан болзол хангасан иргэний өргөдлийг сургуулийн элсэлтийн комисс хүлээн авч, зохих хяналтын тоонд багтаан шалгаруулалт хийнэ.

2.Элсэгчдийн сурах ерөнхий мэдлэг чадварын түвшинг тогтоох зорилго бүхий ЕШ-ыг БСШУЯ-наас эрх олгосон хөндлөнгийн байгууллага зохион байгуулна.

3.Энэхүү журам болон элсэлтийн ажлын зохион байгуулалттай холбоотой нэмэлт мэдээллийг Шихихутуг ХЗДС-ийн вэб хуудас www.shihihutug.edu.mn, БСШУЯ-ны www.education.mn, Боловсролын Үнэлгээний Төвийн www.eec.mn портал сайтад тус тус байрлуулна.

4.Урьд нь дээд болон хууль зүйн тусгай дунд боловсрол эзэмшсэн хүнийг бакалаврын зэрэг олгох эчнээ сургалтанд суралцуулна. Эдгээр хүмүүс ерөнхий шалгалт өгөх шаардлагагүй. Эчнээ ангид элсэгчдийг 6 дугаар сарын 2-ноос 6 дугаар сарын 25-ныг дуустал бүртгэж, 7 дугаар сарын 1-ны дотор үндсэн хуулийн мэдлэг, гадаад хэл /орос, англи хэлийг сонгон/ шалгалт авна.

5.Хууль зүйн дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй хүнийг магистрантурын сургалтанд суралцуулна. Магистрантурт элсэгчдийг 9-р сарын 15-наас, 9-р сарын 28-ныг дуустал бүртгэж, мэргэжлийн суурь, англи хэлээр шалгалт авна.

6.Хоёр дээд сургуульд өдөр, орой хэлбэрээр зэрэг суралцах хүсэлтэй, бүрэн дунд боловсролтой иргэн ЕШ-ыг заавал өгнө.

Хоёр.Элсэгчдэд тавих шаардлага ба шалгалт

7.Шихихутуг ХЗДС-д элсэгч бүрэн дундаас доошгүй боловсрол эзэмшсэн байна.



8.Тус сургуульд элсэгч нийгмийн тухай мэдлэг,гадаад хэлний /англи, орос хэлний аль нэгийг сонгож өгнө./ ЕШ-ийг заавал өгсөн байна.

9.Дээрхн ерөнхий шалгалтын онооны нийлбэр нь авбал зохих нийт онооны 40-өөс дээш хувийг авсан байвал тус сургуульд элсэх болзол хангасан гэж үзнэ.

Гурав.Оргөдөл хүлээн авах

10.Шихихутуг ХЗДС-д элсэхийг хүсэгчдийн өргөдлийг 10-т заасан холбогдох материалын хамт Боловсролын үнэлгээний төвөөс авсан шалгалтын дүн гарсан өдрөөс эхлэн Шихихутуг ХЗДС-ийн дараах хаягаар хүлээж авна.

-Улаанбаатараас элсэхийг хүсэгчид өргөдлөө өөрийн биеэр Шихихутуг ХЗДС-ийн сургалтын албаны 402 тоот ороонд авчирч өгөх ба Хөдөө орон нутгаас элсэгчид өргөдлөө *Улаанбаатар. Их Сургуулийн гудамж-1, холбооны 46-р салбир, шуудангийн хайрцаг №1033, Шихихутуг ХЗДС-ийн элсэлтийн комисст* гэсэн хаягаар шуудангаар буюу оорийн биеэр, итгэмжилсэн хүнээр элсэлтийн комисст ирүүлнэ.

11.Бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

а.Оорийн гараар бичсэн өргөдөл Үүнд: өөрийн товч намтар, ам бүлийн байдал, эцэг эх хаана, ямар ажил эрхэлдэг, энэ мэргэжлийг сонгох болсон шалтгаан,сургалтын төлбөрийг хэн хариуцан төлөх, ямар ангид элсэх хүсэлтэй байгаа, энэ чиглэлээр уралдаан, тэмцээн, олимпиадад үзүүлсэн амжилт, ЕШ-ыг ямар хичээлээр хэдэн оноотой өгсөн тухайгаа бичиж, гарын үсгээ зурж буцах хаяг, холбоо барих гар утасны дугаар /УБ-т амьдардаг ах дүүс байж болно/ тодорхой бичнэ.

б. Боловсролын гэрчилгээний хуулбар

в.Иргэний үнэмлэхний хуулбар

г. Цээж зураг 2% /2006 оны/

д.Бүртгэлийн хураамж /2000 төгрөгийг Кредит банкин дахь Шихихутуг ХЗДС-ийн 2119005 тоот дансанд тушаасан орлогын мэдүүлэг/ Дорөв.Оюутан элсүүлэх шалгаруулалт

12.Шихихутуг ХЗДС-д Нийслэл болон Хөдөө орон нутгаас элсүүлэх оюутны тоог /хяналтын тоо/ БСШУЯ-наас тогтооно.



13. Тус сургуульд элсэх болзол хангагсадаас шалгаруулалт хийхдээ нийгмийн тухай мэдлэг, гадаад хэл /орос, англи/-ний ЕШ-ийн онооны нийлбэр дээр боловсролын гэрчилгээний дундаж оноог нэмж, онооны жагсаалт хийнэ.

14. Онооны жагсаалтаар хяналтын тоондоо багтаан шалгаруулж элсүүлнэ

15. Шалгаруулалтыг 07-р сарын 24-ны дотор хийж тэнцсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг Шихихутуг ХЗДС-ийн вэб сайтад /www.shihihutug.edu.mn/ тавьж одор тутмын сонинд нийтлэнэ. Ямар сонинд нийтэлснийг мэдээллийн хэрэгслээр зарлана.

Тав. Хөнгөлөлттэй нөхцөлөөр хангах

16. 2006 оны нийгмийн тухай мэдлэг болон гадаад хэлний олимпиадад аймаг, хот, улс болон дүүрэгт I-III байр эзэлсэн, тусгай шагнал хүртсэн хүнийг баримтыг үндэслэн онооны дараалал харгалзахгүйгээр шууд элсүүлнэ.

Зургаа. Элсэгчдийг бүртгэх

17. Онооны жагсаалт болон хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх болзол хангаж зохих хяналтын тоонд багтсан, сургалтын төлбөр төлсөн хүмүүст суралцах эрхийн бичгийг 7-р сарын 24-нөөс 28-нд олгоно.

18. Элсэгчид эрхийн бичиг авахдаа дараах материалыг бүрдүүлж ирнэ.

Үүнд:

а. Бүрэн дунд боловсролын үнэмлэх буюу түүнтэй адилтгах бичиг баримт /эх хувь/

б. ЕШ-ын дүнгийн тодорхойлолт

в. Сурагчийн хувийн хэрэг /ажиллагсад нийгмийн даатгалын дэвтэр/

г. Сургуулийн тодорхойлолт /2005, 2006 онд ЕБДС төгсөгчдөд хамаарна/

д. Иргэний үнэмлэх

е. Цээж зураг 4%

ж. Сургалтын төлбөр төлсөн баримт /Зээл авах, төрөөс хариуцах бол холбогдох бичиг баримтууд, төрийн албаны тухай хуулийн дагуу төлөгдох бол эцэг эхийн аль нэгний албан газартай хийсэн гэрээ/, материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийж ирүүлнэ.

19. Тус сургуульд элсэх шалгаруулалтад тэнцсэн хүмүүсийн бүртгэлийг



7-р сарын 28-аар тасалбар болгох ба дурьдсан хугацаанд суралцах эрхийн бичгээ аваагүй хүмүүсийг элсээгүйд тооцно.

20.Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн хүнийг Шихихутуг ХЗДС-д элсүүлэхгүй, элссэн тохиолдолд хасна.

Шихихутуг Хууль Зүйн Дээд Сургуульд

элсүүлэх журам

| д / д | Мэргэжлийн нэр | Сургалтын хэлбэр | Элсэгчдийн боловсролын түвшин | Суралцах хугацаа | Олгох боловсролын зэрэг |
|-------|--------------------|------------------|--------------------------------|-------------------------|-------------------------|
| 1. | Эрх зүйч | өдөр орой эчнээ | бүрэн дунд бүрэн дунд бакалавр | 4 жил 4 жил 3 жил | бакалавр |
| 2. | Бизнесийн эрх зүйч | өдөр орой | бүрэн дунд бүрэн дунд | 4 жил 4 жил | бакалавр |
| 3. | Эрх зүйч | өдөр | бакалавр | 1.5 жил | магистр |

ХАЯГ: Улаанбаатар хот Их Сургуулийн гудамж -1, СБД 6-р хороо, холбооны 46-р салбар, шуудангийн хайрцаг №1033

Утас: 323392, 320176-/элсэлтийн комисс/

320812, 99182624, 99147700

Факс: 323392



Хуулийн судлаач багш оюутнууд та бүхний гар дээр дараах шинэ ном бүтээл очиж байна. Оюун ухаанаа дайчилан оюуны хөрөнгө оруулалт хийсэн судлаачиддаа “Шихихутуг” шинжлэх ухааны онол, арга зүй, мэдээллийн сэтгүүл талархаж байна.



1. Д.Лүндээжанцан Л.Олзийсайхан “Парламентат ес” Энэхүү хамтын бүтээлийн зохиогчид нь энэ бүтээлээс өмнө хууль тогтоох байгууллага, түүний түүхэн хөгжил, хувьсал, хууль тогтоох процедурын онол-практикийн судалгаанд тулгуурлан нэг сэдэвт бүтээлийг туурвисан нь бий. Тэр бүхнээ гүнзгийрүүлэн хууль тогтоох байгууллага, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргээс илүүтэйгээр хуулийг чухам ямар байдлаар томъёолж, нийгэмд тулгарч буй ямар асуудлыг тусгах тухай хэлбэрийн бус агуулгын тал нь өдгөө нэгэнт тулгамдсан асуудал болсныг онцлон анзаарч энэхүү томоохон бүтээлээ Монгол орны төдийгүй дэлхий дахины олон улсын туршлага, жишигт нийцүүлэн туурвисан нь онол, арга зүй, практикийн хувьд илүү өргөн мэдлэг танд олгох зорилт тавьсан нь номын хуудас бүрээс харагдана гэдэгт итгэл төгс байна.



2. Н.Лүндэндорж “Төрийн онол” МУИС-ийн тэргүүлэх профессор, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд захирал, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж багшийн энэхүү бүтээл нь хууль зүйн шинжлэх ухааны мөнхийн судлагдахуун болох “төр”-ийн тухай, нарийвчилбал төрийг Үндсэн хуулийн байгуулал болох талаас нь суурь хэм хэмжээ, үнэт зүйл зарчимын үүднээс харуулан, гүн ухаан орчин цагийн онолын ололтод тулгуурлан тайлбарлан, нэгтгэн дүгнэсэн олзуурхууштай сурах бичиг болжээ. Энэхүү сурах бичиг Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Тэргүүн сурах бичиг”-ийн 2006 оны эрхэм дээд шагнал хүртэв.





3. Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн процессын эрх зүй”. Уг бүтээлийн зохиогч нь Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд тэрээр энэхүү практик мэдлэгээ онолын мэдлэгээр баяжуулан Үндсэн хуулийн шүүх, түүний үйл ажиллагааны зарчим, эрх хэмжээ, Үндсэн хуулийн шүүхийн хяналтын хэлбэр, Үндсэн хуулийн цэцээс хууль тогтоох ажиллагаанд “оролцох” хязгаар зэрэг үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлуудыг ижил төстэй гадаад орны Үндсэн хуулийн шүүхтэй харьцуулан авч үзсэн нь судалгаа, шинжилгээний ажилд илүү тохөмтэй, энэ чиглэлээр

гарсан анхны бүтээл болжээ. Таны судалгаа шинжилгээ, практикт багагүй туслалцаа үзүүлнэ гэдэгт итгэл төгс байна.



4. Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи” Гэмт хэргийн виктимологийн тухай энэхүү бүтээл нь гэмт хэргийн хохирогч судлалын онол, арга зүй, хохирогч хохирох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг олон улс орнуудын виктимологийн шинжлэх ухаан, практик, мэдлэг, мэдээлэлд үндэслэн криминологийн болон эрүүгийн эрх зүйн онолын талаас нь нээн харуулсан томоохон бүтээл юм.



5. Ц.Цэлмэг “Кримнологи” судлаачын эл бүтээл нь криминологийн шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох талаар шинэлэг санаа, үзэл бодлыг дэвшүүлэн тавьсан. Нэн ялангуяа монгол улсад үйлдэгдэж буй шинэ төрлийн гэмт хэргүүд, түүний шалтгаан урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасанаараа онцлогтой юм.

Бэлтгэсэн. багш Б.Бат-Ерөөлт

